

А.Алтанбагана, Х.Баярмаа, Ж.Гэрэлбадрах

# ТҮҮХ VII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
7 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Гурав дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он



DDC  
371.32  
Т-826

Түүх VII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 7 дугаар ангийн сурах бичиг. (Алтанбагана А., Баярмаа Х., Гэрэлбадрах Ж.; Ред. Баасандорж Ц., Пунцагсүрэн Д., -УБ., 2015. -150х)

Энэхүү сурах бичиг нь "Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99962-74-26-8

## ГАРЧИГ

### ӨМНӨХ ҮГ

#### I БҮЛЭГ. ДУНДАД ЗУУНЫ ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

- |   |   |
|---|---|
| 1.1. Дундад зууны түүхээр юу судлах вэ?     | 5 |
| 1.2. Дундад зууны түүхийг хэрхэн судлах вэ? | 8 |

#### II БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ӨМНӨХ МОНГОЛ (VI-XII ЗУУН)

- |  |    |
|--|----|
| 2.1. Монголчуудын нүүдэл, суурьшил       | 11 |
| 2.2. VI-XII зууны Монголын аймаг, улсууд | 13 |
| 2.3. Монголын Дарлигин, Ниругун аймаг    | 18 |
| 2.4. Монголчуудын ахуй амьдрал, соёл     | 20 |
| Бүлгийн дүгнэлт                          | 24 |

#### III БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ӨМНӨХ ДЭЛХИЙ ДАХИН (V-XII ЗУУН)

- |   |    |
|---|----|
| 3.1. Ард түмний Их нүүдэл ба вант улсууд      | 25 |
| 3.2. Франк улс байгуулагдаж, хүчирхэгжсэн нь  | 28 |
| 3.3. Дундад зууны Европын нийгэм (V-XII зуун) | 32 |
| 3.4. Загалмайтны шашин ба соёл                | 35 |
| 3.5. Викингүүд ба Европын улсууд              | 38 |
| 3.6. Византийн эзэнт улс                      | 41 |
| 3.7. Оросууд төр улсаа байгуулсан нь          | 46 |
| 3.8. Майя, Ацтек, Инк улс                     | 51 |
| Дэд бүлгийн дүгнэлт                           | 54 |
| 3.9. Лалын шашны үүсэл ба арабын ертөнц       | 55 |
| 3.10. Тан, Сүн улс                            | 59 |
| 3.11. Дундад зууны Энэтхэг                    | 63 |
| 3.12. Дундад зууны Япон                       | 66 |
| Дэд бүлгийн дүгнэлт                           | 69 |

#### IV БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН (XIII-XV ЗУУН)

- |   |     |
|---|-----|
| <b>4.1. ЧИНГИС ХААН БА МОНГОЛЫН ИХ ГҮРЭН</b>          |     |
| 4.1.1. Бидний мэдэх Чингис хаан                       | 70  |
| 4.1.2. Чингис хаан Их Монгол улсыг байгуулсан нь      | 74  |
| 4.1.3. Чингис хаан төр улсаа төвхнүүлсэн нь           | 79  |
| 4.1.4. Монголчуудын ахуй амьдрал, соёл                | 82  |
| 4.1.5. Чингис хаан Монголын их гүрнийг үндэслэсэн нь  | 87  |
| <b>4.2. МОНГОЛЫН ИХ ГҮРЭН БА ЭЗЭНТ УЛСУУД</b>         |     |
| 4.2.1. Өгэдэй хаан Монголын их гүрнийг төвхнүүлсэн нь | 91  |
| 4.2.2. Гүюг, Мөнх хаадын үеийн Монголын их гүрэн      | 96  |
| 4.2.3. Монголын Их Юань улс                           | 101 |
| 4.2.4. Монголын Алтан орд улс                         | 108 |
| 4.2.5. Монголын Цагадайн улс                          | 113 |
| 4.2.6. Монголын Ил хаант улс                          | 116 |
| Бүлгийн дүгнэлт                                       | 121 |

#### V БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ДЭЛХИЙ ДАХИН (XII-XV ЗУУН)

- |   |     |
|---|-----|
| 5.1. Феодалууд ба тариачид                          | 122 |
| 5.2. Дундад зууны Европын хотууд                    | 126 |
| 5.3. Загалмайтны сүмийн хүчирхэгжилт ба аян дайнууд | 129 |
| 5.4. Баруун Европ: тэмцэл ба нэгдэл                 | 135 |
| 5.5. Баруун Европын соёл                            | 142 |
| 5.6. Византийн эзэнт улсын мөхөл                    | 146 |
| Бүлгийн дүгнэлт                                     | 148 |

## ДУНДАД ЗУУНЫ ТҮҮХЭЭР ТАВТАЙ АЯЛНА УУ

Хүүхдүүд та бүхэн 6-р ангидаа хүний түүхийн эхлэл болсон эртний үеийг судалсан билээ. Одоо дундад зууны түүхийг судлах гэж байна. Уг түүхэн үе V-XV зууны хооронд 1000 орчим жил үргэлжилдэг. Энэ түүхэн үеийг судалснаар

- Монголчууд хүчирхэгжин агуу эзэнт гүрнийг байгуулж, дэлхийн бодлогыг тодорхойлох болсныг,
- Европт төр улсууд байгуулагдсаныг,
- Дэлхийн гурван гол шашин хэрхэн хөгжсөнийг
- Европт феодалын нийгэм хөгжиж, шашны нөлөө ихэссэнийг,
- Дэлхийн улс орнуудын эдийн засаг, шинжлэх ухаан, соёл хөгжсөнийг,
- Одоо цагийн ардчилал-парламентын эх үүсвэр тавигдсаныг тус тус мэднэ.

Та нар энэ түүхэн үеийн гол, сонирхолтой үйл явдлуудыг судлах явцдаа:

- Түүхэн үйл явцын он цагийг мэдэж авна.
- Түүхэн сурвалжтай ажиллаж, асуулт даалгавраас шинэ мэдлэг олж авна.
- Газарзүйн зурагтай ажиллаж шинэ газар орноор аялна.
- Дундад зууны түүхийг өөрсдөө сэргээн судална.
- Дундад зууны нийгмийн байдал, хүмүүсийн ахуй амьдралыг мэдэж авна.

Үүний тулд та нар:

- Түүхэн сэдэв бүрд буй бичвэрийг уншаад түүний доорх асуултад хариулна.
- Түүхэн газарзүйн зурагтай ажиллаж, газарзүйн баримжаа ба мэдлэгээ сайжруулна.
- “Эх сурвалжийг шинжлээрэй” хэсэгт буй түүхэн сурвалжтай ажиллаж, мэдлэг бүтээнэ.
- “Он дарааллын шугам”-ыг ашиглан түүхэн үйл явц, хэрэг явдлын он цагийг тогтооно.
- “Дүгнээрэй, үнэлээрэй” хэсэгт буй асуулт, даалгаврыг хийж, өөрийгөө сориорой.

Сурагч та Дундад зууны түүхээр аялж, олон шинэ зүйлийг судлан таньж, Монголын ба дэлхийн түүхийн мэдлэгээ улам бүр тэлнэ гэдэгт бид итгэж байна.

*Та бүхэнд амжилт хүсье.*

### СУРАХ БИЧИГТ АШИГЛАГДАХ ТАНИХ ТЭМДЭГҮҮД



АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ



УНШИЖ ОЙЛГООРОЙ



ЭХ СУРВАЛЖИЙГ ШИНЖЛЭЭРЭЙ

# I БҮЛЭГ. ДУНДАД ЗУУНЫ ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

## 1. ДУНДАД ЗУУНЫ ТҮҮХЭЭР ЮУ СУДЛАХ ВЭ?



- Эртний түүхээр та нар ямар улс орон, ард түмний түүхийг судалсан бэ?
- НТ 476 онд ямар үйл явдал болсон бэ?
- Эрт, шинэ үеийн хоорондох үеийг хэрхэн нэрлэж болох вэ?
- Энэ үеийн эхэлсэн, дууссан хугацааг тооцоолж, мянганаар илэрхийлнэ үү.

Дундад зуун V зуун буюу Баруун Ромын эзэнт улсын мөхлөөс эхэлж, XV зууны сүүлч хүртэл 1000 гаруй жил үргэлжилнэ.

Энэ үеийн түүхээр тархай бутархай байсан Монгол аймаг, улсууд нэгдэн хүчирхэгжиж, Их Монгол улсыг байгуулсан, Их Монгол улс өргөжин тэлж дэлхийн агуу гүрэн болж хөгжсөнийг судална. Энэ үеийг дэлхийн түүхэнд “Монголын үе” гэдэг.

Дундад зууны Европ тив нэгдмэл “түүхэн эх газар” болж, европчууд нийтлэг шашин шүтлэгтэй, амьдралын ижил хэв маяг бүхий Загалмайтны ертөнцийн хүмүүс болжээ. Чухамхүү Дундад зуунд өнөөгийн Европын үндэстнүүд бүрэлджээ.

Энэ сурах бичигт Дундад зууны Дорно ба Өрнийн улс орнуудын хаад, төр нийгэм, улс төр газар нутаг, хүмүүсийн ахуй амьдралын тухай өгүүлнэ. Тэр үеийн хүмүүсийн орон байр, хувцас, хэрэглэл, зэр зэвсэг ямар байсныг мэднэ. Мөн Дундад зууны гайхамшигт яруу найраг, уран зураг, барилгатай танилцана. Дэлхийн гол шашны сургаал, номлол, сүм хийд, ёс заншил ямар байсан тухай үзнэ.



1. Монголын үе гэж хэддүгээр зууныг хэлэх вэ? Энэ үед ямар түүхэн үйл явдлууд болсон бэ?
2. Дундад зууны Европт гарсан гол өөрчлөлтүүд юу вэ?
3. Дундад зууны түүхээр бид юу мэддэг болох вэ?

### Он тоололтой ажиллаж сурцгаая

Бид 6-р ангидаа он, зуун, мянган хэмээх он тооллын үндсэн нэгжүүдийн тухай, оныг зуунд шилжүүлэх аргын тухай үзсэн билээ.



1. Оныг зуунд шилжүүлэх ямар хялбар аргыг мэдэх вэ? Өмнөх мэдлэгээ сэргээгээрэй.
2. Энэ аргаар оныг мянганд шилжүүлж болох уу. Аргачлал зохиож, дараах оныг мянганаар илэрхийлээрэй. 476 он, 1206 он, 1486 он
3. Энэ үйл явдлууд та нарын төрсөн жилээс хэдэн жилийн өмнө болсон байна вэ? Он тооллын шугамд тэмдэглэнэ үү.

Дундад зууны улс орнууд цаг хугацааг өөр өөрсдийн он тооллоор тоолж байжээ. Тэд он тооллоо өөрсдийн түүхэн чухал үйл явдлаас эхлүүлэн тоолж байв. Он тооллын энэ эхлэл цэгийг эрин гэнэ. Дундад зуунд хэрэглэж байсан эринг жагсаав (Хүснэгт 1.1.). Эдгээр он тооллыг мэдэж авах, дэлхий нийтээр хэрэглэж байгаа нийтийн (аргын) тоололд шилжүүлж, тооцож сурах нь чухал юм.

Хүснэгт 1.1.

ЭРИН	
Ертөнцийг бүтээсэн эрин	НТӨ 5508 он
Хижрийн эрин	622 он
Билгийн тоолол	Монголд 1027 он
Чингисийн тоолол	1162 он

**Билгийн тоолол гэж юу вэ?** Билгийн тоолол гэдэг нь сар дэлхийг тойрох мөчлөгийг ажиглаж, өдөр, сар, жилийг тоолдог тоолол юм.

Монгол, Солонгос, Хятад зэрэг дорнын ард түмэн билгийн тоолол хэрэглэдэг. Гэхдээ улс бүрийн билгийн тоолол эхлэх хугацаа янз бүр юм. Монголчуудын билгийн тоолол аргын тооллын 1027 оноос эхлэх ба XVII жаранд бид амьдарч байна. Энэ тоолол 12 жил, жаран, 5 махбодь дээр суурилдаг. Нэг жил 12 сартай байх ба жил, сар, өдрийг мал, амьтнаар нэрлэдэг. 12 жил таван удаа давтагдахад нэг жаран болдог. Мод, гал, шороо, төмөр, усыг таван махбод гэдэг.



Хүснэгт 1.2.

Махбод	Мод		Гал		Шороо		Төмөр		Ус	
	Хөх	Улаан	Шар	Цагаан	Хар					
Махбодын өнгө, хүйс	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
	Хөх	хөхөгчин	улаан	улаагчин	шар	шарагчин	цагаан	цагаагчин	Хар	харагчин

Энэ өнгийн дэс дарааллаар хөх хулгана, хөхөгчин үхэр, улаан бар, улаагчин туулай, шар луу, шарагчин могой гэж эр, эмээр ялган тоолдог. Хар-эр өнгө, харагчин-эм өнгө юм.

Билгийн жилийг аргын онд, аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга	Жишээ
<p><b>Билгийн жилийг аргын жилд шилжүүлэх арга</b></p> <p>Билгийн жилийг аргын онд шилжүүлэхдээ дараах томъёог ашиглана. Үүнд: <math>x=1026+(a-1)\times 60+b</math> юм.</p> <p>X нь билгийн жилд харгалзах оныг, а нь жарны дугаарыг, b нь жилийн дугаарыг тус тус илэрхийлж байгаа болно.</p>	<p>XVI жарны гал морин жилийг аргын онд шилжүүлье. Томъёо болон жилийн дугаар заасан хүснэгтээ (хүснэгт 2) ашиглан бодвол:</p> $X=1026+(a-1)\times 60+b=1026+(16-1)\times 60+40=1966$ <p>гарч байна. Ийнхүү бид томъёо болон хүснэгтийн тусламжтайгаар XVI жарны гал морин жил аргын тооллын 1966 он болохыг түвэггүй оллоо.</p>
<p><b>Аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга</b></p> <p>Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ тухайн аргын оноос 1026-г хасч, гарсан ялгаврыг 60-д хуваасны бүхэл үлдэгдэл нь олох билгийн жилийн дугаар бөгөөд ногдвор дээр 1-ийг нэмбэл олох билгийн жилийг харьяалах жарны дугаар гарна. Хүснэгтэд буй дугаараар билгийн жил хийгээд түүний махбодыг олно.</p>	<p>1962 оныг билгийн жилд шилжүүлье.</p> $1962-1026=936. \quad 936:60=15(36).$ <p>36 нь билгийн жилийн дугаар. Хүснэгтээс харвал 36 дугаартай жил нь усан бар байна. <math>15+1=16</math>. усан бар жилийг харьяалах жарны дугаар 16 буюу 1962 он нь XVI жарны усан бар жил болж байна.</p>

Хүснэгт 1.3.

Махбодь жил	Гал	Шороо	Төмөр	Ус	Мод
Туулай	1	13	25	37	49
Луу	50	2	14	26	38
Могой	51	3	15	27	39
Морь	40	52	4	16	28
Хонь	41	53	5	17	29
Бич	30	42	54	6	18
Тахиа	31	43	55	7	19
Нохой	20	32	44	56	8
Гахай	21	33	45	57	9
Хулгана	10	22	34	46	58
Үхэр	11	23	35	47	59
Бар	60	12	24	36	48



1. Мэдээлэлд гарсан эрин, билгийн тоолол, жаран зэрэг нэр томъёог бие биедээ тайлбарлаж өгөөрэй.
2. Томъёо, хүснэгтийг ашиглаж, өөрийнхөө төрсөн оныг билгийн жилд шилжүүлээрэй.
3. Энэ жил билгийн тооллын хэддүгээр жарны ямар жил вэ?

Хүснэгт 1.4.

Хижрийн тооллыг аргын тоололд шилжүүлэх арга	Ертөнц бүтээгдсэний эриний тооллыг аргын тоололд шилжүүлэх арга
<p>Лалын тооллын эринг хижра буюу арабаар зугталт гэдэг. 622 онд Лалын шашныг үндэслэгч Мухаммед хэсэг дагагчдынхаа хамтаар Меккагаас Медин хотын зүг зугтсан явдал он тооллын эхлэл болдог. Лалын тооллыг аргын тоололд шилжүүлэхэд тусгай томъёо хэрэглэнэ.</p> $x = M - M/33 + 622$ <p>x – Аргын тооллын он M – Лалын хуанлийн хижрийн он M/33 – Лалын сарны хуанлийн жил нарны жилээс 11 хоноогоор богино буюу нарны жилээс 1/33-ээр хоцорч байдаг. Жишээ нь, хижрийн 1399 оныг аргын онд шилжүүлье.</p> $x = 1399 - 1399/33 + 622$ <p><math>1399/33=42</math> болох бөгөөд <math>1399-42+622=1979</math> он болж байна.</p>	<p>Загалмайтны ертөнцөд эхэн үедээ он тооллыг Христийн мэндэлсэн өдрөөс бус ертөнц бүтээгдсэн өдрөөс эхлэн тоолдог байв. НТӨ 5508 (5509) он буюу Христ мэндлэхээс 5508 жилийн өмнө Ертөнц бүтээгдсэн гэж үздэг. Энэ тооллыг Визант, Орос (1700 он хүртэл) зэрэг үнэн алдартны шашинт орнууд хэрэглэж байжээ. Энэ тооллоор 1700 онд ертөнц бүтээгдээд 7208 жил болно. Он тооллын шугамд тэмдэглэж харуулбал,</p> <div style="text-align: center;"> <p>НТӨ 5508 он      XM 7208 он      НТ 1700 он</p> <p>Он тооллын шугам</p> </div>

Чингисийн тоолол	Бодлого
Монголчууд үндэсний баатар их Чингис хааны тооллыг бас хэрэглэдэг. Энэ нь Чингис хааны төрсөн 1162 оноор эхэлдэг тоолол юм. 1162 оноос өмнөх хугацааг Чингисийн өмнөх он, 1162 оноос хойших хугацааг Чингисийн он гэж тоолно. 2015 он бол Чингисийн 854 он юм.	Хабул хаан 1130 онд Монгол улсыг байгуулсан нь Чингисийн өмнөх хэдэн он болох вэ? Чингис хааны төрсөн 1162 оноос 1130 оныг хасахад 32 гарна. Үүн дээр 1162 оны хий тоог нэмнэ. Ингээд Чингисийн өмнөх 33 он болж байна. $(1162-1130=32+1=33)$ он



- Аргын тоололд шилжүүлнэ үү.
  - Хижрийн 110 он аргын тооллын хэдэн он болох вэ?
  - Ертөнц бүтээгдсний эриний 6494 он аргын тооллын хэдэн он болох вэ?
  - Чингисийн тооллын 800 он аргын тооллын хэдэн он болох вэ?

## ДҮГНЭЭРЭЙ

## 1.1

## ҮНЭЛЭЭРЭЙ

Дундад зуун, Дорно, Өрнө, арга, билгийн тоолол гэж юу вэ?	Дундад зууны түүхээр бид хэчнээн жилийн түүхийг судлах вэ?	Аргын тоолол, билгийн тоолол, хижрийн тоолол, ертөнц бүтээгдсний эриний тооллыг харилцан шилжүүлж сурснаа шалгаарай.
Тайлбарлаарай.	Тооцоолоорой.	Жишээ гаргаж, бодоорой.

## 2. ДУНДАД ЗУУНЫ ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

Дундад зууны түүхээр V–XV зууны Монголын болон дэлхийн улс орны түүхийг судална. Энэ нь бидний амьдарч буй цаг үеэс олон зуун жилийн өмнө болсон түүхэн үйл явдлыг мөшгин судална гэсэн үг юм.

“Манай монгол үндэстний анхны түүхт дурсгалын зохиол бол Монголын нууц товчоо гэдэг зохиол мөн. Тэр эрт холын цагт монголын ард түмний дотор уран үгийг холбож, түүхт их явдлыг найруулан бичих цэцэн билэгтэй, гэгээн боловсролтой хүмүүс байсан байна. Нууц товчоог монгол хүн, монгол нутагт зохиосон тул ...чухал холбогдолтой болно. 1908 онд хятадын эрдэмтэн Ей Дэ-хуй оршил бичиж гаргасан Юань улсын үеийн дармал Нууц товчооны эхэд 12 дэвтэр байна. ...тэргүүн арван дэвтэр нь урьд зохиогдсон ба дараа нэмсэн нь хоёр дэвтэр болно. Энэ нэмэлт хоёр дэвтэрт Өгэдэй хааны үеийн явдлыг бичсэн ба...арван дэвтэрт Монголын анхны гарлаас аваад Чингис хааны эцэс хүртэл болсон явдлуудыг тоочжээ. Уг зохиолыг “...Их хуралдаан болж, хулгана жилийн (1240) хуран (долдугаар) сард Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог, Шилхинцэг хоёрын завсар хаан орд бууж байхад бичиж төгсгөв” гэж өндөрлөжээ. (Ц.Дамдинсүрэн Монголын нууц товчоо. УБ., 1957)



- Олон зуун жилийн өмнө болсон үйл явдлыг бид хэрхэн сэргээн судлах вэ? Бидэнд юу туслах вэ?
- Түүхийн эх сурвалжийн тухай бид юу мэдэх вэ?
- “Монголын нууц товчоо” түүхийн эх сурвалжийн ямар төрөлд хамаарах вэ?
- Бичвэр мэдээллээс “Монголын нууц товчоо”-ны тухай бид юу мэдэж авсан бэ?






Дэлхийн олон музейд дундад зууны хүмүүсийн зэр зэвсэг, хөдөлмөрийн багаж, хувцас, гоёл чимэглэл, зоос, усан онгоцны үлдэгдэл зэрэг дурсгалууд хадгалагдаж байна. Олон хотод дундад зуунд баригдсан шилтгээн, бэхлэлтийн хана, цамхаг, сүм хийдийг харж болно. Гэвч эдгээр нь хүмүүсийн ахуй амьдралын тухай бүгдийг өгүүлж чадахгүй юм.

Дундад зууны хүмүүс газар бэлэглэх, худалдан авах зэргээр олон баримт үйлдэж байжээ. Эдлэн газрын тодорхойлолт, даамлын тайлан, гэрлэлтийн гэрээ зэрэг ажил хэргийн олон баримт архивт бий. Мөн хууль, эрх баригчдын зарлиг, шүүхийн шийдвэр, олон улсын гэрээ хэлцэл зэрэг чухал баримт уламжлан иржээ. Түүх, уран зохиолын гайхамшигт дурсгалууд ч түүх өгүүлнэ.

Номын чимэглэл зураг, бурхны хөрөг, уран зураг, ханын зураг, сүмд босгосон хөшөө баримал зэрэг урлагийн бүтээл хүмүүсийн ахуй амьдралын тухай олон зүйлийг өгүүлж чадна.

1. *Шастир, сав суулга, гоёл чимэглэл, гар бичмэл, зэр зэвсэг, зоос*  
Эдгээрийг бичгийн ба эдийн сурвалжийн алинд нь хамааруулж үзэх вэ? Яагаад?
2. Хэрэв эрдэмтэд дайн, бослого, аж ахуй, хүн амын давхаргын талаар судлах болбол ямар эх сурвалжид хандах вэ гэдгийг эргэцүүлнэ үү.

### Мэдээлэл, эх сурвалжтай ажиллаж сурцгаая.



#### Сурвалжийн мэдээ

1 “Одтой тэнгэр орчиж  
Олон улс байлдаж  
Орондоо унтах завгүй  
Олзлон булаалдаж байв.

Хөрст дэлхий хөрвөж  
Хөвчин улс хямралдаж  
Хөнжилдөө унтах завгүй  
Хөнөөлдөн тэмцэж байв”  
(Монголын нууц товчоо. УБ., 1990. §.254)



Зураг 1.1.

Зэс хөөмөл, 15 x 20 см, Берлин дэх Улсын Номын Сан-Пруссийн Соёлын өвийн сан, Дорно дахины хэсэг


Энэ зургаар эртний Хархорум хот болон Вильгельм Бушегийн бүтээсэн мөнгөн модыг төсөөлсөөр ирсэн юм.

Мөнгөн модны зэс хөөмлийн зургийг Гаага хотноо 1735 онд хэвлүүлсэн Пьерре Бержероны: “Voyages faits principalement en Asie dans le douzieme, treizieme, quatorzieme et quinziesme siacles” хэмээх бүтээлд нийтэлжээ.

3 "...Парисын уран Вильгельм ордны үүдэнд том мөнгөн мод урлан бүтээжээ. Түүний ёроолд тус бүрээс нь айраг олгойдон гарах цоргон амтай дөрвөн мөнгөн арслан байрлуулжээ. Модны дотуур оройд нь хвртэл дөрвөн босоо хоолой татаж, тэдгээрийн амсрыг доош унжуулан тус бүрийн амсрыг алтан шармал могойн ам маягтай үйлдэж, сүүлээр нь мөнгөн модыг ороолгон урлажээ. Эдгээр хоолойн нэгээс дарс, нөгөөгөөс дан айраг, гурав дахиас балын ундаа, дөрөв дэхээс террацина хэмээх будааны шар айраг гоождог аж.

Модны ёроол хавьд амттан ундааг юүлэх тусгай мөнгөн савнуудыг хоолой бүрийн дор тосон байрлуулжээ. Мөнгөн модны орой дээр бүрээ барьсан Ангель хэмээх тэнгэрийн элчийн дүрийг Вильгельм дархан урлан босгож модны доорх газарт хүн далд орохуйц зоорь бэлдэн модны голоор Ангелийг хүртэл бас нэг цорго үйлджээ. Эхлээд тэнд тулман хөөрөг хийсэн авч тэр нь олигтой хөөрөгдөж чадсангүй. Ундааг сөгнөх үйлчлэгч нар тэнд бэлэн хүлээж зогсох ажээ. Модны мөчир, навч, жимс бvгдийг цул мөнгөөр урлажээ..." (Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 185)

Зураг 1.2.



1. Их Монгол улсын түүхийн талаар ямар эх сурвалжуудыг ашигласан бэ?
2. Хүснэгтийг нөхөж эх сурвалж мэдээллээс юу мэдэж авснаа танилцуулаарай.
3. Их Монгол улсын тухай өөр юуг мэдэхийг хүсэж байгаа болон ямар эх сурвалж, мэдээлэл хэрэгтэй байгаа тухай ярилцаарай.

Эх сурвалж	Агуулга	Дүгнэлт
"Монголын Нууц товчоо" зохиолын хэсэг		
Гильом де Рубрук. "Дорно этгээдэд зорчсон минь" зохиолын хэсэг		
Мөнгөн модны зэс хөөмлийн зураг		
"Их Монгол улс" түүхийн газар зүйн зураг		

ДҮГНЭЭРЭЙ

1.2

ҮНЭЛЭЭРЭЙ

Дундад зууны түүхэнд холбогдох ямар эх сурвалжийг судлах вэ?

Эх сурвалж мэдээлэлтэй ажиллах ямар аргад суралцсан бэ?

Нэрлээрэй

Нэг эх сурвалжийг сонгон авч эх сурвалжтай ажиллах төлөвлөгөө гаргаарай

## II БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ӨМНӨХ МОНГОЛ (VI-XII ЗУУН)

### 1. МОНГОЛЧУУДЫН НҮҮДЭЛ, СУУРЬШИЛ

Түрэгүүд 555 онд Жужан (Их Нирун) улсыг мөхөөж, Монгол нутгийг эрхшээлдээ оруулав. Түрэг угсааны улсууд Монгол газар нутагт 842 он хүртэл ноёрхжээ.



Энэ үед Монголын овог, аймгууд хаана нутаглаж, хэрхэн аж төрж байв?

VI зуунд жужанчууд Түрэгт цохигдон гурав хуваагджээ. Нукуз, Хиян овгууд Түрэгээс дайжин дорно зүг Эргүнэ гүн хэмээх газар очиж нутаглав. Эргүнэ гүнд очиж суусан Жужан нарын дундаас хожим Их Монгол улсыг байгуулсан Боржигин овог үүсжээ.

Жужан нарын зарим хэсэг нутгийнхаа зүүн талд шахагдан Хөлөн ба Буйр нуурын саваар төвлөрөн суух болов. Тэдгээр Монгол аймгийг Түрэг, Уйгурын түүхэнд анх 30 татар гэж тэмдэглэжээ. Хожим тэд 9 татар гэгдэх болов.

Жужанчуудын гурав дахь хэсэг нутагтаа үлдэж Түрэг, Уйгур улсуудад захирагдсан байна. Тэдний дундаас хожмын Найман, Хэрэйд, Мэргид зэрэг аймаг, улсууд гарчээ.



Мэдээлэл, сурвалжийн мэдээг задлан шинжилж, асуултад хариулаарай.

#### ТАЙЛБАР

Нукуз буюу Нохос нь олон нохой гэсэн утгатай Монголын ноёлох овгийн нэр юм.

Хиян нь эрэлхэг, чин зоримог гэсэн утгатай Монголын ноёлох овгийн нэр юм.

1. Жужан улс унахад монголчууд хэдэн том хэсэгт хуваагдсан бэ? Бүдүүвчийг гүйцээнэ үү.
2. Эргүнэ гүн хэмээх газар Жужаны ямар овгууд очиж суусан бэ?
3. Монгол нутгийн зүүн талд ямар аймгууд шахагдаж суусан бэ? Тэдгээр аймаг хэнд шахагдсан бэ?
4. Монголын төв нутагт үлдсэн аймгууд ямар улсын захиргаанд байсан бэ?

Бүдүүвч 2.1.

#### ЖУЖАН



#### ТАЙЛБАР

Эргүнэ гүн гэдэг газар Их Хянганы нуруу, Эргүнэ голын савд байдаг.

### Сурвалжийн мэдээ

1. “Эрт цагт монголчууд гэж нэрлэгддэг байсан аймаг бусад түрэг аймагтай хямралдан дайнаар шувтарсан байна. ....бусад аймаг нь монголчуудыг дийлээд хоёр эрэгтэй, хоёр эмэгтэйгээс илүү хүн үлдээлгүй хяджээ. Эдгээр хоёр өрх дайснаас айхдаа бусад хүршгүй газар зугатан очжээ....Энэ нутгийг Эргүнэ гүн гэж нэрлэдэг...” (Судрын чуулган. УБ., 2002. 1-р боть. 1-р дэвтэр, 4-р анги.)
2. “...Энэ угсаатан тэр уулс, ойн дунд үржээд нутаг нь хүрэлцэхгүй шахцалдах болсонд ямар сайн арга, хялбар замаар энэ хэцүү хавцал уулын давчуу хөндийгөөс гарах тухай хоорондоо зөвлөлдөв. Ингээд тэд байнга төмөр хайлуулдаг төмрийн хүдэртэй газар олоод цөмөөрөө хамт цуглан ойд түлээ, олон сав нүүрс бэлтгээд далан толгой үхэр, адуу алан арьсыг нь туламлан өвчиж, төмөрчний хөөрөг хийжээ. Нөгөө уулын хэцийн хормойд түлээ нүүрсээ зэрэглээд далан хөөргөөр тэр хэцийг хайлтал нь нэгэн зэрэг хөөрөгдсөнд тэндээс хэмжээлшгүй их төмөр аваад гарц нээгджээ. Тэд цөм хамт тэр давчуу газраас нүүн талд гарчээ...” (Судрын чуулган. УБ., 2002. 1-р боть. 1-р дэвтэр, 4-р анги.)
3. “...Тэндээс гарагчдын дотор зарим аймгийн толгойлогч Бөртэ Чоно гэдэг ихээхэн нэр хүндтэй ноён байжээ...” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. 2-р дэвтэр. I анги.)




1. Домогт хэдий үеийн монголчуудын тухай өгүүлж байна вэ?
2. Эргүнэ гүнд очсон хоёр эрэгтэй, хоёр эмэгтэйгээр хэнийг төлөөлүүлсэн бэ? Эргүнэ гүнийн монголчууд яагаад уг нутгаас нүүх болсон бэ?
3. Монголчууд Эргүнэ гүнээс хэрхэн гарсан бэ?
4. Монголын зарим аймгийг хэн толгойлж байсан бэ? Энэ мэдээ ямар зохиолд тэмдэглэгдэж үлдсэн бэ?

### Сурвалжийн мэдээ

1. “Чингис хааны язгуур. Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж ...” (МНТ. УБ., 2011. §. 1)
2. “Тэд Онон, Хэрлэн, Туулын хөндийгөөр нутагладаг байжээ. Энэ гурван гол нь Бурхан Халдун уулаас эх авдаг билээ”. (Судрын чуулган. УБ., 2002. I боть, II дэвтэр, I анги)



1. Эргүнэ гүнийн домог, “Монголын нууц товчоон” хоёрыг холбож буй зүйл юу вэ?
2. Бурхан халдун уул, Онон, Хэрлэн, Туулын саваар нутаглах монголчууд хэнээс гаралтай вэ?
3. Бурхан Халдун уул хаана байдаг вэ?
4. Жужан нар хожмын ямар угсаатантай холбоотой вэ? Таамаглал дэвшүүлж ярилцаарай.



Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Түрэг угсаатны ноёрхлын үед Жужан нар хаана нутаглаж байсан бэ?	Түрэг, Уйгур улсын үед Жужан нар түүхэнд ямар нэрээр бичигдэж үлдсэн бэ?	Жужан нарын нүүдэл, суурьшлын үр дүн юу вэ?
Монгол нутагт Түрэг угсааны улсуудын ноёрхол тогтсон ба унасан оныг зуунаар илэрхийлж, үргэлжилсэн хугацааг тооцоолоорой.	Эргүнэ гүн, Хөлөн, Буйр нуурын сав газар, Бурхан Халдун уулыг газарзүйн зурагт зааж үзүүлээрэй.	Нэрлээрэй.	Дүгнэн ярилцаарай.

## 2. VI-XII ЗУУНЫ МОНГОЛЫН АЙМАГ, УЛСУУД

VI зуунд Жужан улс мөхсөний дараа Монголын зарим аймгууд Түрэг, Уйгур, Хятан улсын хараат болж явав. Бас зарим үед хүчирхэгжиж байсан ч Чингис хааны үе хүртэл тархай, бутархай эв түнжин муутай байжээ.



Жужаны хойч Монгол, Татар, Найман, Хэрэйд, Онгуд, Гурван Мэргид зэрэг аймаг, улсууд хэзээ, хаагуур, хэрхэн нутаглаж байв?

555-842 онд Монгол нутагт Түрэг угсааны улсууд ноёрхжээ. Энэ үед Жужаны ноёлох аймгуудаас Нукуз, Хиян нар зүүн зүг Эргүнэ гүнд очив. Нутагтаа үлдсэн Жужан аймгууд Түрэг, Уйгур улсын захиргаанд оров. Мөн зарим хэсэг нь Түрэгт шахагдаж нутгийнхаа дорнод хэсэгт суужээ. Түрэгт шахагдан Хөлөн, Буйр нуурын сав газарт суусан жужанчуудыг Татар гэнэ. Тэд Түрэг, Уйгурын үед бие даасан бэсрэг улс болон тогтож байжээ. Түүнийг зарим түүхчид Монгол-Татарын хаант улс гэж нэрлэдэг. 842 онд Монгол-Татарууд Хиргизийг ялснаар Монгол нутагт Түрэг угсаатны ноёрхол эцэс болов. Үүнээс хойш Татар улс Монгол нутагт 100-аад жил ноёрхсон байна. 923 онд Хятан улсын цэрэгт Татар улс цохигдож, олон аймгуудад хуваагджээ. Энэ үеэс Татар аймгууд Хятан улсад, дараа нь Алтан улсад алба барих болжээ. Монгол, Татар хоёр нэг угсаа гаралтай тул монголчуудын бас нэг нэр нь Татар байв.



1. Түрэгт цохигдсон Жужан нар хэд хуваагдсан бэ?
2. Бэсрэг улс гэж юу вэ? Саналаа солилцоорой.
3. Монгол нутаг дахь Түрэг угсаатны ноёрхлыг хэн эцэс болгосон бэ?
4. Монгол-Татарын улс хэзээ унаж, хэнд алба барих болсон бэ?

### ТАЙЛБАР

Жужан улсын Датань хааны нэрээс Татар нэр үүсжээ.

### Сурвалжийн мэдээ

1. “Буйр нуур, Хөлөн нуур хоёрын зуур Оршуун мөрнөө бүхүн...Татар” (МНТ. УБ., 2011. §. 53)
2. “Хэт их сүр, нэр хүндтэй байсан болохоор ... тэдний нэрээр алдаршин цөм татарчууд гэж нэрлэгддэг байв” (Рашид-Ад-дин. Судрын чуулган. УБ., 2002. т. 66-67)



1. Сурвалжаас татаруудын тухай юу мэдэж авсан бэ?
2. Нүүдэлчин аймаг, овгуудыг нийтэд нь татарчууд гэж нэрлэж байсны учир юу вэ?

**Монгол улс.** Эргүнэ гүнээс гарсан хэсэг монголчуудыг Бөртэ чоно тэргүүлэн Бурхан халдун уул, Гурван голын (Онон, Хэрлэн, Туул) эхэнд иржээ. Тэдгээр аймгуудыг Монгол гэдэг. 1130 оны орчим Хабул Монгол улсыг байгуулжээ. Монгол улс хүчтэй болж, Хабул хаан 1133-1135 оны үед умард Алтан улсад айлчилжээ. Хоёр улсын байгуулсан гэрээгээр Алтан улс зарим газар нутгаа Монголд өгч, жил бүр алба барихаар болов. Ийнхүү Монгол улс Хабул хааны үед хөл дээрээ зогсож чадсан байна.

Хабул нас эцэслэхдээ хаан ширээг Тайчууд аймгийн Амбагайд гэрээсэлжээ. Амбагай хаан монголчуудын эв нэгдлийг сахих бодлогыг үргэлжлүүлж байв. Амбагай хаан охиноо Татарт хатан болгон хүргэж өгөхдөө баригдаж, Алтан улсад хүргэгдэн цаазлуулжээ.

Монгол улсын гурав дахь хаанаар Хабул хааны хүү Хутула өргөмжлөгдөв. Хутула хаан улсаа төв, зүүн, баруун гурван гарт хуваан захирчээ. Тэдгээр гурван гар нь дотроо хүрээний зохион байгуулалттай байв.



1. Монгол улсыг хэн байгуулсан бэ?
2. Монгол улс байгуулагдсан 1130 он нь Чингисийн өмнөх хэдэн он болох вэ?
3. Амбагай хаан ямар бодлого явуулсан бэ?
4. Хутула хаан улсдаа ямар шинэчлэлт хийсэн бэ?

### Тодруулга

Монгол гэдэг нэрийг анх Жужан улсын үеэс эхлэн хэрэглэх болсон юм. Монгол нэрийн талаар 40 гаруй тайлбар бий. Тэдгээрийн заримыг дурдвал, Мон голоор нутагладаг хүмүүсээс үүсэлтэй, Гол аймаг улс, Мөнх гал, Мөнх тэнгэр гал гэсэн үгнээс хувирсан, Мугулюй (мухар толгойт) гэсэн хүний нэрээс үүдэлтэй зэрэг юм.




1. Монгол нэрийн утгын талаар саналаа солилцож мэтгэлцээрэй.

### Сурвалжийн мэдээ

1. Хамаг Монголыг Хабул хаан мэдэж ав (байв). (МНТ. УБ., 2011. §. 52)
2. “Хабул хааны хойно Хабул хааны үгээр долоон хөвүүдээн бөгөөтөл Сэнгүм билгийн хөвүүн Амбагай хаан Хамаг Монголыг мэдэн ав (байв). (МНТ. УБ., 2011. §. 52)
3. “Хамаг Монгол, Тайчууд Ононы Хорхоног Жубур хурж, Хутулыг хаан болгов” (МНТ. УБ., 2011. §. 57)

1. Хабул яагаад хөвүүддээ хаан ширээгээ залгамжлуулаагүй вэ?
2. Бүдүүвчид Монгол улсын хаадыг дараалуулан бичнэ үү.



### Сурвалжийн мэдээ

1. “Хабул түүний хөвүүд нэн зоригтой билгүүн авьяастай болохоор алдар суу нь Алтан (Хятад) улс, түүний ноёдын чихийг дэлсжээ. Хабул хан бол хүндэтгэвэл зохих их хүн гэж Алтан хан төсөөлөх болсон учир түүнтэй ойртох, хоёр тал эвтэй найрсаг байх өргөн зам гаргах гэж бодоод түүнийг урихаар элч заржээ.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. II дэвтэр. I анги)
2. “Хутула хан их том дуутай байсан учир түүний хашгирах дуу 7 давааны цаана дуулддаг...Түүний гар нь баавгайн сарвуу шиг. Тэр хүнийг хоёр гараараа бариад авбал тавихгүй...” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. II дэвтэр. I анги)



1. Алтан улс Хабул хааныг урьсны учир шалтгаан юу вэ?
2. Хутула хаан ямар хүн байсныг төсөөлөн ярилцана уу.

**Найман** нь Түрэг, Уйгур, Хятан улсад захирагдаж явсан Монгол аймгийн нэг юм. Найман аймгаас бүрдэх тул Найман нэртэй болов. XII зууны эхэнд Найман аймгууд улсын хэмжээнд хүрчээ. Найман улсын нутаг баруун зүг Зайсан нуураас зүүн зүг Хархорум уул хүртэл байв. XII зууны II хагаст Найман улсын дотоодод зөрчил гарч, Таян, Буюруг ах дүү хангууд хуваан захирах болов. Таян хан Орду балык төвтэй Найманы умард хэсгийг, Буюруг хан Алтайн Эрчис ба Өрөнгө голын хөндийг тус тус мэдэж байлаа.

**Хэрэйдүүд** мөн Түрэг, Уйгур, Хятан улсын захиргаанд явав. Хээр бор царайтай учир Хэрэйд нэртэй болсон гэдэг. XII зуунаас бие даан улс болжээ. Хэрэйд улс Орхон, Сэлэнгийн бэлчрээс өмнө зүг их элсэн говь, Хэнтий ба Хангайн нурууны хооронд зүүн, төв, баруун гэсэн 3 гарын зохион байгуулалттай оршиж байв. Тэр XII зууны эхэнд Хэрэйд аймгуудыг Маркус хан удирдаж байлаа. Хэрэйд улсад хаан ширээний тэмцэл хүчтэй байжээ. Энэ тэмцэлд Тоорил Монголын Есүхэй баатрын дэмжлэгээр ялж, хаан суув. Түүний үед Хэрэйд улс хүчирхэгжжээ.

**Мэргид** аймгууд Орхон голын адаг, Сэлэнгэ мөрний дунд урсгалаар оршиж байв. Гурван аймагтай тул бас Гурван Мэргид гэдэг. Гурван Мэргидийг Удуйд аймаг тэргүүлж байжээ. Мэргидүүд Монгол улстай эхэндээ сайн харилцаатай байв. Гэвч XII зууны дунд үеэс тэд эвдэрч, хоёр удаа байлдахад Мэргид ялагджээ.

Ойрад аймаг Хөвсгөл нуурын баруун талын ой тайгаар оршино. Ойн ард гэсэн утгатай үг. Хөвсгөл нуурын зүүн талаас Байгал нуурын сав хүртэл Хорь Түмэд, Баргу аймгууд байв. Хиргис аймаг Хэм ба Хэмчиг голын сав газраар нутаглаж байв. Ойрад ба Хиргис аймгийн хойгуур олон жижиг анчин гөрөөчин овог, аймгууд байсныг "Ойн иргэд" гэдэг.

**Онгуд** аймаг Цагаан хэрмийн хойгуур нутагладаг. Тэд Алтан улсын хүчинд автаж түүний хилийг бусад нүүдэлчдээс хамгаалах алба хаах болсон байна.

**Татар аймгууд.** Жужан улсын үед Татар нэр үүсэж “гучин татар”, “есөн татар” гэж тэмдэглэгдэх болов. 923 оны үед Монгол-Татар улс задарч, олон аймгуудад хуваагджээ. Тэд Хөлөн, Буйр нуур, Оршуун голын саваар нутаглаж байв. Тэдний Айригууд, Буйригууд, Цагаан, Алчи, Арухай, Дутагут, Жүй зэрэг аймгуудын нэр тодорхой байдаг. Татарууд угсаа гарал нэгтэй монголчуудтай эв түнжин муутай байсан нь Алтан улсад алба хааж, хаад язгууртнуудыг барьж өгөх болсноос

эхлэлтэй. Мөн татарууд Алтан улстай харилцах зам дээр оршдог, адуу малын сайхан бэлчээр нутагтай байсан зэрэг нөлөөлжээ. Тэр бүх зөрчлийг харилцан цусан өшөө явдал улам хурцатгаж байв.



1. V-IX зуунд Монголын аймгууд ямар улсуудад захирагдаж байсан бэ?
2. Монголын ямар аймгууд улс болж чадсан бэ?
3. Хойд ой тайгаар нутагладаг ямар аймгууд байна вэ?
4. Яагаад Монгол, Татар аймгуудын харилцаа муудсан бэ?

### Сурвалжийн мэдээ


1. “Удуйд Мэргидийн Тогтога, Увас Мэргидийн Дайр Усун, Хаад Мэргидийн Хаатай Дармала эд гурван Мэргид.” (МНТ. УБ., 2011. §. 102)
2. “Онгуд аймаг нь... монголчуудтай л адил байв... Онгудын зонхилоч ба цэргийн ноён нь Алакуш-тегин Хүри гэгч байв.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. I дэвтэр. III анги)



1. Яагаад гурван Мэргид гэж нэрлэсэн бэ? Эдгээр гурван аймгийг хэн толгойлж байв?
2. Онгуд аймгийн ахуй амьдрал, соёл ямар улстай төстэй вэ? Онгуд аймгийг хэн тэргүүлж байсан бэ?



Бүдүүвч 2.2.




Бүдүүвчид Монголын аймаг, улсуудын зарим хаад, тэргүүлэгчийн нэрсийг оноож тавина уу.

(Хабул, Хутула, Тогтога, Хори Буха, Даян, Дайр усун, Буюруг, Тоорил, Хурчахус буюруг, Мэгүжин сүүлт)



Зураг 2.1. Монгол аймаг, улсууд XII зуун



1. Газар зүйн зурагт Монгол аймаг, улсуудыг нэрлэж заана уу.
2. Монголын аймаг, улсуудын өмнө, зүүн өмнө талд ямар улсууд оршиж байсан бэ?

ДҮГНЭЭРЭЙ

2.2

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид хаагуур аялсан бэ?	Монголын аймаг, улсууд	
		Хамгийн их хүчирхэгжсэн нь аль вэ?	Дотоод, гадаад байдал нь ямар байсан бэ?
Монгол-Татарын улс, Монгол улс оршин тогтнож байсан хугацааг зуунаар илэрхийлнэ үү.	Монголын аймаг, улсуудын нутгийн баруун, зүүн, өмнө, хойд хил хаана хүрч байсан бэ?	Нэрлээрэй.	Дүгнэн ярилцаарай.

### 3. МОНГОЛЫН ДАРЛИГИН, НИРУГУН АЙМГУУД

X-XII зуунд Жужаны удмын Татар, Монгол, Мэргид, Хэрэйд зэрэг аймгууд оршиж байв. Эдгээр аймгаас Монгол хожим түүхэнд товойн гарсан бөгөөд Дарлигин, Ниругун (Нирун) гэсэн хоёр том салбарт хуваагдаж байжээ.



Дарлигин, Ниругун аймгууд хэнээс, хэзээ, хэрхэн үүсч нэгдсэн улс байгуулсан бэ?

Түрэгт цохигдсон Жужаны ноёлох Нукуз, Хиян хоёр аймаг Эргүнэ гүнд очиж гурван зуу гаруй жил нутаглажээ. Тэднээс Урианхад, Ихирэс, Олхунугуд, Хонгирад, Элжигин, Дөрвөн зэрэг 23 аймаг салбарлаж гарчээ. Эл аймгуудыг нийтэд нь дарлигинчууд хэмээж байв. Дарлигин аймгууд Бөртэ чонын үед Эргүнэ гүнээс гарч, Бурхан халдун ууланд эргэн ирсэн байна. Жужаны ноёлох хэсэгт Монгол гэх нэртэй аймаг байсныг баримтлан Дарлигин аймгуудыг хятад бичигт Мэн ү буюу Монгол гэж тэмдэглэсэн байдаг.

Бөртэ чонын удмын Добу мэргэн нас барснаас хойш түүний хатан Алангоо гурван хөвүүн төрүүлжээ. Тэдгээр нь Буху хатаги, Бухати салжи, Бодончар мунхаг нар юм. Тэдгээр Алангоогийн гурван хөвүүдээс үүсэж, салбарласан аймгуудыг ерөнхийд нь Ниругун хэмээнэ.

Ниругун аймгууд нь Боржигин, Хатагин, Салжиуд, Тайчууд, Чонос, Ноёхин, Уругуд, Мангуд, Жадаран, Бэсүд, Жүрхин зэрэг 40 орчим аймаг байжээ. Ниругун аймгууд XI зуунд Дарлигин аймгуудаа захирах болов.



1. Нукуз, Хиян аймгууд хаана очиж нутагласан бэ?
2. Хятад сурвалжид монголчуудыг юу гэж тэмдэглэсэн байдаг вэ?
3. Добу мэргэн нас барснаас хойш төрсөн гурван хөвүүнийг нэрлэнэ үү.

#### Сурвалжийн мэдээ

1. “Тэр хоёр хүний (аймгийн) нэр нь Нукуз, Хиян гэдэг. Тэр хоёр хүн тэнд удаан хугацаанд өсөн үржсээр, монгол дарлигинчууд гэж нэрлэгддэг аймаг, салбар салаанууд тэндээс гарчээ”. (Судрын чуулган. УБ., 2002. I боть. I дэвтэр. IV анги)
2. Алангоо гэрлийн туяагаар жирэмсэн болж, ертөнцөд төрүүлсэн гурван хөвүүн, тэдний овог удмаас гарагчдыг Ниругун буюу өөрөөр хэлбэл, нуруу гэнэ. (Судрын чуулган. УБ., 2002. I боть. II дэвтэр. I анги)



1. Дарлигин аймгууд хэнээс, хаана үүссэн бэ?
2. Ниругун гэдэг үг ямар утгатай вэ? Ниругун аймгууд хэнээс үүссэн бэ?

### Сурвалжийн мэдээ

1. “Буху Хатаги Хатагин овогтон болов. Бухату Салжи, Салжууд овогтон болов. Бодончар Боржигин овогтон болов”, (МНТ. УБ., 2011. §. 42)
2. “Бодончарын эмээс төрсөн Барим Шийрт Хабичи нэрт бүлгээ ... Хабичи баатрын хөвүүн Мэнэн Тудун бүлгээ ... Мэнэн Тудуны хөвүүн Хачи Хүлэг ... Хачи Хүлүгийн хөвүүн Хайду ... Хайдугийн хөвүүн ... Чарахай Линху ... Чархай Линхугийн хөвүүн Сэнгүм Билгэ, Амбагайтан Тайчууд овогтон болов”, (МНТ. УБ., 2011. §. 43-47)



1. Монголчуудын Боржигин овог хэнээс үүссэн бэ?
2. Боржигин овог Ниругун, Дарлигины алинд орох вэ?
3. Амбагай ямар овгийн хүн бэ?
4. Тайчууд овог хэнээс салбарлаж үүссэн бэ?
5. Тайчууд Дарлигин, Ниругуны алинд хамаарах вэ?

Зураг 2.2.


### ТАЙЛБАР

1. Нуруу гэдэг үгийг монгол бичгээр Ниругун гэж бичдэг.
2. Боржигин гэдэг нь “чоно эзэн” гэсэн утгатай үг юм. Бор-чоно, жигин (тегинь)- эзэн гэсэн үг ажээ.




1. Алангоо эхийн доор зурсан гурван дугуйгаар юуг харуулсан бэ?
2. Алангоо эхийн өмнө ямар амьтан зурсан байна вэ? Уг амьтнаар юуг төлөөлүүлсэн бэ?

### АЛАНГОО ЭХ



(“Судрын чуулган”-ы чимэг зураг)

Бүдүүвч 2.3.



Мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлж, бүдүүвчийг гүйцээнэ үү.

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүх судалсан бэ?	Бид хаагуур аялсан бэ?	Дарлигин, Ниругун аймгууд Жужантай ямар холбоотой вэ?	Дарлигин, Ниругун аймгууд юугаар ялгагдах вэ?	Дарлигин, Ниругун аймаг гэсэн ялгаа гарах болсон шалтгаан юу вэ?
Жужан улс унасан, Ниругун аймгууд Дарлигинчуудыг захирах болсон хооронд хэдэн зуун жилийн хугацаа байна вэ?	Эргүнэ гүн, Бурхан Халдун уул хаана байдаг вэ?	Бүдүүвчээр харуулаарай.	Хамтарч тодорхойлно уу.	Саналаа дэвшүүлээрэй.

#### 4. МОНГОЛЧУУДЫН АХУЙ АМЬДРАЛ, СОЁЛ

Монголын аймаг, улсууд Байгал нуураас Цагаан хэрэм, Алтайгаас Хянганы нуруу хүртэлх говь, тал хээр, ой тайга бүхий нутагт оршиж байв. Тиймээс монголчуудын аж ахуй, соёл олон янз байжээ. Монголчуудыг нэрийдэх өөр нэг нэр нь Татар юм.



Чингис хааны өмнөх монголчуудын ахуй амьдрал, соёл ямар байсан бэ?



##### Сурвалжийн мэдээ

“Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр, гурван ямхаас давахгүй бас тарган биш, нүүр өргөн бөгөөд хавтгай, хацрын яс товгор, нүд давхраагүй. Үс сахал бага.” (Монгол-Татарын бүрэн тэмдэглэл. УБ., 2014)

##### ТАЙЛБАР

1. Тохой-тохойноос гарын хуруу хүртэл хэмждэг уртын хэмжүүр. Нэг тохой 35 см орчим юм.
2. Ямх-3,2 см орчим ажээ.



1. Монгол хүний нүүрний хэлбэр, биеийг дүрсэлнэ үү. Монгол хүний дундаж өндөр хэдэн см болох вэ?

**Монголчуудын аж ахуй.** Монголын аймаг, улсуудыг эрхлэх гол аж ахуйгаар нь “ойн анчин” ба “талын малчин” гэж ялгаж үздэг. Нүүдэлчид мал аж ахуй голлон эрхэлнэ. Малын мах, сүү бүх ашиг шимийг боловсруулж хэрэглэнэ. Мөн ан гөрөө хийдэг байв. Ан гөрөөг ганц нэгээр хийдэг ан, олуул нийлж хийдэг ав хоморго гэж хоёр ялгана.

Монголчууд бага сага тариа тарьдаг байсан нь Буйр ба Хөлөн нуур, Халх гол, Байгал нуурын өмнөд бие, Сэлэнгэ мөрний саваар байв.

Мөн намар, өвлийн цагт малчдын дунд гэр, тэрэг болон модон сав суулгыг хийх урчууд цөөнгүй байжээ. Төмөр, зэс, ширэм хайлуулж боловсруулан түүгээр хэрэгцээт зүйлээ хийнэ.

Ойн анчин аймгууд Монгол орны умард хязгаараар нутаглаж байв. Тэдгээр нь Баргуд, Хори, Түмэд, Ойрад зэрэг юм. Тэдэнтэй булгачин, хэрэмчин, гөрөөчин зэрэг цөөн хүн амтай ойн иргэд зэрэгцэн сууж байжээ.



1. Монголын аймаг, улсуудын аж ахуй яагаад өөр байсан бэ?
2. Талын аймаг, улсуудын эрхлэх аж ахуй юу байв?
3. Монголчууд хаагуур тариалан эрхэлж байсан бэ?
4. Ойн аймгуудын эрхлэх аж ахуй юу вэ?

### Сурвалжийн мэдээ

1. “Татар хүний нутаг ус бэлчээрээр баялаг тул хонь, адуу зонхилно... гүүний сүү уух бөгөөд хонь гаргаж идэш болгоно.” (*Монгол-татарын бүрэн тэмдэглэл. УБ., 2014.*)
2. “Долоон настyg Мэргид иргэн дагуулж одож, хар алаг ишгэн дах өмсгөж” (*МНТ. УБ., 2011. §. 152*)
3. “Хүрээ нь цагираг тойрог гэсэн утгатай. Эрт цагт ямар нэг аймаг хаа нэг нутагт буухдаа тойрог маягтай байрлах ба тэдний ахлагч төв голд нь байдаг байжээ. Үүнийг хүрээ гэж нэрлэдэг.” (*Судрын чуулган. УБ., 2002. I боть. 2-р дэвтэр. I анги*)



1. Монголчууд хонь, адуу маллах болсон шалтгаан юу вэ?
2. Гүүний сүү гэж юу вэ? Гүү, үнээ, хонины сүүг юунд хэрэглэж байсан бэ?
3. Дах гэж юу вэ? Түүнийг юугаар хийж байсан бэ?
4. Малчин аймгууд хэрхэн нүүж, суудаг байсан бэ? Түүнийг юу гэж нэрлэдэг вэ?

### Сурвалжийн мэдээ

1. “Сэлэнгийн Буур хээрээ Мэргидийн уур нүдэв.” (*МНТ. УБ., 2011. §. 152*)
2. “Бодончар ... чонын гуунд хоргоосон гөрөөсийг харваж алж идэлдээд ... тэр он гарав.” (*МНТ. УБ., 2011. §. 26*)
3. “Өрнө умраас хий (салхи) болбоос харцгайгаар бариулсан нугад, галуудын өдөн үс нь бургалих цасан мэт бутарч хийсэж ирмүй.” (*МНТ. УБ., 2011. §. 31*)



1. “Мэргидийн уур нүдэв” хэмээснийг тайлбарлаарай.
2. Монголчуудын амьдралд ан гөрөө ямар үүрэгтэй байна вэ?
3. Нугас, галууг юугаар агнаж байсан бэ? Үүнийг ямар ан гэдэг вэ?

### Зурагт буй 4 хүний үйл хөдлөлийг тайлбарлаарай.



Зураг 2.3.

### Сурвалжийн мэдээ

1. “Ойд ойрхон нутагладаг аймаг бүрийг л ойн аймагт тооцдог байжээ.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. 2-р дэвтэр. I анги)
2. “...Тусгай мод хийгээд дээр нь зогсон сураар жолоо хийж, гартаа таяг барин усаар хөлөг онгоц явуулах адил таягаараа газар тулан цасан дээгүүр явдаг. Тэд тал, тэгш газар, газрын уруу өөд хурдлан уулын үхэр, бусад амьтныг гүйцэн алдаг.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. 2-р дэвтэр. II анги. УБ., 2002.)



1. Хаана нутагладаг аймгийг ойн аймаг гэдэг байв?
2. Монголын Ойн Урианхай аймгийн хүмүүс цасан дээр явах ямар хэрэглэлтэй байсан бэ? Ойн Урианхай аймгийн эрхлэх гол аж ахуй юу байсан бэ?

### Сурвалжийн мэдээ


1. “Тэдний сууц дугуй хэлбэртэй, майхан шиг хийцтэй бөгөөд нарийн мод мөчрөөр хийдэг. Сууцныхаа дээд оройд гэрэл нэвтрэх бөгөөд гэрийн голд гал түлдэг тул утаа гаргах цонх гаргажээ. Хана туурга үүдээ эсгийгээр хийдэг.” (П.Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988)
2. “Бодончар ... Онон мөрөн рүү зорчиж тавив. Зорчиж Балжун арал хүрч, тэнд өвсөн нэмбүүл гэр хийж, тэнд ав суув.” (МНТ. УБ., 2011. §. 24)



1. Монголчуудын үндсэн сууцыг юу гэдэг вэ?
2. Сурвалжид монгол гэрийг хэрхэн дүрслэн бичсэн бэ? Өвсөн нэмбүүл гэж юу вэ?

Бүдүүвчид малчин, анчин аймгийн амьдралын хэв маягийг харьцуулна уу.

Бүдүүвч 2.4.



**Монголчуудын шашин шүтлэг, соёл.** Монголын аймаг, улсууд шашин шүтлэгийн хувьд өөр өөр байжээ. Тэдний ихэнх нь бөөгийн шашинтан байв. Тиймээс монголчуудын оюуны соёл бөөгийн шашны үзэл санаатай нягт холбоотой байв. Харин Хэрэйд, Найман, Онгуд нар загалмайн шашны несториан урсгалыг шүтдэг байлаа.

Монголчуудын эдийн соёл нүүдлийн мал аж ахуйд үндэслэгдсэн байдаг. Мөн монголчууд тахилга тайлга, баяр ёслолын үеэр бүжиг бүжиж, дуулж, хуурддаг байжээ. Бас бөх барилдаж, сур харван, шагай тоглоно.



1. Монголын аймаг, улсуудын ихэнх нь ямар шашинтай байсан бэ?
2. Монгол угсааны ямар аймгууд загалмайн шашныг шүтэж байв?

### Сурвалжийн мэдээ

1. “Ямар нэгэн аймаг онгон шүтээн болгосон зүйл рүүгээ довтолдоггүй, эсэргүүцдэггүй, махыг нь иддэггүй заншилтай. Учир нь тэд тэрнийг сайны бэлгэдэл болгон авсан билээ.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. 1-р дэвтэр. I анги)
2. “Тэд төлөг үзэхдээ хонины далны ясыг шатааж, гарсан зурхайн сөрөг ба эерэгийг үзэж сайн, муу ёрыг ялгадаг. Тэнгэр ивээх эсэхийг үүгээр тогтоомуй.” (Хар Татарын хэргийн товч. УБ., 2014)
3. “Хэрэйд ... Исүсийн уриа тэдэнд хүрч, тэд үүнийг шүтжээ. Тэд өөрсдөө монголчуудын төрөл овог юм.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. 1-р дэвтэр. 3-р анги)



1. Онгон шүтээн гэж юуг хэлж байна вэ?
2. Бөөгийн шашинтнууд тэнгэр, онгон шүтээнээ хүндэлдгийн учир юу вэ?
3. Төлөг үзэх гэж юуг хэлж байна вэ?
4. Хэрэйдүүд яагаад загалмайн шашныг шүтэх болсон бэ?

### Сурвалжийн мэдээ

“Бүх аймаг тус бүрдээ тодорхой ургийн бичигтэй. Учир нь монголчуудын заншил бол өвөг дээдсийнхээ ураг удмыг хадгалах шинэ төрсөн хүүхэд бүрд түүнийгээ зааж мэдүүлдэг болохоор өөрийн аймаг, уг гарлыг мэддэггүй нэг ч хүн байдаггүй.” (Судрын чуулган. УБ., 2002. I боть. II дэвтэр. I анги)



1. Ургийн бичиг гэж юу бэ? Монголчуудын ургийн бичгийн ач тусыг тайлбарлана уу.

### ДУГНЭЭРЭЙ

2.4

### ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүх судалсан бэ?	Бид хаагуур аялсан бэ?	Талын малчин, ойн анчны аж ахуй, соёлын ялгаа юу вэ?	Малчин, анчин гэсэн ялгаа яагаад гарсан бэ?	Бөө, загалмайн шашны ялгаа юу вэ?
Татар, Хэрэйд зэрэг аймгууд хэдийд оршиж байсан бэ?	Талын малчин, ойн анчин аймаг, улсуудын нутгийг газарзүйн зурагт заагаарай.	Хамтарч тодорхойлно уу.	Саналаа дэвшүүлээрэй.	Ялгааг олж нэрлээрэй.

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Дундад зууны өмнөх үеийг
  - а. Шинэ үе
  - б. Түүхийн өмнөх үе
  - в. Эртний үе
  - г. Ойрх үе гэнэ.
2. Асуултад хариулж, он тооллын шугамд тэмдэглээрэй.
  - а. Ямар эзэнт улсын мөхөл эртний үеийн төгсгөл болсон бэ?
  - б. Эртний үе хэдэн онд дууссан бэ?
  - в. Хэддүгээр зуун, мянганд энэ үйл явдал болсон бэ?
  - г. Энэ үйл явдлаас хойш хичнээн жил өнгөрсөн бэ?

3. Доор дурдсан эх сурвалжуудыг хүснэгтэд ялгаж тавина уу. Яагаад эд өлгийн, бичгийн эх сурвалжид хамааруулж үзсэнээ тайлбарлаарай.

*Чингисийн чулууны бичиг, Хархорумын хотын туурь, Пап ламын бичиг, Өгэдэй хааны зоос*

Бичгийн эх сурвалж	Эд өлгийн эх сурвалж

4. Эргүнэ гүний домогт өгүүлж буй үйл явдал одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ? Он тооллын шугамд тэмдэглэнэ үү.
5. Монгол нутагт Түрэг аймгуудын ноёрхол тогтсон, унасан оныг тодорхойлно уу.
6. Монголчууд Бурхан Халдун ууланд эргэж ирсэн үйл явдал хэддүгээр зуун, мянганд болсон бэ?
7. Эргүнэ гүний Монгол, Гучин татар, Мэн ү Шивэй эдгээр нэрсийн нийтлэг тал юу вэ?
  - а. Нийт монголчуудыг нэрлэх нэр
  - б. Татарын гурван өөрөөр нэрлэж байсан
  - в. Эргүнэ гүний монголчуудыг бүгдийг дуудах нэр
  - г. V-XII зууны Монгол аймаг, улсуудын нэр
8. Монголын аймаг, улсуудыг эрхлэх аж ахуйгаар хэрхэн ангилдаг вэ?
  - а. Тариачин ба талын малчин
  - б. Ойн анчин ба талын малчин
  - в. Тариачин ба ойн анчин
  - г. Бүгд талын нүүдэлчин
9. Монгол аймаг, улсуудын олонх ямар шашин шүтдэг байв?
  - а. Загалмайтны шашин
  - б. Бөөгийн шашин
  - в. Лалын шашин
  - г. Католик шашин
10. Монгол аймаг, улсуудыг газар нутагтай нь тохируулна уу.
 

<ol style="list-style-type: none"> <li>1. Монгол улс</li> <li>2. Монгол Татарын улс</li> <li>3. Найман улс</li> <li>4. Хэрэйд улс</li> <li>5. Онгуд аймаг</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>а. Хангай уулаас Зайсан нуур хүртэл</li> <li>б. Орхон, Сэлэнгийн бэлчрээс өмнө зүг их элсэн говь</li> <li>в. Цагаан хэрмийн хойгуур</li> <li>г. Хөлөн, Буйр нуурын сав газар</li> <li>д. Онон, Хэрлэн, Туулын голын эхэнд</li> </ol>
--	---

<ol style="list-style-type: none"> <li>1. 1б, 2в, 3г, 4д, 5а</li> <li>2. 3. 1г, 2б, 3в, 4а, 5д</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>2. 1д, 2г, 3а, 4б, 5в</li> <li>4. 1а, 2д, 3б, 4в, 5г</li> </ol>
---	--
11. Алангоогийн гурван хүүгээс үүссэн Ниругун овгийн нэрийн учрыг тайлбарлана уу.
  - а. Нуруу гэсэн үг
  - б. Тэнгэр заяат гэсэн үг
  - в. Нарны гэрэл гэсэн үг
  - г. Нүүр царай гэсэн үг



### III БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ӨМНӨХ ДЭЛХИЙ ДАХИН (V-XII ЗУУН)

#### 1. АРД ТҮМНИЙ ИХ НҮҮДЭЛ БА ВАНТ УЛСУУД

Зураг 3.1. Ромын эзэнт улсын Умард хөршүүд.



- Газар зүйн зургийг ажиглаарай.
  - Альпийн нуруунаас умард зүг Ромын эзэнт улстай хил залгаа ямар аймгууд нутаглаж байв?
  - Герман аймгууд хаагуур нутаглаж байв?
- III зууны үеэс Герман аймгууд Ромын эзэнт улсад довтолж, ард түмний их нүүдэл болон өргөжив. Яагаад германчууд аймгаараа Баруун Ромын эзэнт улсын газар нутагт нүүдэллэх болов?

Альпийн нуруунаас умард зүг Европын нутаг дэвсгэрт Кельт, Герман, Славян гурван том аймаг нутаглаж байжээ. Герман аймгууд нийтийн тооллын эхэн үед Одер мөрнөөс Рейн мөрөн, Балтийн тэнгисээс Дунай мөрөн хүртэлх газар нутагт суурьшжээ. Германчуудын нутаг Италитай харьцуулахад хахир, хүйтэн уур амьсгалтай байв.

Германчууд өтгөн зэрлэг ойд ан ав хийх дуртай. Тэд бага сага газар тариалан эрхэлнэ. Арвай, улаан буудай, олс тариална. Германчууд малыг гол баялаг гэж үзнэ. Шар үхэр, агт морьдыг өндөр үнэлнэ. Тэд нүүдэлчид байгаагүй, модоор “урт байшин” барьж, жижиг тосгодоороо амьдарна. “Урт байшин” бүрд нэг том гэр бүл амьдарна. Хоорондоо төрөл гэр бүлүүд нэг овгийг үүсгэнэ. Овгууд нийлж аймаг болно. Аймгууд хүчирхэг дайсныхаа эсрэг холбоо байгуулах нь бий. Аймгийн гишүүн - насанд хүрсэн бүх эрчүүд тэгш эрхтэй. Цөөн тооны боолууд байсан ч “ярьдаг багаж” гэж үздэггүй, гэрийн эзэдтэй нэг дээвэр дор амьдарч байжээ. Аймаг хүн бүрд ижил хэмжээний газар хуваарилна. Гэхдээ газрыг хэн ч зарж, бэлэглэж чадахгүй юм. Аймгууд тинг хэмээх ардын хурлаар удирдагчаа сонгож, гэмтнийг шүүнэ. Германчууд олон бурхан шүтэж, өргөл өргөдөг байжээ. Гэхдээ сүм байгуулж, бурхдын баримал барьж байсангүй.



Зураг 3.2. Германчуудын сууц “Урт байшин”. Тэд сууцаа малынхаа байртай нэгтгэн барьдаг байв.

Ромын баян муж, хотууд эртнээс германчуудын анхаарлыг татдаг байв. Гот, франк, вандал, лангобард зэрэг аймгийн холбоонд нэгдсэн германчууд Ромын эзэнт улсад довтолж, дээрэм тонуул хийдэг байв. Ромчууд тэднийг “варварууд” буюу “бүдүүлгүүд” хэмээнэ. Зарим варвар Ромын армид хөлсөөр зүтгэдэг байжээ.



III зууны үеэс Ромын эзэнт улс доройтож, хилээ хамгаалах хөрөнгөгүй болов. Энэ үед варварууд эзэнт улсад довтлох нь улам бүр ихэсжээ.

Төв Азиас нүүдэллэсэн хүннүүд зам зуур тохиолдсон олон аймгийг цохиж нэгтгэсээр Зүүн Европ хүрчээ. Хүннү нар 370 оны орчим Дон мөрнийг гаталж, Гот аймгуудыг довтлов. Зүүн готууд (остгот) тэдний захиргаанд орж, баруун готууд (вестгот) Ромын эзэнт улсын хилийг даван нүүдэллэжээ. Улмаар Баруун Европын бусад ард түмэн ч нүүх болов. Ромчууд ухран, тэдний орыг эдгээр бүдүүлэг аймгууд эзэлжээ. Ийнхүү Европт “Ард түмний их нүүдэл” хэмээх үйл явдал эхэлж, 400 жил үргэлжилсэн юм.

Хүннү нарын улс 420 оны үед Унгарын тал хээр нутагт төвлөрчээ. Атилла хаанаар удирдуулсан Хүннү нар Визант гүрнээр алба бариулж, Баруун Ромын эзэнт улсад аюул учруулж байв. Сульдан доройтсон Баруун Ромын эзэнт улсад варвар аймгууд үржил шимт газар, дайны олз омогт санаархан цөмрөв. Тэд V зууны эцэст Баруун Ромын эзэнт улсыг мөхөөн нутагт нь тархан суужээ. Вандалууд Хойд Африкт, баруун готууд Испанид, зүүн готууд Италид, франкууд Галлид, англи, саксууд Британийн аралд суурьшиж, өөрсдийн вант улсыг байгуулсан юм.

#### Сурвалжийн мэдээ

1. "Германчууд мал сүргээ өсгөхийг эрмэлздэг бөгөөд аливаа баялгийн цорын ганц, ашигтай төрөл бол мал гэж үздэг".
2. "Тэд алт, мөнгийг үнэлэхийг үл мэддэг, түүнд дургүй болохоор тэрхүү үнэт металлыг огт тоодоггүй байв".
3. "Герман аймгуудад ... үр жимс, мал сүргээсээ сайн дураараа удирдагчдадаа өргөдөг заншил буй бөгөөд түүнийг их хүндэт бэлэг гэж хүлээн авна".
4. "Онц ач холбогдолгүй хэргийг ахмадууд зөвлөлдөж, гойд чухал хэргийг ард түмэн шийдвэрлэх бөгөөд ... саналыг эс зөвшөөрвөл хашхиралдан эсэргүүцэх агаад зөвшөөрвөөс жадаа өргөдөг байжээ". (У.Гонгоржав. Дундад зууны түүхийн дээж бичиг. УБ.,2005)

2

Ʀ Ƨ Ƨ Ƨ Ƨ < X Ʀ Ƨ Ƨ | Ƨ

f u th a r k g w h n i j

Ƨ Ƨ Ƨ Ƨ Ƨ Ƨ Ƨ Ƨ Ƨ Ƨ

cu (?) p z s t b e m l ng o d

I-II зуунд герман аймгуудын дунд үүссэн цагаан толгой. Уг авиан бичгийг руни гэдэг.




Асуултын дагуу уншсан мэдээллийн агуулгыг ярилцана уу.



1. Яагаад германчуудыг “урт байшин”-гийн оршин суугчид гэж нэрлэсэн бэ?
2. Герман аймгуудын ахуй амьдрал, нийгмийн зохион байгуулалт, шашин, соёлын талаар ямар төсөөлөлтэй болсон бэ? Ромын нийгмээс ямар ялгаатай байна вэ?

Ромын нийгэм	Герман аймгууд

3. Ромчууд герман овог, аймгуудыг “варвар” гэж нэрлэсний учир юу вэ?
4. Герман аймгуудын нүүдлийн шалтгааныг тодорхойлно уу?.
5. Хүннү нар тэдний нүүдэлд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
6. Ард түмний их нүүдлийн үр дүнг тайлбарлана уу?



Зураг 3.3. Ромын эзэнт улс ба ард түмний их нүүдэл



Ард түмний их нүүдэл одоогоос хэдэн жилийн өмнө болсныг тооцоолно уу. Энэ үйл явдал хэддүгээр мянганд болсон бэ?	Ард түмний их нүүдлээр Европын газар зүйн зурагт ямар өөрчлөлт гарсан бэ?	Ард түмний их нүүдэл ямар үр дагавартай байв.	
		Ромын эзэнт улс	Герман аймгууд
Он тооллын шугамд тэмдэглээрэй	Газар зүйн зурагт зааж тайлбарлана уу	Дүгнэн ярилцаарай	

## 2. ФРАНК УЛС БАЙГУУЛАГДАЖ, ХҮЧИРХЭГЖСЭН НЬ

Герман аймгууд Баруун Ромын эзэнт улсыг мөхөөв. Тэдний байгуулсан улсуудаас Франк хамгийн ихээр хүчирхэгжжээ. Тус улсын Их Карл хаан Төв, Баруун Европыг нэгтгэн эзэнт улс байгуулсан юм.



Франкууд хэрхэн хүчирхэгжиж, эзэнт улсаа байгуулсан бэ?

### Франк улс байгуулагдсан нь

Франкууд Рейн мөрний доод урсгалаар Ромын Галл мужтай хил залгаа нутаглаж байжээ. V зууны сүүлчээр франк аймгийн нэгэн удирдагч Хлодвиг бусад удирдагч нартай хамтран 486 онд Баруун Ромын цэргийг бут цохин Хойд Галлыг эзлэв. Улмаар баруун готуудаас Галлын өмнөд хэсгийг булаан авч, мөн Рейн мөрний зүүн эргийн Герман аймгуудыг нэгтгэжээ.

Хлодвиг Ромын эзэн хааны эзэмшил газрыг өөртөө авч, нөхөр цэрэг болон ойр дотныхондоо их хэмжээний газар өгчээ. Ийнхүү франкуудын дунд, том газар эзэмшигчид буй болов. Мөн Баруун Ромын зарим боолын эзэн Хлодвигийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрч эзэмшлээ авч үлджээ. Харин тосгодоор тархан суусан жирийн франкуудад гэр бүлийн жижиг ноогдол газар олгосон байна. Франкууд Галлыг эзэлсний дараа хувийн өмч, газраа захиран зарцуулах эрхэд ийнхүү суралцав. Үүгээр германчуудын дунд тэгш бус байдал үүсжээ.

500 оны орчим Хлодвиг ван болж, Франкийн төрийг байгуулав. Франкийн Ардын хурал хуралдахаа болив. Аливаа асуудлыг Хлодвиг ван сурвалжтнуудтай хэлэлцэн шийдвэрлэж, хавар болдог цэргийн үзлэгээр франкуудад танилцуулдаг болов. Мөн Хлодвиг итгэлт хүмүүсээ мужын захирагч гүнгээр томилж, татвар, цэрэг, шүүх хэргийг мэдүүлсэн байна.

Хлодвиг ван эрх мэдлээ бэхжүүлэхийн тулд франкуудын хэв хуулийг бичиглэн улсдаа мөрдүүлжээ. Энэ хуулийг “Саалийн үнэн” гэх ба Европын хэв хуулийн хамгийн эртний эмхэтгэл юм. Саалийн үнэнд франкуудын ахуй амьдрал, зан заншил, сүсэг бишрэлтэй холбоотой олон зүйл заалт оржээ.

Франкуудад эзлэгдсэн Ромын Галл мужийн оршин суугчид загалмайтны шашин шүтдэг байв. Хлодвиг ван нөхөр цэргүүд болон жирийн франкуудыг тус шашинд

оруулжээ. Учир нь загалмайтны сүм хийдүүд ван, төрдөө хүлцэнгүй захирагдахыг сүсэгтэн олонд сурталчилдаг байв. Хлодвиг ван үүний хариуд загалмайтны сүм, хийдэд газар олгож, эд баялгийг нь хамгаалжээ. Сүмийн тэргүүн хамба лам Хлодвиг вангийн зөвлөх болов. Франкууд загалмайтны шашинд орж, тэдний дунд латин бичиг дэлгэрчээ.



Зураг 3.4. Загалмайтны шашинд оруулж буй нь. Номын чимэглэл зураг. IX зуун.



1. Мэдээлэлд гарсан Франк, Саал, Галл хэмээх үгсийг тайлбарлана уу.
2. Франк улсыг газар зүйн зурагт заагаарай. Франк улс өнөөгийн ямар улсын нутагт байсан бэ?
3. Хүснэгтийг нөхөж, агуулгыг танилцуулна уу.
4. Хлодвиг яагаад загалмайтны шашинд орсон бэ?
5. Зураг 3.4-т загалмайтны шашны ямар зан үйлийг харуулсан бэ?

Хлодвиг тэргүүтэй Франкууд	
Галлыг байлдан дагуулахаас өмнө	Галлыг байлдан дагуулсны дараа
- Ардын хурал	-
- Цэргийн жанжин	-
- Журамт цэрэг, нөхөр цэрэг	-
- Эртний заншлын дагуу ардын хурлын шүүх	-
- Онго шүтлэг	-

### Сурвалжийн мэдээ

Франкууд Ромын нутгийг эзлэх үед үзэмж, хэмжээгээрээ гайхагдах аяга олзолжээ. Хлодвиг өөрт оногдох олзны хувь дээр уг аягыг нэмж өгөхийг хүсэхэд цэргүүд нь зөвшөөрчээ. Гэвч нэг цэрэг сүхээр аягыг цавчин “өөрт ноогдох хувиас илүү юу ч чи авахгүй” гэжээ.

Жилийн дараа Хлодвиг цэргүүдээ бүртгэх үеэр нөгөө цэргийн өмнө зогсож, “Хэн ч чам шиг ингэж зэвсгээ хадгалахгүй” хэмээн сүхийг нь газарт зоов. Нөгөө цэрэг сүхээ авахаар тонгойход ван толгойг нь цавчжээ. Тэгээд “Суассоны аягатай чи ингэж хандсан билүү” гэв. Хлодвиг ийнхүү цэргүүдэд айдас төрүүлсний дараа гэр гэртээ харихыг тушаав.



1. Хлодвиг аягыг шууд авалгүй цэргүүдээс яагаад зөвшөөрөл эрсэн бэ?
2. Тэр эсэргүүцсэн цэргийг яагаад шууд цавчаагүй вэ?
3. Жилийн дараа ван Хлодвиг хэрхэн өөрчлөгдсөн бэ?

## Франк улсын хүчирхэгжилт

Франк улс Их Карл вангийн үед хүчирхэгжив. Тэр 768 онд Франк улсын ван болжээ. Их Карл бол нуруулаг, биерхүү, хүч чадалтай, ухаалаг жанжин байв.

Их Карл ван хөрш улс, аймгуудыг эзэлж, загалмайтны шашинт эзэнт улс байгуулахыг зорьжээ. Франк улс хойд, зүүн хойд талаараа Германы Сакс аймагтай, зүүн талаараа славянчуудтай өмнөд талаараа Испани дахь лалын улстай хиллэж байв. Их Карл ван Альпийн нурууг давж лангобардуудыг хоёронтоо довтлон, өнөөгийн Италийн зарим нутгийг нэгтгэжээ.

Мөн лалын улстай дайтаж, Эбро гол хүртэлх Испанийн нутгийг нэгтгэв. Их Карл 796 онд одоогийн Унгарын нутагт тогтож байсан Аварын хант улсыг дагуулав.

Рейн, Эльба мөрний хооронд нутаглах саксууд Франк улсын цэрэгт ялагдсан ч 30 гаруй жил бослого гарган тэмцжээ. Гэвч Саксоны сурвалжтанууд нэгэн цагт Их Карлын захиргааг дагав. Их Карл саксуудыг захирахын тулд тэднийг загалмайтны шашинд хүчээр оруулжээ. Загалмайтны шашинд орохоос татгалзсан 4500 саксыг нэг өдрийн дотор цаазалсан гэдэг.

Лангобардуудыг буулган авсны хариуд 800 онд Пап лам Их Карлыг Ромын эзэн хаанаар өргөмжлөв. Эзэн хаан Их Карл загалмайтны сүмийг тэтгэн дэмжих болов.

Их Карлын явуулсан 50 гаруй аян дайнаар Франк улсын нутаг хуучны Баруун Ромын эзэнт улстай эн тэнцэхүйц болсон байна. Төв, Баруун Европт тогтсон Их Карлын эзэнт улсын нийслэл нь Ахен хот байв. Их Карл эзэн хаан 814 онд нас барж, төрийн эрх хүүд нь шилжжээ.

Их Карлын ач нар нь 843 онд Верден хотод эзэнт улсыг хуваан захирах гэрээ байгуулж, Баруун Франкийн хаант улс, Зүүн Франкийн хаант улс, Лотарингийн хаант улс үүссэн байна. Энэхүү задралаар өнөөгийн Франц, Итали, Герман улсын үндэс тавигдсан юм.

Зураг 3.5. Их Карлын эзэнт улс IX зуун

### ТАЙЛБАР

Славян аймгууд бол чех, словак, польш, болгар, серб, хорват, орос, украин, белорусс нарын өвөг дээдэс юм.

Жужан нарын зарим өрнө зүг нүүдэллэн Унгарын хээр талд очиж төр улсаа байгуулсан юм. Тэднийг өрнийн түүхэнд Авар гэдэг.





1. Дараах асуултын дагуу ярилцаж, газар зүйн зураг, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.
  - а. Их Карл хааны явуулсан дайны зорилго юу вэ?
  - б. Их Карл хааны аян дайн, Франк улсын газар нутгийн тэлэлтийг заагаарай.
  - в. Их Карлыг Пап лам эзэн хаанд өргөмжилсний учир юу вэ?
  - г. Их Карлын байлдан дагуулсны үр дүн юу вэ?
  - д. Верденийн хуваагдал гэж юу вэ? Верденийн хуваагдлаар үүссэн улсыг газар зүйн зурагт заана уу. Одоогийн ямар улсуудын үндэс болсон бэ?

ДҮГНЭЭРЭЙ

3.2

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Франкийн нийгэмд гарсан өөрчлөлт		
		Төр	Эзэнт улс	Хуваагдал
Тооцоолж, он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт заагаарай.	Тодорхойлоорой		

### 3. ДУНДАД ЗУУНЫ ЕВРОПЫН НИЙГЭМ (V-XII ЗУУН)



Дундад зууны Европын нийгэмд мөргөл үйлдэгсэд, тулалдагсад, ажиллагсад гэсэн гурван үндсэн давхарга байв. Эхний давхарга нь сүм хийдийнхэн, хоёр дахь давхарга нь газрын эзэд, гурав дахь давхарга нь тариачид юм. Тэдний нийгмийн байр суурь үе залгамжлагдана. Давхарга бүр бусад давхаргын өмнө үүрэг хүлээнэ.

Европт хот үүсэх хүртэл энэ гурван давхарга бодитой оршиж байв.

*Зураг 3.6. Гурван давхарга Бичээс нь “Чи залбир”, “Чи хамгаал”, “Чи ажилла” гэсэн утгатай. XV зууны зураасан зураг*



Дундад зууны нийгмийн давхаргууд хэрхэн бүрэлдсэн бэ?

Галлыг эзлэх дайнд оролцсон франк эрчүүд ноогдол газартай болжээ. VI зууны эцэс гэхэд тэд ноогдол газраа өмчлөн чөлөөт тариачид болсон байна. Тэд Франк улсын ванд захирагдаж, хэрэгтэй цагт түүний цэрэг болдог байв.

Франк улсын ван Карл Мартелл (715-741) Европт аюул учруулж байсан арабуудын довтолгоог зогсоохын тулд хүнд зэвсэгт явган цэргийг хөнгөн зэвсэгт морин цэрэг болгон шинэчилжээ. Ингэхдээ том газар эзэмшигчид, сүм хийдийн эзэмшлийн газраас хурааж, морин цэрэг болж чадах хүмүүст өгчээ. Хэрэв тухайн цэрэг албанаасаа татгалзвал түүнд өгсөн газрыг буцаан авч дараагийн цэрэг болох хүнд шилжүүлнэ. Тэд газар өгсөн эзнийхээ харьяат болж түүнд алба хаан үнэнч байх тангараг өргөнө. Ийм газар эзэмшлийг болзолт эзэмшил (бенефици) гэнэ. Болзолт эзэмшлийн тогтолцоо эзэн-харьяатын харилцааг үүсгэв.

IX зууны үеэс морин цэргүүд болзолт эзэмшлээ үр хүүхдэдээ өвлүүлэх эрхтэй болжээ. Үүний хариуд үр хүүхэд нь эцгийн цэргийн албыг үргэлжлүүлэн хаах үүрэг хүлээнэ. Ийм эдлэнг феод гэнэ. Феод эзэмшигчдийг феодал хэмээнэ.

Тэр үед хаан феодалуудын дээд эзэн (сеньор) байж, тэдний маргааныг шийдвэрлэдэг байв. Мөн дайны үед хаан бүх цэргийг удирдана. Герцог, гүн (граф) зэрэг газар эзэмшигчид хааны харьяат (вассал) байна. Тэд тус тусдаа цэрэгтэй, зарим нь 100-аад тосгоныг эзэмшиж байжээ.

Герцог, гүнгийн харьяа газар эзэмшигчдийг барон гэнэ. Тэд мөн хэд хэдэн тосгон эзэмшиж, цэрэг гаргана. Рыцарь бол баронуудын харьяат феодал юм. Феодалууд газраа зөвхөн ахмад хүүдээ өвлүүлэх болсноор XI зууны үеэс газаргүй, хэрэн тэнэгч рыцариуд буй болов. Тэд бусдыг тонон дээрэмдэж, алдар нэр, олз омог олж байжээ.

Эзэн ба харьяатууд харилцан үүрэг хүлээдэг. Харьяат феодалууд эзэндээ үнэнчийн тангараг өргөнө. Эзнийхээ дуудсан цагт цэргийн хамт хүрэлцэн ирэхээс



гадна эзний шүүхэд оролцож, шаардлагатай бол мөнгөн тусламж үзүүлнэ. Харин эзэн нь харьяат феодалуудаа өмгөөлөн хамгаалах үүрэгтэй байв.

Хааны тушаалаар герцог, гүнгүүд цэрэгтэйгээ, тэдний тушаалаар баронууд цэрэгтэйгээ, бароны тушаалаар рыцариуд дайнд орно.

Ихэнх чөлөөт тариачин өөрийгөө зэвсэглэн морьд засаж цэрэг болж чадахгүй байв. Морин цэрэг болж, болзолт эзэмшил авч чадаагүй тариачид алба гувчуур төлж, цэргийн хэрэгцээг хангах болжээ. Алба гувчуур, язгууртнуудын хавчлага, дайн дажин олон тариачдыг хоосруулав. Хоосорсон тариачид, ерөнд орсон хүмүүс өөр хүчирхэг нэгний ивээлд орно. Ийнхүү хөршийн хүй нэгдлийн тариачид том газар эзэмшигчдээс хараат болжээ. Хараат тариачдын дунд хуучны колониуд (Ромын үеийн чөлөөлөгдсөн боол) байв.

Феодалын эзэмшил газар эзний эдлэн ба хараат тариачдын ноогдол газраас бүрдэнэ. Тариачид газрын эзэн болон өөрийн ноогдол газар дээр ажиллана. Харин газрын эзэн өөрийн талбайн ургацаас гадна тариачдаас бүтээгдэхүүний алба авч байв. Мөн хараат тариачид эзнийхээ бусад ажлыг ч үнэ хөлсгүй гүйцэтгэдэг байжээ.




1. Мэдээлэлд гарсан бенефици, феодал, феодал хэмээх үгсийг тайлбарлана уу.
2. Карл Мартеллын үеэс Франкийн нийгэмд ямар өөрчлөлт гарсан бэ?
3. Нийгмийн дээд хэсэг ямар бүтэцтэй болсон бэ? Бүдүүвчийг гүйцээнэ үү.
4. Эзэн, харьяатын үүргийг ялган бичнэ үү.


Эзний үүрэг	Харьяатын үүрэг

5. Хараат хүн амын давхарга хэрхэн бүрэлдсэн талаар ярилцаж, бүдүүвч 3.3-ыг гүйцээнэ үү.

Бүдүүвч 3.2. Феодалын шатлал



Бүдүүвч 3.3.




### Феодалын бутрал

Хааны хүчирхэг нэгдмэл засаг аажмаар суларч, том язгууртнууд (феодалууд) аж ахуй, цэргийн талаар биеэ даан орших болсноор феодалын бутрал гардаг.

Яг ийм шалтгааны улмаас Франкийн эзэнт улс задарсан юм.

843 онд Верденийн гэрээгээр Франкийн эзэнт улс гурав задрав. Мөн тэр гурван улс дотроо феодалын олон эзэмшилд хуваагдав. Феодалууд хүн амаас татвар авч, тариачдыг шүүн шийтгэдэг байв. Мөн бусадтай дайтах, найрамдахыг бие даан шийднэ. Баруун Франкийн вант улсад (IX зуунаас Франц гэгдэх болов.) 14 ийм эзэмшил байв.

Зураг 3.7. Их Карлын эзэнт улсын задрал



Верденийн хуваагдлаар үүссэн өөр нэг улс нь Зүүн Франкийн вант улс (Герман) байв. 955 онд Германы I Оттон хаан улсад нь аюул учруулж байсан Унгарын тал хээрт нутаглах нүүдэлчдийн довтолгоог бүрмөсөн зогсоов. 961 онд Ромын Пап лам Италийн хаанаас (Лотарыг залгамжлагчид) хамгаалахыг I Оттоноос хүсэж, хариуд нь эзэн хааны титэм амлажээ. 962 онд I Оттон хойд Италийг нэгтгэж, Ромын Пап ламаас эзэн хааны титэм хүртэв. Түүний байгуулсан улсыг Ромын эзэнт улс гэнэ. Тэрээр Италийг эзэлж, хуучны Ромын эзэнт улсыг сэргээхийг хүсэж байсан тул улсаа ийнхүү нэрлэжээ. XII зууны үеэс Ариун Ромын эзэнт улс гэх болжээ. Гэвч эзэнт улс дундад зууны турш тархай бутархай байсан юм.



1. Дараах асуултын дагуу ярилцаж газар зүйн зураг мэдээллээс юу мэдэж авснаа эргэцүүлээрэй.
  - а. Феодалын бутрал гэж юу вэ?
  - б. Феодалын бутралаар Их Карлын эзэнт улс хэд хуваагдсан бэ? Газар зүйн зурагт заан тайлбарлана уу.
  - в. Ариун Ромын эзэнт улс хэрхэн байгуулагдсан бэ?

ДүГНЭЭРЭЙ

3.3

ҮНЭЛЭЭРЭЙ

Феод, феодал, феодалын бутрал гэж юу вэ?	Европт гарсан өөрчлөлт	
	Нийгмийн давхарга	Газрын харилцаа
Ухагдахууныг тайлбарлана уу.	Нэрлээрэй	Хамтарч тодорхойлно уу.

## 4. ЗАГАЛМАЙТНЫ ШАШИН БА СОЁЛ

476 онд загалмайтны шашинт Ромын эзэнт гүрэн онго шүтлэгт бүдүүлэг аймгуудад эзлэгдэж мөхөв. Ромын соёлын үнэт зүйл ихээхэн устгагджээ.



Загалмайтны сүм, хийд, лам нарын хувь заяа хэрхсэн бол...?

Франк улсын Хлодвиг ван загалмайтны сүмд газар олгон сүм, хийд барих, шашны үйл хэргээ явуулахад нь туслан дэмжжээ. VIII зууны сүүл гэхэд тус улсад загалмайтны шашны 250 орчим сүм байв. Тодруулбал, бүх хот, тосгон сүмтэй болж, лам нар бурхны ном айлдаж шашин номын зан үйл хийх болов. Сүмийн албан хаагчдыг тахилч лам нар гэнэ. Ийнхүү загалмайтны шашны лам нарын тоо өсөж, сүм, хийд бэхжин Франк улсад байр сууриа эзэлжээ. Баруун Европын анхны хийдийг Гэгээн Бенедикт үндэслэсэн гэдэг. Тэрээр хийдийн дүрмийг зохиожээ.

Тэрүү дундад зуунд Европ байнгын дайн дажинтай байсан тул хүмүүс сүм, хийдэд очиж бурхнаас аврал өршөөл эрнэ. Тэдний дундаас мөргөл хийж насыг бардаг хүмүүс буй болов. Зарим нь ахуй амьдралаас холдон цөл, уул, агуйд даяанчлан амьдарч, бурханд өөрийгөө зориулах боллоо. Хожим тэд хийдэд шавилан сууж, хийдийн дүрэмд захирагдан аж төрөв. Тэднийг хар лам нар (монах) гэнэ. Том хийдийн тэргүүнийг ширээт лам гэнэ. Хийдийн ширээт лам нар харьяалах мужийн хамба ламд захирагдана. Тэдний оройд Пап лам заларч байлаа. IV зууны сүүлч, V зууны эхээр Ромын тэргүүн хамба өөртөө Пап лам буюу загалмайтны сүмийн тэргүүн хэмээх цол хүртээв. Ингэж лам нарын давхарга бүрэлджээ.

Загалмайтны шашны сүм, хийдүүд том эзэмшил газартай байв. Хийдийн эзэмшилд хийдийн барилга, лам нарын сууц, сургууль, эмнэлэг, агуулах, халуун усны газар, дэн буудал, дархны газар, уушийн газар, цэцэрлэг бий. Хийдүүд тэр үеийнхээ соёл, боловсролын төв байжээ. Хийдийн сургуулиудад лам нарыг бэлтгэж байв.

Франк улсын ван намхан Пипин Пап ламын хүсэлтээр хоёр удаа Итали руу аян дайн хийж, Ромд заналхийлж байсан лангобардуудыг (Хойд Итали дахь зүүн готуудын орыг эзэлсэн герман аймаг) бут цохив. Тэрээр Ромоос Равенна хот хүртлэх Италийн газар нутгийг Пап ламд өгчээ. Ийнхүү 756 онд Ромын Пап ламын улс байгуулагдлаа.

### Сүмийн хуваагдал.

XI зууны эхээр Европын ихэнх оронд загалмайтны шашин дэлгэрчээ. Баруун, Төв Европын орнуудын сүм хийд Ромын Пап лам, Зүүн Европ, Балканы хойгийн орнууд Константинополийн патриарх (Зүүн Ром буюу

Зураг 3.8. Загалмайтны сүмийн хуваагдал



Византийн загалмайтны сүмийн тэргүүн хамба ламд) захирагдаж байв. Ромын Пап лам Константинополийн сүмийн бие даасан байдлыг эсэргүүцэв. Харин Константинополийн сүм Ромын Папын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байжээ. 1054 онд Ромын Пап лам, Константинополийн патриархийн тэмцэл дээд цэгтээ хүрч, загалмайтны сүм Католик (ертөнцийн) ба Үнэн алдартны сүм гэж хуваагдав. Энэ үйл явдлыг түүхэнд схизм (сүмийн хуваагдал) гэдэг. Хоёр сүмийн зан үйлд зарим ялгаа бий болжээ. Католик сүм латин хэлээр, Үнэн алдартны сүм грек хэлээр ном айлддаг. Католик сүм бүх лам нарт гэрлэхийг зөвшөөрдөггүй бол үнэн алдартны сүм зөвхөн хар лам нарт хориглодог байна.

**Каролингийн сэргэн мандалт.** IV-V зууны бүдүүлэг аймгуудын довтолгоонд эртний грек-ромын соёл сүйдэж, 400 гаруй жил уналтад оржээ. Энэ үеийг түүхчид хожим “харанхуй зуун” хэмээн нэрлэжээ. Их Карлын үед соёл сэргэн хөгжив. Их Карл хаан Ромын эзэнт улсыг сэргээн байгуулах агуу зорилго тавьсан тул эн түүрүүн Грек-ромын соёлыг сэргээв. Уг үйл явдлыг түүхэнд Каролингийн сэргэн мандалт гэнэ.

Их Карл Европын боловсролтой хүмүүсийг ордондоо урив. Хааны ордонд шашны сургууль нээж, Алкуин лам багшлан сурах бичиг зохиожээ. Том хийдүүдийн дэргэд ч сургууль нээгдэв. Сургуулиудад 7 чөлөөт урлагийг судална. Мөн Их Карлын үед шинжлэх ухаан, уран зохиолыг судлах Академи байгуулагдсан байна. Академийн гишүүд шашин, гүн ухааны зохиол, шастир, туульсийн яруу найргаас уншиж, марган мэтгэлцдэг байв.




Том хийдүүдэд урлан байгуулагдаж, ном хуулан бичдэг болов. Урьдын адил пергамент (тугалын арьс) ашигладаг байсан ч орчин үеийн номын хэлбэрт оруулжээ. Пергамент маш үнэтэй, Библийг хуулан бичихэд 300 тугалын арьс орсон гэдэг. Гар бичмэл ном бүтээхэд их хугацаа орохоос гадна олон хүний хөдөлмөр шаарддаг байв.

Зураг. 3.9. Номын чимэглэл зураг

VI-VIII зуунд Баруун Европт ард түмний түүхийг өгүүлсэн шастир зохиогджээ. Турын Григорий (538-594) франкууд, Сивилийн Исидор гот, вандалуудын түүхийг бичсэн байна. Бага Диониси гэгч лам Христийн тооллыг зохиосныг Ирландын лам Беда “Английн сүмийн түүх” бүтээлдээ анх ашигласан байдаг.

Нэр нь үл мэдэгдэх найрагчид алдарт туульсийн яруу найргийг туурвижээ. Түүний нэг нь ам дамжигдан ирсээр XI зуунд бичиглэсэн



“Роландын дуулал” юм. Роландын дүрээр эзэндээ үнэнч байх тангаргаасаа үл няцаж, амиа өгч байгаа шударга, сайхан сэтгэлт, баатар зоригт рыцарийн дүрийг мөнхөлжээ.

### Сурвалжийн мэдээ

Лам ванг (Хлодвиг) дуудаж, ... онго шүтээнээ орхиж, газар тэнгэрийг бүтээгч жинхэнэ бурхныг (Христийг) шүтэхийг нууцаар ятгаж эхлэв. ... Ван тэргүүн ламаас хамгийн түрүүн загалмай зүүж өгөхийг гуйжээ. Түүний цэргүүдээс гурван мянга гаруй хүн христосын шашинд орж загалмай зүүжээ. (У.Гонгоржав. Дундад зууны түүхийн дээж бичиг. УБ., 2005)

### Тодруулга

Ромын Папын улс өдгөө Ватикан гэсэн нэртэй оршиж байна. Тус улс Итали улсын нийслэл Ром хотын дотор 0.44 км<sup>2</sup> талбай эзлэн оршдог, хамгийн бага газар нутаг, цөөн хүн амтай улс юм.

### Тодруулга

VI зуунд Италийн лам бага Диониси “Исүс Ром хот байгуулагдсанаас хойш 753 дахь жилийн 12-р сарын 25-нд төрсөн гэж тооцоолжээ.” Өөрөөр хэлбэл, Христийг мэндлэхээс 753 жилийн өмнө Ром хот үүссэн байна.




Асуулт даалгавар.

1. Лам нарын давхарга хэрхэн бүрэлдсэн бэ? Загалмайтны шашны лам нар ямар эрэмбэ, дэс дараатай байсныг бүдүүвчээр харуулна уу.
2. Түүрүү дундад зууны үед сүм хийд ямар үүрэг гүйцэтгэж байсан бэ?
3. Пап ламын хот улс хэзээ, хаана байгуулагдсан бэ?
4. Хүснэгтийг нөхөж бичээрэй.

Загалмайтны сүм хуваагдсан он цаг	Загалмайтны сүмийн хуваагдлын шалтгаан	Зан үйлийн гол ялгаа

5. Газар зүйн зурагт католик ба үнэн алдартны шашны төвийг заагаарай.
6. Каролингийн сэргэн мандалт гэж юу вэ?
7. Христ мэндэлснээс эхэлсэн тооллыг хэн зохиосон бэ? Өнөөдөр христ мэндэлсний хэдэн он бэ?

Бүдүүвч 3.5. Лам нарын давхарга



### ДҮГНЭЭРЭЙ

### 3.4 ҮНЭЛЭЭРЭЙ

Баруун Ромын эзэнт улс мөхсөн, Пап ламын хот улс байгуулагдсан, загалмайтны сүм хийд хуваагдсан үйл явдлын хугацааг зуунаар илэрхийлээрэй.	Өнөөдөр Ромын Папын мужийн газар нутагт ямар өөрчлөлт гарсан бэ?	Загалмайтны шашны лам нарын давхарга
Он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт заана уу.	Нэрлэнэ үү.

## 5. ВИКИНГҮҮД БА ЕВРОПЫН УЛСУУД

Зураг 3.10. Викингүүдийн довтолгоо VIII-XII зуун

Баруун Европт “хойд нутгийн хүмүүс” буюу норманнчууд гэгдэх германаймгууд нь орчин үеийн норвеги, швед, дани, исландчуудын өвөг дээдэс юм. Тэд Ютланд, Скандинавын хойг, Балтийн тэнгисийн арлуудаар нутаглаж байжээ. Скандинавын хойг нь уулархаг, ой модоор баян, газар тариаланд тохиромжтой газар нутаг хомс байв. Өвөл хахир хүйтэн, урт тул нөөцөлсөн хүнс, малын өвс, тэжээл хүрэлцэхгүй байх нь бий. Норманнчууд эртнээс тэнгистэй нөхөрлөжээ. Умард тэнгис, Балтийн тэнгисээр аялж, загас олборлоно. Тэд Европын хамгийн шилдэг далайчид байв.


Тэд 20-40 хүн багтах овор бага, бат бөх, хурдан явагч хөлөг онгоц барьж, онгоцны хошууг домгийн амьтны сийлбэрээр чимэглэнэ. Норманнчууд оддоор зүг чигээ баримжаалж, алс холын аянд ч зориглон мордож байв. IX зууны эхээр тэд Фарерийн арлууд хүрч, харин IX зууны сүүлчээр Исланд арлыг нээжээ.

Адал явдал, аюултай нүүр тулгарах дуртай хамгийн зоригт эрчүүд алс холын аянд мордож байв. Тэднийг викингүүд гэнэ. Викингүүдийн дунд гэмт хэрэгтнүүд, эх орноосоо хөөгдөгсөд ч байжээ.

X зуунд Исландын Улбар шар хочит Эйрикээр удирдуулсан викингүүд Гренланд арлыг нээж, өөрсдийн сууринг үндэслэн байгуулжээ.

Улбар шар Эйрикийн хүү Лейв эцгийнхээ адил алс холын аянд аз сорих дуртай нэгэн байв. Түүний удирдсан викингүүд 1000 оны үед баруун зүг аялж, олон сар аялсны эцэст нэгэн үл таних эрэгт тулж иржээ. Голын усанд нь яргай загас сүрэглэж, нарлаг ойд нь усан үзмийн бут ургасан энэ нутгийг тэд Винланд (усан үзмийн орон) гэж нэрлэв. Энэ нь Хойд Америкийн эрэг байв. Археологчид Ньюфаундленд аралд викингүүдийн сууринг малтан шинжилсэн байдаг. Лейв бол Шинэ тив хүрсэн анхны европ хүн юм.

Викингүүд мөн Балтийн тэнгис, баруун Двина голоор аялж, славянчуудын нутагт хүрчээ. Славянчууд тэднийг варягууд гэнэ. Варягууд Ижил мөрнөөр Каспийн тэнгис, харин Днепр мөрнөөр Хар тэнгис хүрч, улмаар Константинополь, Иерусалим хүрч



байжээ. Варягуудаас бүрдсэн хөлсний цэргүүд Константинополийн эзэн хааны ордонд алба хашиж байв.

VIII-XI зууны туршид норманнчууд Европыг түйвээж байхад тэдний амьдрал “Ард түмний их нүүдлийн” үеийн герман аймгуудтай олон талаар ижил байсан юм. Аажмаар чөлөөт хүмүүсийн дунд тэгш бус байдал гүнзгийрч, нөхөр цэргийн удирдагч – конунг нарын эрх мэдэл өсөв. Ардын хурал тинг ч ач холбогдлоо алдав.


XI зуунд викингүүдийн довтолгоо аажмаар хумигджээ. Европт суурьшсан норманнчууд улсаа байгуулж, Скандинавын хойгт ч төрт улс бүрэлдэн тогтов.

Зураг 3.11. Лейв Эриксоны аялал



1. Норманнчуудыг юу тэнгисийн аянд түлхэв?
2. Викингүүд гэж хэн бэ?
3. Викингүүдийн тэнгисийн аян дайны чиглэлийг газар зүйн зурагт заана уу.
4. Яагаад Лейв Америк тивийг нээсэн атал алдар гавьяа нь Колумбид оногдсон бэ?

### АНГЛИ, САКСЫН ВАНТ УЛС



Англи, саксууд Их Британийн аралд бэхжээд удаагүй байв. Викингүүд 793 онд арлын зүүн хойд хэсэгт анх довтолж, Денло (Данийн эрхэт муж) мужийг байгуулжээ. Тэд Ирландын зүүн эргийг эзлэн авч, Дублин хотыг байгуулав. Англичууд 300 жилийн турш норманнчуудын довтолгоог эсэргүүцэн тэмцэв. Эгберт вангийн үед 829 онд англи, саксууд нэгдэж, Англи гэгдэх болжээ. Түүний хүү Английн ван Их Алфред (849-900) викингүүдтэй тэмцэхийн тулд усан флот байгуулав. Тэрбээр



Английн хүн амыг загалмайн шашинд оруулж, вангийн эрх мэдэл дор нэгтгэжээ. Английг мужид хуваан эртний хуулиудыг эмхэтгэсэн нь “Альфред вангийн үнэн” юм. Вангийн шүүх байгуулав. Альфредын үед олон хүнийг Францад сургаж, боловсрол олгож байв. Хожим түүнийг агуу Альфред гэх болсон юм.

Викингүүд XI зуунд Английг бүхэлд нь эзэлсэн ч Францын Норманд мужид суурьшсан өөр нэгэн норманнчуудад шахагджээ. Тэдний удирдагч Роллон Францын вангаас Норманд мужийг цэргийн алба хаах болзолтойгоор үе залгамжлан эзэмших эрх авчээ. Нормандын Байлдан дагуулагч хочит Вильгельм 1066 онд Их Британийн аралд бууж, Английг эзлэн авч, шинэ угсааг үндэслэсэн юм. Викингүүдийн үр удам нормандчууд Неаполь, Сицили арлыг эзэлж, улмаар Хоёр Сицилийн вант улсыг байгуулсан ажээ.

### Сурвалжийн мэдээ

Франко Роллонд ингэж хэлэв: “Роллон чи Руандийн удирдагч билээ ...Биеэ авч явах байдлаа өөрчлөгтүн. Хүч чадал, эр зоригоо харуул... загалмайтны шашинд орж, хаанд талархаж яв. Тэр сурвалжит охиноо чамтай гэрлүүлэхийг хүсэж байгаа билээ. Чи хааны охинтой гэрлэж, ...газар нутагтай болно, жил бүр арвин орлого, сайхан орд харштай болж, дээрэм хийх шаардлагагүй болно” ...Роллон Франкогийн хэлэхийг сонсов. ...Түүний үгийг дагаж, эвлэрэхийг зөвшөөрөн (Карлтай), гэрээг... баталгаажуулав. Роллон хааны харьяат болж, хааны гараас адис хүртэв. Дараа нь хааны өлмийг үнсэх байсан авч бөхийсөнгүй, харин хөлийг нь өргөтөл Карл хаан онхолдон унажээ. Бүгд шоолон инээлдэж, Карл ч босч ирэв. Хаан олны өмнө охиноо Нормандын хамт Роллонд өгөв.

*(XII зууны зохиогч Роберт Васын “Роллоны тухай өгүүлэл”-ээс)*



Он тооллын шугам, сурах бичгийн 27-р талын газар зүйн зургийн мэдээллийг уншиж, асуултад хариулаарай.

1. Их Британийн арлын уугуул оршин суугчид хэн байсан бэ? Ромчууд хэзээ арлыг эзлэн авсан бэ?
2. Ард түмний их нүүдлээр аралд ямар өөрчлөлт гарсан бэ?
3. Викингүүдийн довтолгоо Англид ямар үр дагавар авчирсан бэ?
4. Альфред ванг яагаад агуу гэх болсон бэ? Түүний шинэтгэлүүдийг нэрлэнэ үү.
5. Норманд, Денло гэдэг нэршил хэрхэн үүссэн бэ?
6. Нормандчуудын Европт байгуулсан улсуудыг газар зүйн зурагт заана уу. 38 дугаар талын газар зүйн зургийг ашиглаарай.
7. Эх сурвалжид түүхэн ямар үйл явдлын тухай өгүүлж байна вэ? Норманд нутаг хаана байдаг вэ? Газар зүйн зурагт заагаарай.

ДҮГНЭЭРЭЙ

3.5


ҮНЭЛЭЭРЭЙ

Норманн, викинг хэмээх үгийн утгыг тайлбарлана уу.	Норманнчуудын ахуй амьдрал, нийгмийн зохион байгуулалтын талаар ямар төсөөлөлтэй болсон бэ?	Викингүүдийн аян дайн ямар үр дагавартай байсан бэ?	
		Европчуудын хувьд	Викингүүдийн хувьд
		Хамтарч тодорхойлно уу.	



## 6. ВИЗАНТИЙН ЭЗЭНТ УЛС

Зураг 3.12. Византийн эзэнт улс VI зуун



1. Газар зүйн зургийг ажиглан 395 онд Ромын эзэнт улсын задралаар Византийн эзэнт улсын бүрэлдэхүүнд үлдсэн мужуудыг заана уу.
2. Бүдүүлэг аймгуудын довтолгоо Византийн эзэнт улсад ямар үр дагавартай байсан талаар асуулт гаргаж, асуудал дэвшүүлээрэй.

Баруун Европт Зүүн Ромын эзэнт улсыг Византийн эзэнт улс, хүн амыг нь грекчүүд гэдэг байжээ. Гэхдээ эзэнт улсын албатууд өөрсдийгөө ромчууд (грекээр –“ромеи”) харин улсаа Ромын эзэнт улс гэдэг байв. Визант газар тариалан, гар урлалын эртний төв байлаа. Византад олон хот байв. Хамгийн томд орох Константинополь, Александри хот нийтийн байгууламж, олон давхар орон сууцтай. Хотын гудамжийг эртний грек-ромын уран баримал, нуман хаалга, усан оргилуураар чимэглэжээ. Византийн хотуудад шилэн сав суулга, торго, гоёл чимэглэл, папирус үйлдвэрлэх гар урлалын салбарууд хөгжиж байв. Хотын зах дээр Испаниас Хятад хүртэлх газар газрын худалдаачид цугларна. Константинополь хот Европ, Азийг холбосон “Алтан гүүр” гэгдэж байлаа. Византийн худалдаачид өрнө дахинд тансаг хувцас, гоёл чимэглэл, халуун ногоо, үнэт дарс, зэр зэвсэг, сав суулга, шашны эд зүйлс, бурхны хөрөг худалдаална. Византийн алтан “номисма”-г (4.55 гр жинтэй алтан зоос) гүйлгээнд түгээмэл хэрэглэнэ.

Баруун Европын орнуудаас ялгаатай нь Визант нь дангаар захирах эзэн хаант нэгдсэн улс байв. Тэрээр дээд шүүгчийн үүрэг гүйцэтгэж, цэргийн жанжин, дээд түшмэдийг томилно. Эзэн хааны мэдэлд хөлсний цэрэг бүхий хүчирхэг арми, флот байлаа.

Визант улс нь грекийн соёл, боловсролын төв байв. Сүм хийдээс гадна хувийн ба улсын бага, дунд сургуульд олон хүүхэд суралцаж, Гомерийн яруу найраг, Эзопийн үлгэрийг уншиж судалдаг байв. Шинжлэх ухааны өлгий Афин хот хамгийн алдартай нь юм. Грек-ромын математикийн мэдлэгийг одон орон, барилга, татвар санхүүгийн салбарт ашиглаж байв. XI зуунд Константинопольд хийдийн дэргэд эмнэлэг байгуулагдав. Анхны анагаах ухааны сургууль нээж, анагаах ухааны гарын авлага гаргажээ. Нефть, давирхайн хольцоор “Грекийн гал”-ыг бүтээж, дайн, тулаанд хэрэглэх болов. Газар зүйн зураг, хотын дэвсгэр зураг зохиов. Эх сурвалж, үйл явдалд оролцогчдын ярианд үндэслэн түүхийн зохиолуудыг бүтээн туурвижээ.

Зураг 3.13. Грекийн гал. Номын чимэглэл зураг



### Сурвалжийн мэдээ

“...Тэнд сүм бий...тэнд мөн грекийн пап лам бий, тийм учраас тэд ромын папт захирагдахгүй. Түүний баялгийг тоолохын аргагүй, хот, цайз бүхий хоёр том арлаас алба өргөнө. Дэлхийн нэг ч сүмд ийм баялгийг олж харахгүй биз ээ. Сүмийн дотор баганат танхим, тоо томшгүй олон алт, мөнгөөр хийсэн зул асаажээ. Ордны дэргэд хааны зугаа цэнгэлийн газар – морин тойруулга бий. Жил бүр Христийн мэндэлсэн өдөр хааны зарлигаар тэнд их үзвэр зохион байгуулна. Хаан, хатанд зориулан тоглолт хийж, олон хүн оролцон, арслан, барс, баавгай, луус, заримдаа шувуудын тоглолт үзнэ. Дэлхийн хаана ч ийм цэнгэлийг үзэхгүй. (1117 оны 12 сард Константинополь хотод айлчилсан Туделийн Венаминий тэмдэглэлээс)



Асуулт даалгаврыг гүйцэтгэж уншсан мэдээллийн агуулгыг танилцуулна уу.

1. Византийн нийслэл Константинополь хотыг газар зүйн зургаас олж, яагаад “Алтан гүүр” гэж нэрлэснийг тайлбарлана уу.
2. Византийн худалдаачид Баруун Европт ямар барааг худалдаалдаг байсан бэ?
3. Византийн томоохон хотуудын дүр төрх, өдөр тутмын амьдралын талаар ямар төсөөлөлтэй болсон бэ?
4. Яагаад VI-XI зууны үед Византид шинжлэх ухаан, боловсрол Баруун Европоос өндөр хөгжсөн бэ?
5. Винаминий тэмдэглэлд Византийн тухай юу өгүүлсэн бэ?

## Юстиниан хааны үеийн Византийн эзэнт улс

Византийн эзэнт улс Юстиниан (527-565) хааны үед ихэд хүчирхэгжив.

I Юстиниан хаан Ромын эзэнт гүрний газар нутгийг сэргээх зорилгоор аян дайныг эхлүүлжээ. 534 онд тэрээр Хойд Африкийн Вандалын улсыг мөхөөв. Юстинианы цэрэг Сицили арлыг эзлээд зүүн готууд ноёрхож байсан Италийн ихэнх хэсгийг эзлэн авчээ. Италид Равенна төвтэй онцгой мужийг байгуулав. Улмаар Испанид довтолж, Испанийн өмнөд муж, Гибралтарын хоолойг нэгтгэжээ.



Зураг 3.14. Агуу Юстиниан, түүний хатан Феодорагийн шигтгэмэл хөрөг. Италийн Равенна хотын Сан Витале сүм. VI зууны дунд үе.

Эзэн хаан I Юстиниан эзэнт улсдаа олон шинэчлэл хийсэн юм. Эзэнт улс даяар олон сүм, бэхлэлт, ордон, байгуулжээ. Юстинианы үеийн хамгийн гайхамшигт байгууламж бол Константинополь хот дахь Гэгээн Софийн сүм юм.

Тоосгоор барьсан сүмийг ховор гантигаар доторлож, загалмайтны шашны бэлгэдэл, хээ угалз бүхий шигтгэмэл зураг, бурхны хөргөөр чимэглэжээ. Сүмийн үлэмж том бөмбөгөр оройн диаметр 31,5 м юм. Бөмбөгөрийн хормойгоор олон цонх гаргасан байна. Сүмийн доороос бөмбөгөр орой руу харахад нарны тусгал, алслалтаас болж, цонх хоорондын зай төдийлөн ялгарч харагдахгүй, бөмбөгөр орой сүмийн дээр ямар ч тулгуургүй хөвөх мэт харагдана. Гэгээн Софийн сүмийн бөмбөгөр оройг тэнгэрээс алтан гинжээр дүүжилсэн гэлцдэг байжээ. 537 онд сүмийг барьж дуусгасан байна.

I Юстиниан хаан эртний Ромын хуульч нарын бүтээлийг цуглуулж, эмхэтгэн гаргасан нь орчин үеийн олон орны иргэний хуулийн үндэс болсон билээ. Юстиниан хааныг өөд болсны дараа Византийн эзэнт улс олон жилийн турш славян, араб, түрэгүүдийн довтолгоонд өртөж, загалмайтны аян дайны хөлд нэрвэгджээ.

VI зууны эхэн үеэс славянчууд Византийн эзэнт улсад довтолох болов. Славяны зарим аймаг аажмаар эзэнт улсын Балканы хойг, Македон, Грек мужид суурьшжээ. Тэд эзэнт улсын албатууд болж, эзэн хааны цэрэгт алба хааж байв. VII зуунаас Византийн өмнөд талаас арабууд довтолжээ. Тэд Палестин, Сири, Египетийг булаан эзэлж, зууны сүүлчээр Хойд Африкийг бүхэлд нь эзэгнэв. Эзэнт улсын газар нутаг Юстиниан хааны үеийнхээс гурав дахин багасжээ. Византийн мэдэлд зөвхөн Бага Ази, Балканы хойгийн өмнөд хэсэг, Италийн зарим муж үлдсэн байна.



Дараах асуултын дагуу ярилцаж, мэдээлэл, газар зүйн зургаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Юстиниан хааны аян дайн, байлдан эзэлсэн газар нутгийг газар зүйн зурагт заана уу.
2. Юстиниан хаан ямар шинэтгэлүүд хийсэн бэ?
3. Константинополь хотод ямар байгууламжууд байсныг нэрлэнэ үү.
4. Византичууд сүмийн чимэглэл урлагт ямар хувь нэмэр оруулсан бэ?
5. Византийн эзэнт улс Юстиниан хаанаас хойш ямар бэрхшээлүүдтэй нүүр тулав?

Зураг 3.15. Византийн эзэнт улс VI зуун



### Сурвалжийн мэдээ


Византийн ард түмэн гэнэт бослого гаргаж, удалгүй хот дайсны довтолгоонд өртсөн мэт галд автсан байна. Софийн сүм, Зевксиппийн халуун усны газар, хааны ордон гэх мэт олон газар түймэрт өртөж...баячуудын хөрөнгө зоорь, байшин сав юу ч үгүй болтлоо галд шатав. Хаан, хатан зарим шадар албатын хамт Палатийн толгодод нуугдаж, хүлээхээс өөр аргагүйд хүрчээ. Босогчид цөмөөрөө “Ника! Ника!” (“Ялалт! Ялалт!”) хэмээн уриалан хашхирч байсан учраас бослогыг “Никагийн бослого” хэмээжээ.

Энэ үед хаан юу хийх хэрэгтэй вэ?, энд үлдэх үү? эсвэл хөлөг онгоцоор зугтах уу? гэх зэргээр олон асуудлыг хэлэлцжээ. ...Феодора хатан “...Миний бодлоор зугтах нь магадгүй хэзээ нэгэн цагт аврал болсон байх, мөн одоо ч гэсэн аврал болох бизээ. Ертөнцөд ирсэн хэн бүхэн үхэшгүй мөнх амьдарна гэж байдаггүйн адил хаан ширээнд суусан хэн ч бай зугтах нь гутамшигт хэрэг билээ. Эрх мэдлээ орхин явбал эргээд ирэхэд эзэгтэй, хатан гэж дуудахгүй ч байж болно. Хаан минь, хэрвээ та зугтах гэж байгаа бол энэ асуудал биш. Бидэнд их мөнгө, усан онгоц, мөн хажууханд минь далай байна. Гэхдээ ...надад “хааны эрх мэдэл хамгийн сайн халхавч” гэсэн эртний цэцэн мэргэн үг таалагддаг” гэжээ.

Хатны хэлсэн үг бүх хүнд нөлөөлж, тэдэнд урам өгөв. Хааны шадар зөвлөхүүд сэтгэл санаа, зориг зүрхээ хатамжилж, ...Велисарий жанжин хэдэн зуун мянгаараа түлхэлцэн эмх замбараагүй зогсож буй босогчид рүү гэнэт...довтлон оров. Цэргийн дэг журам, сүр хүчийг үзээгүй босогчид ихэд айж, тал тал тийш зугтав. (532 онд Константинопольд дээдсэн бослогын тухай Кесрийн Прокопийн тэмдэглэлээс)



1. Эх сурвалжид юун тухай өгүүлж байна вэ?
2. Яагаад энэ үйл явдлыг Никагийн бослого гэж нэрлэв? Одоогоос хэдэн жилийн өмнө болсон бэ?
3. Эх сурвалжаас Феодора хатны тухай юу гэж дүгнэж болох вэ?



### ДҮГНЭЭРЭЙ

### 3.6 ҮНЭЛЭЭРЭЙ

Византийн эзэнт улс хэдэн жил оршин тогтносон бэ?	Юстиниан хааны үеийн Византийн эзэнт улсын газар нутагт одоо ямар улсууд оршиж байна вэ?	Яагаад Византийн эзэнт улс бүдүүлэг аймгуудын довтолгоог зогсоож, Баруун Ромын эзэнт улсаас 1000 гаруй жил илүү оршин тогтнож чадсан бэ?
Тооцоолно уу.	Газар зүйн зурагт заана уу.	Дүгнэн ярилцаарай.

## 7. ОРОСУУД ТӨР УЛСАА БАЙГУУЛСАН НЬ

Дундад зууны эхээр Европт шинэ ард түмэн түүхийн тавцанд гарч ирэв. Тэднийг Славянчууд гэдэг байв. Тэд Төв ба Зүүн Европын өргөн уудам нутагт тархан суужээ. Славянчуудыг баруун, зүүн, өмнөд гэж ялгана. Зүүн Славянчууд I мянган жилийн сүүлээр хүчирхэг засаг, нэгдмэл хуультай төр улсаа байгуулжээ.



Энэ үйл явдал хэрхэн өрнөсөн бэ? Зүүн Славянчуудын нийгэмд ямар өөрчлөлт гарсан бэ?

Зүүн славянчуудын нутгийг Русь (Орос) гэх болов. Энэ нэршил скандинав гаралтай хэдий ч зүүн славянчуудын анхны төрт улсын нэр болсон юм. Зүүн славяны умард хил варягуудын довтолгоонд байнга өртөж байв. Орост скандинавын дайчин викингүүдийг варягууд гэнэ. Мөн Зүүн Славян аймгууд өмнөд хөрш Хазарын хант улсад алба гувчуур барьдаг байв. Зүүн славяны 12 аймгийн холбоод байжээ. Тэд газар тариалан голлон эрхэлнэ. Тэдний нутаг ихэнхдээ өтгөн ойгоор өвч хучигдсан учраас модыг цавчин унагаж, тайрдсыг нь ухан авч, шатаан хөрсөө бордоно. 2-3 жил ашигласны дараа талбайгаа орхиж, өөр талбайг борддог байв. Тэд улаан буудай, хөх будаа, арвай, шар будаа, овьёс, гурвалжин будаа, вандуй, шош, маалинга, олс тариална. Ногооны талбайдаа улаан манжин, сонгино, байцай тариалдаг.



Зураг 3.16. Талбайг хагалж, бордох үйл явц

Газар тариалангаас гадна славянчууд мал аж ахуй эрхэлж, үхэр, ямаа, хонь, гахай, агт морь өсгөдөг. Зүүн славянчуудын амьдралд зөгийн аж ахуй, загасчлал, ан ав их үүрэг гүйцэтгэжээ. Ан хийж, хоол хүнсэндээ нэмэрлэхээс гадна арьс үсээр нь хувцас хийнэ. Суусарын арьс арилжааны гол хэрэгсэл байсан тул хожим мөнгийг кун (суусар) гэж нэрлэж байв. Сайн чанарын төмөр цутгаж, зэр зэвсэг хийдэг байлаа.

Славянчууд хонгор шар үс, улаа бутарсан хацар, саарал нүдтэй, биерхүү өндөр нуруутай, тэнхээтэй, тэсвэр хатуужилтай хүмүүс гэж сурвалжид тэмдэглэжээ. Хөрш ард түмэн нь тэдний эрх дураараа, зочломтгой зан чанарыг онцолсон байдаг. Славянчууд гол, нуурын эргээр орон гэрээ барьдаг. Тэд голдуу 10-20 м<sup>2</sup> талбайтай, газарт гүн суулган барьсан байшинд сууна.

Зүүн славянчууд онго шүтлэгтэй, олон бурхан шүтдэг. Аянгын бурхан Перуныг онцгойлон шүтнэ. Тэд лус, савдаг, галын бурхан зэрэг байгалийн далдын хүчинд итгэдэг байв.

VI зууны үед славянчууд хөршийн хүйгээрээ амьдрах болжээ. Хүй нэгдлийн гишүүд тариалангийн талбайг гэр бүлээрээ эзэмшиж, хадлангийн талбай, ой, нуга хамтын өмч байлаа. Гэр бүлийн тэргүүн бүр вече хэмээх ардын хуралд оролцож,

чухал асуудлыг хамтдаа шийднэ.

IX зууны үед худалдаа өргөжин хөгжжээ. “Варягаас Грек хүрэх” зам худалдаанд чухал үүрэгтэй байлаа. Энэ замаар Визант улсад ангийн арьс үс, зөгийн бал, лав, боол арилжиж, үнэт даавуу, торго, мөн дарс, жимс, халуун ногоо зэрэг тансаг барааг авчирч байв. Хар тэнгисээс Балтийн тэнгис хүрэх зам дагуу худалдааны суурингууд үүсжээ. Аажмаар эдгээр суурингаас Киев, Смоленск, Чернигов, Любеч хотууд өсөж өндийв. Худалдаачид хотод орон байр, бараа агуулах газар байгуулж, жингийн худалдаа зохион байгуулна. Хотод гар урчууд ч төвлөрөн суух болов.

Худалдаа наймаа их ашигтай ч аз сорьсон, аюултай ажил байв. Варягуудаас гадна IX зууны үеэс нүүдэлчин печенегүүд Доод Днеприйн талыг эзэгнэж, жингийн худалдаачид, хот сууринг тонон дээрэмдэх болов. Худалдаачид хотоо хамгаалахын тулд нөхөр цэргийг бүрдүүлж, цэргийн жанжин тайж нар захирах болов. Хотыг хамгаалж, бэхлэлт хана босгож, ханыг тойруулан суваг шуудуу ухжээ. Хотод олон аймгийн хүмүүс цугларч, аймгийн уламжлалаар хотыг удирдах боломжгүй байлаа. Аажмаар хэв журам тогтоох, хэрэгжүүлэх эрх мэдэл тайж нарын гарт шилжжээ. Тосгодын тариачид хотод ирж, арилжаа хийнэ. Тэд гэнэтийн дайралтын үеэр хотыг хамгаалахад оролцоно. Хотууд аажмаар ойр орчмын газар нутгийг захиргаандаа орууллаа.

862 онд варягуудын захиргаанд байсан зүүн славянчууд тэдэнд алба гувчуур төлөхөө зогсоож, нутагт нь хөөжээ. Гэвч аймгууд хоорондоо эв түнжингүй байв. Дээр нь хазаруудын довтолгоо аюул учруулах болов. Ийм учраас аймгийн төлөөлөгчид вече зарлан хуралдуулж, тэнгисийн чанад варягуудад элч илгээжээ. Тэдний урилгаар Варягийн тайж Рюрих нөхөр цэргийн хамт ирж, Новгород хотыг үндэслэн захиран суув. IX зууны үед варягийн тайж Аскольд, Дир нар полянчуудын төв Киев хотыг эзлэн авснаар варягуудаар удирдуулсан зүүн славяны төрт улсын хоёр дахь том төв үүсжээ.






Даалгаврыг гүйцэтгэж газар зүйн зураг, мэдээллээс юу ойлгож авснаа танилцуулаарай.

1. Мэдээлэлд гарсан варяг, славян, вече зэрэг үгсийг тайлбарлаарай.
2. Бүдүүвчийг гүйцээж, зүүн славянчуудын гарал үүслийг тайлбарлана уу.
3. Зүүн славянчуудын газар нутаг, аймгийн холбоод, хөрш аймаг улсууд, Варягаас Грек хүрэх замыг газар зүйн зурагт заана уу.
4. Дараах төлөвлөгөөний дагуу уншсан мэдээллийн агуулгыг танилцуулна уу
  - а. Зүүн славянчуудын эрхлэх аж ахуй
  - б. Орон байр
  - в. Шашин шүтлэг
  - г. Нийгмийн зохион байгуулалт
  - д. Төр улс үүссэн нь

Бүдүүвч 3.6.



### Сурвалжийн мэдээ

“6370 он. Варягуудыг (чудь, словен, мере) тэнгисийн чанад руу хөөж, алба гувчуур төлөхөө больж, өөрөө өөрсөддөө эзэн суув. Тэдний дунд нэгдсэн засаг гэж үгүй, овог, аймгаараа хуваагдаж, дайсагналцана. “Бидэнд эзэн сууж, биднийг захирч, хуулийн дагуу шүүх тайж хайцгаая?”...Ийнхүү тэнгисийн чанадад варягууд, русь нарт очиж...”Манай газар өргөн уудам, гэвч тэнд хэв журам алга. “Тайж ор сууж, биднийг захирна уу гэв. Ах дүү гурав сонгогдож (варягуудаас) овгийнхоо хамт ирцгээв. Том ах Рюрик Новгородод, нөгөө нь Белоозерод, гурав дахь нь Изборскт захиран суув”. (Варягуудыг урьсан тухай XI–XII зууны Оросын шашдирт өгүүлсэн домог).

### ТАЙЛБАР

Оросууд Константинполь хотыг Царьград буюу Хаан хот гэнэ.

“Грекээс Варяг хүртэлх” зам Финийн булангаас Нева, Ладог нуур, Волхов, Ильмень нуур, дамжин тэндээс Ловать гол, Баруун Двина, Днепр, Днепрээс Хар тэнгис, Царьград хүрдэг байжээ.



Дараах даалгаврыг гүйцэтгэж мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Эх сурвалж эртний Оросын төр улсын үүслийн тухай юу өгүүлж байна вэ? Оросын төрт улсын хоёр төв бүрэлдэхэд варягууд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Тэднийг орос улсыг байгуулсан гэж үзэж болох уу.
2. Эх сурвалжид өгүүлж буй үйл явдал нийтийн тооллын хэдэн онд болсон бэ?



## Оросын вангуудын бодлого үйл ажиллагаа

879 онд Рюрих Новгород хотод өөд болов. Түүний садан Олег (882-921) Новгородын ван болжээ. Тэрээр Киевийг нэгтгэж, 907, 911 онд Царьград руу довтолж, Орост ашигтай худалдааны гэрээ байгуулав. Олег ванг өөд болсны дараа Рюрихийн хүү Игорь төр барьжээ. Игорь ван древлянчууд руу алба гувчуурын хэргээр яваад тэдний гарт хөнөөгдөв. Түүний бэлбэсэн хатан Ольга балчир хүү Святославын өмнөөс төр барихдаа алба гувчуурын хувь хэмжээ, тушаах газрыг тогтоосон нь төрийн анхны шинэтгэл байв.

Святослав вангийн (957-972) үед Хазарын хант улсыг хиар цохиж, оросын хотуудын аюулыг зайлуулав. Гэвч тэдний орыг нүүдэлчин печенегүүд эзэлж, Орост заналхийлэх болов. Владимир ван (980-1015) печенегүүдээс хамгаалах бэхлэлт босгосон байна. Тэрээр дан ганц цэргийн хүчээр славяны газар нутгийг захиргаандаа тогтоон барих боломжгүй гэдгийг ойлгожээ. 988 онд Владимир загалмайн шашинд орж, Византийн гүнжтэй гэрлэв. Тэрээр Византийн лам нарын хамт нутагтаа ирж, Перун зэрэг эртний бурхдын баримлыг Днепр мөрөнд хаяж, хүн амаа загалмайн шашинд оруулжээ. Загалмайн шашин оросын ард түмний ахуй, зан байдлыг эрс өөрчилсөн юм. Золигт гаргах, олон эхнэр авах, цусан өшөө авах зэрэг эртний заншлыг халав. Сүм хийдүүд байгуулагдаж, өнчин, ядуусыг тэтгэв. Орост загалмайн шашны хамт бичиг, үсэг, боловсрол, сүмийн урлаг дэлгэрчээ. Цэцэн хэмээх Ярославын үед Орос улс цэцэглэн хөгжив. Сүм, номын сан барьж, Новгородын хэв хуулийг боловсруулсан нь “Ярославын хууль” хэмээн алдаршжээ.

### Сурвалжийн мэдээ

“6390 оны зун. Олег ван их цэргээ авч, аян дайнд мордов... Смоленск хотыг эзлэн авч, өөрийн хүнээр захируулав. Улмаар өмнө зүг хөдөлж, Любеч хотыг эзлэв... Киевийн хаяанд ирж Аскольд, Дир захиран суугааг мэдэв.

...Аскольд, Дирт элч илгээж, Бид та нарын зочин Грект хүрэхээр яваа Олег ван, түүний хүү Игорь байна. Нутаг нэгт бидэнд хүрэлцэн ирнэ үү гэв. Тэднийг ирэхэд Олег ван “Та нар тайж угсаагүй би тайж гаралтай хэмээн...” Аскольд, Дирийг хөнөөв... Ийнхүү Олег Киевт захиран сууж, “Энэ хот Орос орны эх” хэмээв.

### Тодруулга:



Византийн эзэн хаан III Михаилын зарлигаар ах дүү Кирилл, Мефоди нар Болгар, Морав улсад шашин номлох болов. Славяны ард түмэн грек хэл үл мэдэх тул ах дүү хоёр славяны анхны цагаан толгойг зохиожээ. Ийнхүү кирилл үсгийн цагаан толгой үүссэн байна.



Нестор ламын 1113 онд бичсэн “Он жилүүдийн тууж” “Орос нутаг хэрхэн бүрэлдэв, Киевт хэн анх хаанчлав” гэж эхэлдэг.



Дараах даалгаврыг гүйцэтгэж мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Олег ван Киевийг дайлсан үйл явдал нийтийн тооллын хэдэн онд болсон бэ? Тэр яагаад Киев хотыг эртний Орос улсын нийслэл болгосон бэ?
2. Оросын вангуудын үйл ажиллагаанд нийтлэг ба онцлог зүйлс юу байна вэ?

ДҮГНЭЭРЭЙ

3.7 ҮНЭЛЭЭРЭЙ

Эртний Орос улс одоогоос хэдэн жилийн өмнө байгуулагдсан бэ?	Шашин соёлын хувьд ямар улс Орост нөлөө үзүүлсэн бэ?	Цэцэн Ярославын үеийн Орос улсын газар нутаг, түүний хөрш улсуудыг нэрлэнэ үү.	Эртний Орос улсын аж ахуй, шашин соёлын талаар юу мэддэг болсон бэ?
Тооцоолж он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт заагаарай.	Дүгнэн ярилцана уу.	

## 8. МАЙЯ, АЦТЕК, ИНК УЛС

1492 онд Х.Колумб Америк тивийг нээх хүртэл Европчууд энэ тивийн тухай мэддэггүй байсан юм. Х.Колумб ч өөрөө Энэтхэгт очсон гэж бодоод нутгийн хүмүүсийг индианчууд (энэтхэгчүүд) гэж нэрлэжээ.



Америكت Колумбаас өмнө ямар улсууд байсан бэ?



Зураг 3.18..Майя, Ацтек, Инк улсууд



Хойд, Төв, Өмнөд Америكت эртнээс олон аймаг, ард түмэн нутаглаж иржээ. Тэдгээр хүмүүсийг одоогоос 11-15 мянган жилийн өмнө Төв Азиас Берингийн хоолойг дамжин Америк тивд очин суурьшсан гэж үздэг.

Америкийн уугуул хүмүүс ан ав хийх, загасчилах зэргээр аж төрж байв. Харин Хойд Америкийн өмнөд хэсэг, Төв, Өмнөд Америкийн тэгш өндөрлөгт тариалан эрхэлж, эрдэнэ шиш, төмс, наранцэцэг, улаан лооль, какао, тамхи зэргийг анх тариалжээ. Эдгээр ургамлыг хожим XV зуунд газарзүйн их нээлтийн дараа Европ, улмаар дэлхийн бусад оронд тариалах болов.

Харин Америкийн уугуул хүмүүс амьтан гаршуулах нь ховор байв. Тивийн хойд хэсэгт нохой, өмнөдөд лам гөрөөс өсгөж, ахуй амьдралдаа ашиглаж байжээ. Мөн цацагт хяруул, нугас үржүүлж, хүнсэндээ хэрэглэдэг. Америкийн уугуул хүмүүс багаж, зэр зэвсгээ мод, галт уулын чулуу, хүрлээр хийн харин шүтлэгийн эд зүйлсээ алт, мөнгөөр урлан тахин шүтэж байжээ. XV зуунд Америк тивд хөл тавьсан Испанийн далайчин Х.Колумб Америк тивийн уугуул хүмүүсийг индианчууд хэмээн нэрлэсэн нь энэтхэгчүүд гэсэн утгатай юм.

Америкийн уугуул хүмүүс овог, аймгийн байгууллаар аж төрж байлаа. Тэдгээр овог, аймгаас Майя, Ацтек, Инкүүд төр улсаа байгуулж, аж ахуй, соёлын хөгжлөөрөө товойн гарчээ.

**Майя-гийн “Нарны сүм”**




Зураг 3.19. “Нарны сүм” 60 метр өндөр үелсэн пирамид хэлбэртэй, гоёмсог сийлбэрээр чимэглэгджээ.

**МАЙЯ.** Майячууд Төв Америкийн Юкатаны хойгоор нутаглаж байв. Тэд газар тариалан эрхэлж, ан гөрөө хийнэ.

III зууны үед майячууд дүрс бичиг зохион ном бичиж, зургаар чимэглэжээ. Тэд нарны хуанлийг анх зохиосон юм. Чичен Ица хотод одон орон судлах оргил байгуулж, од эрхэсийг ажиглан нар, сар хиртэлтийг урьдчилан мэддэг байв. Тэд тооны ухааныг хөгжүүлж, тооллын хорьтын систем, тэг тоог нэвтрүүлжээ. Анагаах ухаан ч мөн өндөр хөгжиж, мэс засал хийн шүд эмчилж байсныг нотлох мэдээ сэлт бий.

Майячууд хавтанг шахаж, зам тавьдаг байв. Мөн өндөр суурин дээр олон шат гишгүүр бүхий сац суварга, тахилын сүм байгуулжээ. Жишээ нь Чичен-Ице хотын сац суваргын оройд байрлах тахилын сүм жилийн хоногийн тоотой тэнцэх 365 гишгүүртэй юм. Сац суваргыг бурхдын баримал, хаад, тайлгач лам, мөн дайныг дүрсэлсэн товгор сийлбэрээр чимэглэжээ.

Зураг 3.20. Теночтитлан хот



**АЦТЕК.** Ацтекууд Хойд Америкийн төв хэсэг одоогийн Мексик улсын нутаг оршиж байв. Тэд 1325 онд Тескуко нуурын тэг дунд орших арал дээр Теночтитлан хотыг байгуулсан юм. Хотод газар хүрэлцэхгүй байсан учраас тэд мөчрөөр сал сүлжиж, нуурын замаг, хар хөрс дэвсэж тариална. Ийм “хөвөгч талбай”-гаас жилд 2-3 удаа ургац хураан хотын хүн амыг хүнсээр хангана.

Ацтекууд дайнч ард түмэн байв. Тэд Нарыг бурханчлан шүтэж, шашны өвөрмөц зан үйл хийнэ. Жил бүр дайнд олзолсон хүмүүсээр бурхандаа тахил өргөж, амьдралаа даатгана.

Ацтекуудын зохиосон нарны хуанли 4 улиралтай. Нэг жил нь 20 сар, сар бүр нь 20 хоногтой байжээ. 1519 онд Испанийн цэргүүд Төв Америкт ирж, Ацтекийг эзлэн авсан байна.



**ТАЙЛБАР:**

1. Тонатиух бурхны дүрсийг дүрсэлсэн.
2. 4-н улирал болох бар, ус, салхи, бороо зэргийг дүрсэлсэн.
3. 20 хоног нь тус тусдаа амьтныг дүрсэлсэн байдаг.

Зураг 3.21. Ацтекийн нарны хуанли

**ИНК.** Инкүүд одоогийн Перу улсын нутаг Өмнөд Америкийн баруун эргийн Андын нуруугаар нутаглаж байжээ. Инкүүд XII зуунд төр улсаа байгуулан хөрш аймгуудаа байлдан дагуулж, газар нутгаа өргөтгөсөн байна. Улсын нийслэл нь Куско хот байв.

Хэмжээгүй эрхт хаан Инк улсыг захирна. Түүнийг инкүүдийн бурхан, Нарны хүү хэмээн өргөмжилж, эрх ямба эдлүүлнэ. Ихэнх эрс цэргийн алба хашин хатуу сахилга батад суралцаж, хөрш овог, аймаг руу дайнд мордож байв.

Харин тариачид уулын бэлийг засаж, эрдэнэ шиш, төмс тариалж, ургацынхаа гуравны хоёрыг хаан, тайлгач ламд алба болгон барина. Тэд лам гөрөөс үржүүлж, уналга, ачилгад хэрэглэн мах, арьсыг нь ашиглана.

Улс орон даяар шуудан харилцаа хөгжин зарлагууд орон нутгаас нийслэл рүү мэдээ дамжуулна. Инкүүд бичиг үсэгтэй байсан эсэх нь өнөө хэр тодорхойгүй байна.

Инкийн уран барилгачид сүм, ордон, бэхлэлт цайз олноор байгуулжээ. Хадат толгод дээр байрлах Куско хотын гол цайзаас газар доогуур хонгил татаж, хотын бусад дүүрэгтэй холбосон байна. Хотын гурван цамхагийг тус бүрд нь хэдэн зуун тонн жинтэй бул чулуун ханаар хүрээлжээ. Ийм бул чулууг дугуйт тэрэггүйгээр зөвхөн олсоор хэдэн арван км чирч ууланд авчирсан гэдэгтэй эрдэмтэд санал нийлдэггүй юм. 1570 онд португальчууд Инкийг эзлэн авчээ.



Даалгаврыг гүйцэтгэж уншсан мэдээллийн агуулгыг танилцуулаарай.

1. Ацтек, Инк, Майя улсуудыг газар зүйн зурагт заана уу? Одоогийн ямар улсын газар нутагт оршиж байсан бэ?
2. Америкийн овог, аймгууд газар тариалангийн ямар соёлыг бусад оронд дэлгэрүүлсэн бэ?
3. Майячууд яагаад наранд зориулж сүм барьсан бэ?
4. Ацтекийн Теночтитлан хотын онцлог юу вэ?
5. Ацтекуудын цаг тооны хуанлийн тухай ярилцаарай. Бидний хэрэглэж буй хуанлиас ямар ялгаатай байна вэ?

## ДҮГНЭЭРЭЙ

3.8

## ҮНЭЛЭЭРЭЙ

Америк тивийн эртний улсууд	Одоогийн ямар улсын газар нутагт байсан бэ? Газар зүйн зурагт заана уу.	Америк тивийн эртний улсуудын нийгмийн зохион байгуулалт, аж ахуй, соёлын хөгжил дэх нийтлэг ба онцлог шинжүүд	
		Нийтлэг шинж	Онцлог шинж
Ацтек			
Инк			
Майя			

## ДЭД БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Ард түмний нүүдэл, Европ дахь викингүүдийн довтолгоог харьцуулна уу.

	Нийтлэг шинж	Онцлог шинж
Ард түмний их нүүдэл		
Викингүүдийн довтолгоо		

2. Дараах ухагдахууныг тайлбарлана уу.

Ард түмний их нүүдэл	
Варварууд	
Саалийн үнэн	

3. Харьцуулна уу.

Бенефици	Феод

4. Византийн эзэнт улс, Франкийн эзэнт улсын бүрэлдэхүүнд орж байсан газар нутгийг ялгаж бичнэ үү.

- а. Хойд Итали                      б. Өмнөд Итали, баруун Сицили                      в. Грек  
г. Өмнөд Франц                      д. Фрак                      е. Баруун Герман

Византийн эзэнт улс	Франкийн эзэнт улс

5. Дараах үйл явдлууд та нарын төрсөн жилээс хэдэн жилийн өмнө болсон бэ? Хэддүгээр зуун, мянганд болсныг тооцоолж, он тооллын шугамд тэмдэглэнэ үү.

- а. 476 он - Баруун Ромын эзэнт улс мөхөв.  
б. 800 он – Их Карлыг эзэн хаанаар өргөмжлөв.  
в. 882 он - Эртний Орос улс байгуулагдав.  
г. 1054 он – Загалмайтны сүм хийд хоёр хуваагдав.

6. Дараах тэгшитгэлийг бодоорой.

(Олег ван Киевийг дайлсан он + зөнч Мухаммедын Мекка руу зугатан гарсан он) :  $2+4=x$  (Энэ онд ямар үйл явдал болсон бэ?)

7. Үйл явдлыг он цагийн дараалалд оруулна уу.

- а. I Юстиниан хаан ширээнд суув.  
б. Ромын эзэнт улс Баруун, Зүүн гэж хуваагдав.  
в. I Юстиниан хааны цэргүүд Италийг байлдан дагуулав.  
г. Баруун Ромын эзэнт улс мөхөв.

8. Тохируулна уу.

1. Зүүн славян                      а. Польш  
2. Баруун славян                      б. Украин  
3. Өмнөд Славян                      в. Серб

9. Нөхөж бичээрэй.

Баруун Европ – Норманн                      Орос - .....

10. Эх сурвалжид дурдсан үйл явдал аргын тооллын хэдэн онд болсон бэ? Он тооллын шугамд тэмдэглэнэ үү.

«6494 оны зун. Махмет шүтлэгтэй болгарууд, Ромоос немцүүд, улмаар хазарын еврей нар ирцгээлээ. Тэд бүгд л өөрсдийн хуулиа магтан сайшаана».

11. Ромын папыг дэмжигч загалмайтнууд, Константинополийн патриархыг дэмжигчдийн хоорондын хуваагдал шашны гэхээсээ улс төрийн шалтгаантай байсан. Учир нь хоёр сүм хийдийн номлол, зан үйлд тун бага ялгаа бий. Та энэ дүгнэлттэй санал нийлэх үү? Тийм, үгүй гэсэн дүгнэлтийг сонгон үндэслэлээ тайлбарлана уу.

## 9. ЛАЛЫН ШАШНЫ ҮҮСЭЛ БА АРАБЫН ЕРТӨНЦ

Хоёр мөрнөөс Гибралтарын хоолой хүртэлх Өрнөд Ази, Умард Африкийн газар нутагт Арабын 20 гаруй улс бий. VII-VIII зуунд энэ өргөн уудам нутагт Арабын халифт хэмээх хүчирхэг улс оршин тогтнож байсан юм.



Арабуудыг юу нэгтгэж байв?



**Лалын шашин үүссэн нь.** Арабын хойг Баруун Азид оршино. Хойгийн төв хэсэгт өргөн уудам Арабын цөл бий. Хүмүүс голдуу тэнгисийн эрэг, цөлийн захаар нутаглаж байв.

Арабын хойгийн баруун-өмнөд Йемен, баруун эргийн Хижаз муж харьцангуй өндөр хөгжилтэй байв. Йемен бол үржил шимт баян бүрд юм. Арабууд хөвөн, усан үзмийн бут, финикийн дал мод, чихрийн нишингэ, арвай тариална. Йемен, Хижазийн нутгаар өрнө, дорныг холбосон худалдааны зам дайран өнгөрдөг. Энэ замаар Энэтхэгийн халуун ногоо, торго, сувдыг Византийн Сирид хүргэнэ. Ийм учраас энд Мекка, Ясриб зэрэг худалдааны олон хот өсөж өндийжээ. Хойгийн баян бүрдтэй хиллэх цөлд араб нүүдэлчин - бедуинчууд нутаглаж, мал аж ахуй эрхэлнэ. Тэд хонь, агт морь, нэг бөхт тэмээ өсгөж байв.

Арабууд онго шүтлэгтэй байжээ. Гэхдээ нэгдмэл шүтлэггүй, аймаг бүр өөрийн шүтээнтэй байв. Ромчуудын хавчилгаас зугатан ирсэн еврейчүүд хойгт иудейн шашныг авчирчээ. Харин загалмайтны шашинт худалдаачид, Визант, Этиопийн лам, санваартнууд Арабын хойгт Христийн сургаалийг номлож байв.

Арабуудыг нэгтгэн төр улс байгуулахад лалын шашин (ислам) гол үүрэг гүйцэтгэв. Лалын шашныг үндэслэгч Мухаммед 570 оны орчим Мекка хотод төржээ. Мекка хот Хижазын төв хэсэгт Сири хүрэх худалдааны замд байв. Меккагийн хүн ам Йемен, Энэтхэгийн барааг Сири, Палестинд худалдаалж, ашиг олж амьдарна. Энэ хотод араб аймгуудын 360 шүтээн бүхий онго шүтлэгийн Кааба сүм байжээ.

Мухаммед 6 насандаа өнчирч хоцорсон байна. Залуудаа баян худалдаачин садан төрлийнхөө жинг тээх зэрэг хар бол ажил хийж байв. 25 насандаа Мухаммед Хадижа хэмээх баян эмэгтэйтэй гэрлэж, худалдаа эрхлэх болов. Мухаммедыг 40 настай байхад нэгэн явдал тохиолджээ. Меккагийн ойролцоох Хира уулын агуйд Мухаммед зүүдэндээ Аллах тэнгэртэй (арабуудын дээд бурхан) уулзсан гэнэ. Аллах түүнд “унш” гээд хэдэн мөр хэлж, давтаж хэлэхийг тушаан, Мухаммедэд бурхны сургаалийг номлох хувь тавилан оноосон гэдэг. Эхэндээ Мухаммедыг төрөл садан, найз нөхөд гээд цөөн хүн дагажээ. Мухаммедыг дагагчдыг мусульманчууд гэнэ. Меккагийн оршин суугчид онго шүтлэгээс татгалзан Аллах бурхныг шүтэх Мухаммедын уриалгыг хүлээн авсангүй. Мухаммедыг өвөг дээдсийн шүтлэгээс нүүр бууруулсан буруу номтон хэмээн түүний гэр бүл, хамтран зүтгэгчдийг шахан хавчих болов. Мухаммедын амь насанд аюул заналхийлж, тэрээр цөөн дагалдагчдын хамт Меккаг орхин Ясриб руу зугатав. Энэ үйл явдлыг арабууд хижра (зугталт) гэх бөгөөд уг үйл явдал болсон 622 оноос мусульманы тоолол (хижрийн тоолол) эхэлдэг.

Ясрибт Мухаммедыг найрсагаар угтав. Түүний нэр хүнд өсч, Ясриб хотыг Медина буюу “Зөнчийн хот” хэмээн нэрлэжээ. Медина хотод бурхны Зөнч Мухаммед анхны лалын сүм (арабаар мечеть) барьж, шашны хатуу дэг тогтоосон байна. Мухаммед тэргүүтэй Медина хотынхон 630 он хүртэл Меккатай дайтаж, эцэстээ Меккагийн баячуудтай тохиролцжээ. Мухаммед Меккагийн гол шүтээн Кааба (арабаар шоо дөрвөлжин)-г онго шүтлэгийн бурхдаас цэвэрлэн лалын шашны ариун газар болгов.

Арабын хот, нүүдэлчин аймгууд ар араасаа Мухаммедтай нэгдэв. Тэднийг Аллах бурхны шүтлэг нэгтгэжээ. Мухаммед 632 онд өөд болов.

Түүнийг өөд болсны дараа Аллах бурхны сургаалыг эмхэтгэн Коран (арабаар уншлага гэсэн үг) судрыг бүтээв.




1. Мэдээлэлд гарсан бедуин, хижра, мусульман, коран хэмээх үгсийг утгыг тайлбарлаарай.
2. Уншсан мэдээллийн агуулгыг дараах төлөвлөгөөний дагуу танилцуулаарай.
  - а. Арабын хойгийн байгаль, газар зүйн онцлог
  - б. Хүн амын эрхлэх аж ахуй
  - в. Араб аймгуудын шашин шүтлэг
  - г. Лалын шашны үүсэл
  - д. Төр улс байгуулагдсан нь
3. Арабын хойгийн суурьшмал, нүүдлийн газар нутаг, лалын шашны анхны төвүүдийг газар зүйн зурагт заана уу. Хижра хэмээх үйл явдал хаана болсныг мөн заагаарай.

### Тодруулга:

Мекка хот дахь лалын сүмийн төвд Кааба хэмээх байгууламж бий. Уг байгууламж шоо дөрвөлжин хэлбэртэй 5 давхар байшинтай тэнцэнэ. Лалын шашинтнууд Кааба сүм рүү хандаж мөргөл үйлддэг.

Зураг 3.22. Мекка дахь Кааба сүм



### Лалын шашинт хүний дагаж мөрдөх зан үйл

Аллах бурхныг шүтэх "Аллахаас өөр тэнгэр үгүй, Мухаммед түүний зөнч"	Меккагийн зүг хандаж, өдөрт 5 удаа мөргөл үйлдэх	Үл хөдлөх хөрөнгө, мал сүрэг, худалдааны ашиг, дайны олзны 1/40 хувийг ядууст зориулж, буян үйлдэх	Сарын хуанлийн 9 дэх сар буюу рамадан сард мацаг барих
--	--	--	--



Меккад очиж Кааба сүмд мөргөх




## Арабын халифт улс.

Мухаммедыг өөд болсны дараа зөнчийн ойрын хамтран зүтгэгчид лалын улсыг тэргүүлэв. Тэднийг халифууд (зөнчийн орлогч) гэнэ. Эхний дөрвөн халиф Абу Бекр, Омар, Осман, Али нар 632-661 онд төр барьсан (тэднийг “үнэн зөв” халифууд” гэдэг) юм. Тэд шашин, төрийг хослон барьж байв. Арабууд хойгийг нэгтгэн нэгдмэл улс байгуулсны дараа буруу номтныг номхотгох ариун дайнд (жихад) морджээ. Арабын морин цэрэг VII зууны сүүл хагаст Византиас Сири, Палестин, Египет, Хойд Африкийг булаан авав. Улмаар VII зууны сүүлчээр Сицили арлыг эзэгнэв. Дорно зүгт арабууд Ираны шахад цохилт өгч, Хятадын хил хүрчээ. 711 онд арабууд Пиренейн хойгт хөл тавьсан байна. 7 мянган морин цэргээс бүрдсэн цэргийн хүчин Баруун готын вант улсыг бут цохиж, Испанийг буулган авчээ. 732 онд Франкад халдсан арабуудыг ван Карл Мартеллын цэрэг Пуатьегийн дэргэд бут цохиж Баруун Европ дахь арабуудын довтолгоог зогсоосон байна.

Арабууд баруун Азийн эртний соёлт грек, еврей сири, перс ард түмний өв соёлыг эзэмшин өөрсдийн соёлыг бүтээсэн юм. Мусульманчууд грек, перс зохиолуудыг араб хэлнээ орчуулж, араб хэл олон орны номын хэл болов. Тоо, одон орон, анагаах ухаан, хими, газарзүй өндөр хөгжив. Мусульманчууд улиралд нийцүүлэн хувцаслах, найранд зоог барих (эхлээд шөл, дараа нь мах, тахиа, сүүлд нь амттан өгөх) зэрэг ахуйн соёлыг нэвтрүүлжээ.

Зураг 3.23. Арабын халифт улс



Лалын шашин Бурхныг дүрслэхийг хориглодог юм. Загалмайтнууд Бурхны хөрөг бүтээхийг эрхэмд үздэг бол мусульманчууд бурхны сургаал, үгсийг мөнхжүүлэхийг

эрмэлзжээ. Арабуудын дунд ном чимэглэх урлаг, уран бичлэг (каллиграф) цэцэглэн хөгжив. Уран бичлэгийн ачаар араб цагаан толгой Испаниас Бухар, Энэтхэгт дэлгэрэв. Араб цагаан толгойг VI зуунд зохиосон байна. Араб цагаан толгой 28 үсэгтэй, баруунаас зүүн тийш бичдэг юм. Уран барилга лалын шашинт орон бүрд өөрийн онцлогтой байв. Испанийн Кордова хотын лалын сүм, Гранада хотын Алгамбрын ордон арабын уран барилгын гайхамшигт дурсгал юм.

Тоо	Одон орон	Түүх	Газар зүй	Анагаах ухаан
Аль Хорезм анх арабуудыг энэтхэг тоотой танилцуулав. "Алгебр" тооцоолол хэмээх бүтээл туурвисан нь Алгебр буюу тооны шинжлэх ухааны нэр болжээ. Европчууд энэ тоог арабуудаас өвлөн авсан тул араб тоо гэдэг.	Багдад, Дамаскт одон орныг судлах төв байв. Одон орончид дэлхийн диаметрийг багцаалан тодорхойлж, оддын байршлыг зураглан гаргав. Аль-Бируни Нар бол ертөнцийн төв, дэлхий түүнийг тойрон эргэнэ гэсэн таамаглал дэвшүүлэв.	Мухаммедын амьдралаас сэдэвлэсэн домог, арабуудын аян дайныг алдаршуулсан бүтээл бий болов. Ром, Визант, Ираны төрийн түүхийг судалж байв.	Газар зүйч, аялагчид Африк, Хятад, Энэтхэг, Зүүн Европын улс орон, ард түмнийг тодорхойлон газар зүйн зураг бүтээв. Араб худалдаачдын аялал "1001 шөнийн үлгэр" зохиолд тусгалаа олжээ.	Авиценна Ибн Сина анагаах ухааны 100 гаруй бүтээл туурвиж, олон өвчний шинж тэмдгийг нэрлэсэн байна.




Даалгаврыг гүйцэтгэж, мэдээлэл, газар зүйн зургаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Арабуудын аян дайны чиглэлийг газар зүйн зурагт зааж, байлдан дагууллын үр дүнг тодорхойлно уу.
2. Араб цагаан толгой хэзээ зохиогдсон бэ? Араб бичгийн онцлог юу вэ?
3. Арабын халифт улсад шинжлэх ухаан хөгжсөнөөр ямар, ямар шинэ мэдлэг бий болсон бэ?
4. Арабын халифт улсад урлагийн ямар төрөл хөгжсөн бэ?



Зураг 3.24. Испанийн Гранада хотын Альгамбрын ордон



Зураг 3.25. Альгамбрын ордны уран бичлэг ба геометрийн дүрсэн чимэглэл. "Аллах" гэж бичжээ.

ДҮГНЭЭРЭЙ

3.9

ҮНЭЛЭЭРЭЙ

Лалын шашин одоогоос хэдэн жилийн өмнө үүссэн бэ?	Арабын халифт улсын нутагт ямар ямар улсууд багтаж байсан бэ?	Арабын халифт улс соёл шинжлэх ухааны хөгжилд ямар хувь нэмэр оруулсан бэ?	Мухаммед түүхэнд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
Тооцоолж он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт заана уу.	Үнэлээрэй.	Дүгнэн ярилцаарай.

## 10. ТАН, СҮН УЛС

220 онд Хань гүрэн задарснаар Хятад орон уналтад оров. Хятадын сэргэлт 589 онд Сүй улс байгуулагдсанаар эхэлж, түүнийг залгасан Тан, Сүн гүрний үед оргилдоо хүрчээ.



Тан, Сүн улсын газар нутаг, нийгэм, аж ахуй, соёл ямар байв?



### Тан улс

Тан улсыг 618 онд Ли Юань жанжин байгуулж, 6 жилийн дотор бүх Хятадыг нэгтгэжээ. Чанань, Лоян хотууд Тан улсын нийслэл болж байлаа. Ли Юань хааныг хүү Ли Ши Мин нь 626 онд залгамжилсан байна. Шинэ хаанд дотоод, гадаад олон бэрхшээл тулгарчээ. Сүй улсыг мөхөөсөн дотоодын дайнд Хятадын хүн ам ихээр хорогдон татвар төлөгч эрс цөөрснөөс эдийн засаг хүндэрчээ. Мөн Сүй улсын эсрэг холбоотон болж байсан Зүүн Түрэгийн цэрэг Тан улсыг чиглэх болов. Эл хоёр гүрэн дайтсан ч хэн нь ч ялалт байгуулж чадсангүй.

Харин Өндөр тэрэгтэн аймгуудын бослогын улмаас Зүүн Түрэгийн хаан, язгууртнууд харьяат нарын хамт их говийн өмнө очжээ. Тэднийг Тан улс 630 онд эрхшээлдээ оруулсан байна. Үүгээр Тан улс умардын нүүдэлчидтэй их говиор хиллэх болов. Ийнхүү Ли Ши Мин хааны үед Тан улсын хүчирхэгжилт оргилдоо хүрсэн юм. Эл хүчирхэгжилт 100 гаруй жил үргэлжилсэн байна.

Тан улсын арми Баруун Түрэг улсын цэргийг ялснаар Хятадын нөлөө өрнө зүгт Персийн хил хүрэв. Мөн дорно зүгт Солонгосыг эрхшээж, өмнө зүгт умард Энэтхэгийн зарим вангууд, Аннам зэрэг улс алба барих болжээ.

Зураг 3.26. Тан улс VII-X зуун



Гэвч Тан улс умрын нүүдэлчдийн бослого, довтолгоонд өртсөөр байлаа. Үүний нэг нь Түрэгийн бослого амжилт олж, тэд 682 онд улсаа сэргээн байгуулан Хятадын эрхшээлээс гарсан явдал юм.

Цэргийн жанжин Ан Лушаны 755 онд гаргасан бослогоор Тан улсын бууралтын үе эхлэв. Ан Лушан 757 онд алагдсан ч хүү Ши Чао И бослогыг үргэлжлүүлжээ. Бослогыг Уйгур, Төвөд улсын цэргийн тусламжаар дарсан ч Тан улс дахин хүчирхэгжиж чадалгүй 907 онд мөхсөн байна.



Дараах асуултын дагуу ярилцаж мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Тан улсыг хэн, хэзээ байгуулсан бэ?
2. Ли Ши Мин хаан улс оронд нь тулгарсан хүндрэлийг хэрхэн шийдвэрлэв?
3. Тан улсын нийслэл хот, нутгийн хил хязгаар, хөрш улсуудыг заагаарай.
4. Тан улсын хүч буурсан шалтгаан юу вэ? Тан улс хэдэн онд мөхсөн бэ?

### Сүн улс

Тан улс унаснаар Хятад орон дахин задарч, Таван улсын үе эхэлжээ. Энэ үед Хятадын зүүн хойт нутгийг Монгол угсааны Хятан гүрэн эзэлж захирав.

Удалгүй Сүн улсын жанжин Жао Куанжин гэгч 960 онд Хятадын нэгдмэл байдлыг дахин сэргээв. Хойд Сүн улс эхэндээ Бянжин буюу одоогийн Кайпин хотыг нийслэлээ болгож байв. Нэгдмэл болсон Хятадын төр Хятан гүрний довтолгоог зогсоосон ба хоёр улс 1004 онд гэрээ байгуулж найрамдал тогтоожээ. Мөн Хойд Сүн улсын баруун хойд талд Тангуд нар 1038 онд улсаа байгуулав.

XI зууны дундуур Хятадад их ган болсноос ургац алдан хүн ам өлсгөлөнд нэрвэгджээ. Тариачид татвараа төлж дийлэхээ болив. Энэ нөхцөлд эзэн хаан Ван Ань Ши-гэгчийг тэргүүн сайд болгож, түүний шинэчлэлтийг хэрэгжүүлжээ. Шинэчлэлтийн хүрээнд дамлан худалдаж байсан цагаан будааг хураан авч, өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст өгчээ. Мөн тариачдад үр болон мөнгөн зээллэг өгч, татварыг хөнгөлөв. Ургац хураасны дараа тариачид зээлээ өгөхөд, түүнийг улсын зоринд хадгална. Мөн бараа бүтээгдэхүүнд хатуу үнэ тогтоожээ. Төрийн албанд мэдлэг, чадвартай хүмүүсийг шалгаруулан авч, авлигач, ажилдаа тэнцэхгүй түшмэдийг халав. Суурингуудад сургууль нээж, хотуудад дээд сургуулиуд байгуулав. Хөлсний армийг татан буулгаж, нийтийн цэргийн арми байгуулав. Эл шинэчлэлт хуучныг баримтлагч

Зураг 3.27. Сүн улс X зуун



түшмэд, худалдаачид, мөнгө хүүлэгчдийн эсэргүүцлийн улмаас зогссон байна.

Хятан гүрний захиргаанд байсан Зүрчид аймгууд 1116 онд Алтан улсыг байгуулж богино хугацаанд хүчирхэгжив. Алтан, Сүн улсууд хүч хавсран Хятан гүрнийг 1125 онд унагасан ч тэд удалгүй эвдрэлцжээ. 1127 онд Алтан улсын цэрэг нийслэл Кайпин хотыг эзлэхэд Сүн улсын хаан өмнө зүг зугтан Ханжоу хотыг нийслэл болгож суув. Энэ үеэс тус улсыг Өмнөд Сүн гэх болжээ. Өмнөд Сүн улс монгол цэрэгт 1279 онд бүрэн эзлэгдсэн билээ.



Дараах асуултын дагуу ярилцаж мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Хойд Сүн улсыг хэн, хэзээ байгуулсан бэ?
2. Хятан улсын довтолгооныг Хойд Сүн улс хэзээ зогсоов?
3. Хойд Сүн улсын нийслэл хот, нутгийн хил хязгаар, хөрш улсуудыг заагаарай.
4. Ван Ань Ши-гийн шинэчлэлтийн ач холбогдлыг тодорхойлно уу.
5. Хойд, Өмнөд Сүн улс гэж ялган нэрлэх болсны учир юу вэ?

**Эдийн засаг.** Тан, Сүн улс олон сая хүн амтай, хүчирхэг эдийн засагтай байв. Хүн амын ихэнх нь хөдөө тосгодод тариалан эрхлэх ба хэдэн зуун мянгаас 1 сая хүртэл хүн амтай Чанань, Ханжоу зэрэг томоохон хотууд ч байв. Хотууд худалдаа, гар үйлдвэр, соёлын төв болж байлаа.

Сүй улсын үед Хөх, Шар мөрнийг усан сувгаар холбосон юм. Энэ нь Тан, Сүн улсын дотоод худалдааны хөгжилд чухал нөлөө үзүүлэв. Мөн Энэтхэг болон Зүүн Ази, Африкийн зүүн эргийн орнуудтай хийх гадаад худалдаа өргөжжээ. Хятадын худалдааны хөгжилт газар нутгийн тэлэлт, хүн ам, хотын өсөлт, усан онгоцны хөгжил, луужин болон худалдааны шинэ замуудыг нээсэн зэрэгтэй холбоотой.

Торгоны зам Хятадыг Дундад Ази, Иран ба Европтой холбосон хэвээр байв. Тан улсын үед хятад урчууд шаазан үйлдвэрлэх болжээ. Улмаар Сүн улсын үед урчуудын арга ухаанаар гангар шаазан хийх болжээ. Ваарыг бодвол шаазан нь нягт, ус уудаггүй байна. Гадаргууд нь шил будгаар паалан тавих ба цохиход маш тод дуу гардаг ажээ.

Мөн төмөрлөг, торго, ваар, мод, цаас, будгийн үйлдвэрлэл ихээр хөгжив. Бас Х зууны эхний хагаст Хятадад дарь гаргаж сурчээ. Европт үүнээс 300 жилийн дараа дарийг хэрэглэж эхэлсэн юм.

**Соёл, шашин.** Тан улсын Ханьлинд шинжлэх ухааны хүрээлэн, олон хотод номын сан, сургуулиуд ажиллаж түүх, гүн ухаан, утга зохиолыг голлон судалж байлаа. Ийн Тан, Сүн улсын үед хятадын соёл, урлаг, боловсрол ихээхэн ахижээ.

Хятад хүмүүс Күнз, Даогийн шашин суртлыг голлон шүтэж иржээ. Тан улсын хаан Ли Ши Миний үеэс Хятадад бурхны шашин хүчтэй дэлгэрсэн байна. Бурхны шашны дэлгэрэлт Хятадын уран барилга, барималд шинэ өнгө төрх оруулсан юм. Гэвч IX зууны эхээс Хятад дахь бурхны шашны лам, сүм хийд күнзийн сурталтнуудын шүүмжлэл, хавчилтад өртөх болжээ. 845 онд Ву Зон хааны зарлигаар бурхны шашны 4600 сүм хийдийг буулгаж, 250.000 ламыг хүчээр хар болгосон байна.

### Сурвалжийн мэдээ

1. Хятад урчууд шаазанг “толь шиг тунгалаг, цаас шиг нимгэн, харанга шиг дуу гардаг, нартай өдрийн нуур шиг гялалзан туяардаг байх ёстой” гэдэг байжээ.
2. Ваар, тоосго хийдэг, пийшин барьдаг, баримал барьдаг. Тэрчлэн амьтан шувуудын дүрс урладаг, будаг үйлдвэрлэдэг зэрэг арван төрөл зүйлийн урчууд байдаг. У.Гонгоржав. *Дундад зууны түүхийн дээж бичиг*. УБ., 2005.



Дараах асуултын дагуу ярилцаж мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Тан, Сүн улсын эдийн засгийн тулгуур юу вэ?
2. Энэ үеийн Хятадын дотоод, гадаад худалдааны хөгжилд нөлөөлсөн хүчин зүйлүүд юу вэ? Гар урлалд ямар амжилт гарсан бэ?
3. Хятад хүмүүс ямар шашныг шүтэж ирсэн бэ?
4. Хятадад бурхны шашин хэзээ хүчтэй дэлгэрэв? Бурхны шашны дэлгэрэлт ямар нөлөө үзүүлсэн бэ?

### ДҮГНЭЭРЭЙ

3.10

### ҮНЭЛЭЭРЭЙ

Тан, Сүн улсын байгуулагдсан, мөхсөн оныг нэрлэж, хэдэн жил оршин тогтносон хугацааг тооцоолоорой.	Тан, Сүн улсын газар нутгийг өнөөгийн Хятад улсын газар нутагтай харьцуулна уу.	Тан, Сүн улсын аж ахуй, соёлын хөгжилд гарсан ахиц дэвшил юу байсан бэ?
Он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт заагаарай.	Дүгнэн ярилцаарай.

## 11. ДУНДАД ЗУУНЫ ЭНЭТХЭГ

V-VI зуунд Энэтхэгт Гуптын эзэнт улс тогтов. Эзэнт улс мөхөхөд Энэтхэг олон жижиг улс болон хуваагдав. Тус орон Монголын байлдан дагуулал хүртэл Лалын шашинтны довтолгоонд өртжээ.



Гуптын эзэнт улсын дараа Энэтхэгт ямар өөрчлөлт гарсан бэ?

VI-VII зуунд Энэтхэгийн хойгт 70 хаант улс зэрэгцэн оршиж байлаа. Газар тариалангийн эртний бүс нутаг Инд, Ганга мөрний хөндий, тэнгис орчмын нутаг өндөр хөгжилтэй байв. Энэхүү бүс нутагт Энэтхэгийн хүчирхэг улсууд бүрэлдсэн юм. Хаант улсын тэргүүн ражи тансаг ордонд амьдарч, тусгайлан сургасан заан хөлөглөнө. Ражи нар нэг бол эвсэн найрамдаж, эсвэл өөр зуураа тэмцэлдэнэ. Дотоодын дайн дажинд доройтсон Энэтхэгийн хаант улсууд харийн булаан эзлэгчдийн хялбар олз болжээ.

X зууны сүүлчээс Дундад Ази, Иранд байгуулагдсан лалын улсын захирагчид Энэтхэгт довтолов. Тэд хүн амыг зэрлэгээр хядаж, хот, тосгод, сүмийг тонон сүйтгэжээ. Улмаар мусульманчууд Хойд Энэтхэгийг бүхэлд нь эзэгнэж, 1206 онд Дели төвтэй султант улсаа (1206-1526) байгууллаа. Делийн султант улсын ноёлох шашин нь лалын шашин байв. Харин энэтхэгчүүдийн дийлэнх нь индус шашинтай байжээ.

Делийн султаны хүчирхэг морьт цэргийн хороо нь булаан эзлэх дайны гол хүч байв. XIII зууны сүүлч, XIV зууны эхэн гэхэд тэд Энэтхэгийн ихэнх газар нутгийг нэгтгэжээ. Гэхдээ булаан эзэлсэн газар нутгаа удаан хугацаанд тогтоон барьж чадаагүй юм. Дотоодын бутралын үе буюу 1398 онд Дундад Азийг эзэгнэсэн Доголон Төмөр хаан (1336-1405) Делийн султант улсад довтолжээ. Тэр Энэтхэгт эзэн суусангүй, харин 20 мянган урчуудыг олзлон Самарканд хот руу асар их баялаг хүргүүлсэн гэдэг. XV зуунд Делийн султант улс хэд хэдэн улс болон задарчээ. Улмаар 1526 онд Төмөрийн угсааны Бабур Делийн султант улсыг мөхөөн Их Могол улсыг байгуулсан юм.

**Кастын байгуулал ба шашин.** Дундад зуунд бурхны шашин аажмаар Энэтхэгт нөлөөгөө алдаж, индус шашин ноёлох байр суурьтай болжээ. Индус шашны дээд бурхад Брахма, Вишну, Шиваг онцгойлон шүтнэ. Индус шашин кастын байгууллыг зөвтгөн дэмжиж байсан юм. Каст нь Эртний Энэтхэгт бүрэлдсэн брахман, кшатры, вайшья, шудр хэмээх дөрвөн үндсэн давхаргад (варна гэнэ) үндэслэжээ. Дундад зууны үед доод давхаргууд эрхлэх ажил, мэргэжлээс хамаарах жижиг бүлгүүдэд хуваагджээ (жишээ нь вайшьягийн давхаргын гар урчууд алт мөнгөний дархан, нэхмэлчин, гуталчин зэргээр хуваагдав). Ийм бүлгийг каст гэнэ. Дундад зууны үед ийм кастын тоо хэдэн мянгад хүрчээ.

### Тодруулга:

Каст бүрд өөрийн эрх, үүрэг бий. Хэрэв урчууд нэхмэлчдийн кастад хамаарах бол даавуу нэхэхээс өөр зүйл эрхэлж болохгүй юм. Брахман, кшатры нар өөрийн газарт ажиллахгүй, энэ ажлыг доод кастын хүмүүс хийх ёстой. Энэтхэгт бүх хүн ийм байх ёстой гэдэгт итгэдэг байв. Нэг кастаас нөгөөд орох, өөр кастын хүмүүс хоорондоо гэрлэхийг хатуу хориглоно.

Энэтхэгийн тариачид голын уснаас суваг, шуудуу татаж, цагаан будаа, улаан буудай, хөх будаа, чихрийн нишингэ, хөвөн, тарвас, амтат гуа, жүрж, халуун ногоо тариалан арвин ургац хурааж байв. Зүүн бүс нутагт жилд 2-3 удаа ургац авна.

Дундад зуунд Энэтхэгт олон шинэ хот байгуулагдсанаас хамгийн том нь Дели юм. Энэтхэгийн гар урчууд төмөрлөг боловсруулж, ган төмөр гарган авчээ. Үүний нууцыг Ойрх Дорнодын арабууд өвлөн авч, Европт дэлгэрүүлсэн тул Дамасскийн ган гэх болжээ.



Зураг 3.28. Лалын уран барилгын сор бүтээл Кутб-Минарыг XIII зуунд Дели хотод босгожээ. Дугуй цамхагийн өндөр нь 70 м, хээ угалзаар чимэглэсэн 24 цагирагтай юм.




Зураг 3.29. Энэтхэгийн Тамилнад мужид байх Индус шашны сүм Гопурам. X зуун.

Энэтхэгчүүд будаг гарган авдаг байв. Тэдний будсан даавуу, гоёл чимэглэлийн зүйл, гар урлалын бүтээгдэхүүн, мөн хүж, тансаг үнэртэн, халуун ногоо нь Европт өндөр үнэлэгдэнэ.

Шинжлэх ухаан ба соёл. Дундад зуунд Энэтхэгт математик, одон орон, анагаах ухаан уламжлан хөгжив. Энэтхэгийн хэд хэдэн хотод одон орныг судлах төв байжээ. Эмч нар 200 гаруй багаж ашиглан тархины мэс засал зэрэг нарийн ажилбар хийдэг болов.

Делийн султант улс байгуулагдсан цагаас Энэтхэгт лалын шашин дэлгэрч, индус, лал соёл зэрэгцэн орших болов. Лалын булаан эзлэгчдийн соёл Энэтхэгийн уран барилга, уран зурагт үлэмж нөлөө үзүүлсэн байдаг. VII-VIII зуунаас индусын сүмийг нүсэр цамхаг шиг барьж, ханыг нь товгор сийлбэр, баримлаар чимэглэх болжээ.

Зураг 3.30. Делийн султант улс







Дараах асуултын дагуу ярилцаж мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Индус, ислам, каст, варна хэмээх үгсийг тайлбарлана уу.
2. Энэтхэгт лалын шашныг хэн дэлгэрүүлсэн бэ?
3. Делийн султант улс байгуулагдсан болоод хүчирхэгжсэн тухай юу мэддэг болсон бэ? Газар зүйн зурагт заан тайлбарлаарай.
4. Дундад зуунд энэтхэгчүүдийн ахуй амьдрал, соёлд ямар өөрчлөлт гарсан бэ?
5. Индус ба лалын сүмийн зургийг харьцуулна уу. Ямар ялгаа байна вэ?

ДҮГНЭЭРЭЙ

3.11 ҮНЭЛЭЭРЭЙ

Гуптын эзэнт улс мөхсөн, Энэтхэгт Газнын султант довтлох болсон хугацааг тодорхойлж, хэдэн зуун жилийн түүх судласнаа тооцоолоорой.	VI-XI зууны үед Энэтхэгийн хойгийн газар зүйн зурагт ямар өөрчлөлт гарсан бэ?	Энэтхэгт ямар өөрчлөлт гарав.			
		Нийгмийн давхраа, харилцаа	Аж ахуй	Шашин шүтлэг	Шинжлэх ухаан
Он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт зааж тайлбарлаарай	Нэрлээрэй	Дүгнэн ярилцаарай.		

## 12. ДУНДАД ЗУУНЫ ЯПОН

VII зуунд хааны төвлөрсөн хүчтэй засаглал тогтсон Японд төрт ёс, нийгэм, соёлын талаар олон өөрчлөлт гарчээ.



Японы төрт ёс, нийгэм, соёлд ямар өөрчлөлт гарав?



Дундад зууны Японы хөгжилд байгаль, газар зүйн нөхцөл мөн Хятадын соёл үлэмж нөлөө үзүүлжээ.

Японы газар нутгийн 2/3 нь уулархаг бөгөөд япончуудын шүтдэг Фүжи уул 4000 м өндөр юм. Галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт, намрын улиралд зонхилон тохиолддог далайн хар шуурга япончуудыг тэвчээртэй, дасан зохицох чадвартай болгожээ. Япончууд газар тариаланд тохиромжтой бүх л газрыг ашиглан цагаан будаа, хүнсний ногоо тариалсаар иржээ. Япончууд цагаан будааг бол хүнсэндээ голлон хэрэглэдэг. Цагаан будаа тариалах нь нарийн няхуур хөдөлмөр, их арчилгаа шаардана.

VII-VIII зуунд Японд Яматогийн угсааны хаант засаг тогтов. Эзэн хааны эрх мэдлийг бэхжүүлэхийн тулд хөрш Хятадын загвараар өөрчлөлт хийжээ. Тухайлбал, 605 онд Яматогийн хаад Хятадын Сүй улсаас тэнно хэмээх цолыг авч хэрэглэсэн нь “эзэн хаан” гэсэн утгатай байв. Мөн Хятадын боловсрол, эрх зүй, улс төрийн онолыг авч хэрэглэжээ. 701 оны шинэтгэлээр албан хэрэгт хятад ханз үсгийг хэрэглэх болов. Яматогийн улсыг Ниппон буюу Мандах нарны орон гэж нэрлэжээ.

Япон улсын эзэн хаан 710 онд Хятадын Тан улсын нийслэл Чаньянь хотын загвараар хот барьж, Нара гэж нэрлэв. Тус хотод Бурхан багшийн 12 м өндөр хүрэл хөшөөг байрлуулсан юм. Улмаар 780 онд Нагасаки, 794 онд Хэйан (Киото) хотыг байгуулж, нийслэлээ болгожээ.

Тариачин бүр эзэн хаанаас газар авч, түүнд татвар төлдөг байв. Түшмэд алба хашсаныхаа төлөө том газар эзэмших бөгөөд энэ газрыг нь тариачид



Зураг 3.31. Яматогийн улс

боловсруулдаг байв. Х зуунаас газар эзэмших ийм журам өөрчлөгдөж, сурвалжтан ба том түшмэд газрыг үе залгамжлан эзэмших болжээ. Тариачид улсад татвар төлөхийн оронд эзэндээ ажиллаж, алба барих болов. Газрын эзэд хараат тариачдыг шүүн, шийтгэх эрхтэй байлаа. Ийнхүү Японд хамжлагат тариачид бий болжээ. Багахан эзэмшилтэй нэг нь хүчирхэг эздийн ивээлд багтаж, харьяат нь болов. Ийнхүү Японд эзэн харьяатын харилцаа тогтсон байна. Япон нь дундад зуунд феодалын харилцаа тогтсон Европ бус цорын ганц орон юм.

**Самурай.** Аажмаар том феодалууд хүчирхэгжин эзэн хаанд захирагдахаа больж, өөр зуураа тэмцэлдэх болжээ. Тэд өөрийн цэрэгтэй байсныг самурай (эзэндээ зүтгэх гэсэн утгатай) гэнэ. Хожим том феодалууд тэдэнд алба хаасны төлөө газар олгож, өөрийн харьяат болгожээ. Дундад зууны Японд нийт хүн амын 10% нь самурай нар байв. Гэтэл Англи, Францад хүн амын 1-2% нь рыцариуд байсан юм.

Самурай нар хүн амын онцгой давхарга байв. Самурайн нэр төр аминаас нь илүү үнэтэй. Тулааны талбараас зугтах, олзлогдох, дайснаас өшөө авч чадахгүй байх нь гутамшигт тооцогдох бөгөөд ийм тохиолдолд самурай харакири (гэдсээ хүүлэх гэсэн утгатай) үйлдэж, амиа егүүтгэдэг байв. Учир нь япончууд хүний сүнс нь гэдсэндээ оршдог гэж төсөөлдөг байжээ. Самурайн нэр төрийн дүрэм бусидо (дайчны замнал гэсэн утгатай) нь япон хүний ёс зүй, зан суртахуун, хүмүүжилд үлэмж нөлөөлсөн юм.



Зураг 3.32. Самурай

**Монголчуудын довтолгоо.** XII зууны сүүл хагаст Японд засгийн эрхийн төлөө тэмцэл хурцаджээ. Өрсөлдөгч хүчнүүдээс Тайра, Миномото угсааныхан хамгийн хүчтэй байв. 1185 онд болсон шийдвэрлэх тулалдаанд Миномото угсааныхан ялав. 1192 онд Миномото Ёритомо шёогун цолтойгоор төрийн эрхийг гартаа авч, эзэн хааны эрх мэдэл нэр төдий болов.

XIII зууны сүүл хагаст япончууд монголчуудын довтолгоонд өртөж эхлэв. Монголын их цэрэг довтлоход Японы өмнөд аралд самурай нар эрэлхэгээр тулалдан няцаажээ. Гэвч хэдэн жилийн дараа Монголын их цэрэг Японы эрэгт дахин иржээ. Хүч тэнцвэргүй энэ тулалдаан далайн хар шуурга монголчуудын хөлөг онгоцыг сүйрүүлснээр төгсөв. Япончууд бурхан тусаллаа хэмээн залбирч, хар шуургыг камиказе буюу бурхны салхи гэх болжээ. Ийнхүү япончууд тусгаар тогтнолоо хадгалан үлджээ. Япон улс бол бусдад эзлэгдээгүй дундад зууны цөөн орны нэг юм.

**Шашин ба соёл.** Япончууд нэн эртнээс шинто хэмээх шашин шүтлэгтэй байв. Шинто гэдэг нь Японоор бурхдын зам гэсэн утгатай. Энэ шашныг шүтэгсэд уул, ургамал, байгалийн юмс үзэгдэл, өөрийн сүнс, эзэдтэй гэж үздэг. Шинто шашны гол бурхан нь нарны бурхан Аматэрасу юм. Япончууд эзэн хаанаа Аматэрасу бурхны үр сад гэж дээдэлдэг.


Төрүү дундад зуунд Японд бурхны шашин Хятадаар дамжин дэлгэрчээ. Японд бурхны шашин дэлгэрсэн цагаас олон гайхамшигт сүм, Буддын баримлуудыг бүтээв. Японы уран барималчдын бүтээсэн хамгийн том Буддагийн хөшөө нь 20 м өндөр Дайбуцу (Их Будда) юм. Япончууд хятадын бичиг үсгийг хэрэглэж байгаад хожим өөрсдийн бичиг үсгийг зохион хэрэглэжээ.



Зураг 3.33. Хирагана. 813-867 онд холбогдох шавар суулганы хэлтэрхий дээрх бичээс уг бичгийн хамгийн эртний дурсгал юм.

Тайкагийн өөрчлөлтөөр Японд кана хэмээх бичиг үсэг зохиож хэрэглэв. Канаг хятад ханзтай хамт хэрэглэдэг. Кана-д хятад бичгээр тэмдэглэгдээгүй үгийг бичих ханзыг хирагана гэнэ. Харин гадаад үгийг тэмдэглэдэг ханзыг катакана гэдэг.

### Тодруулга:



Нарны эх бурхан Аматаэрасуг Японы төрийн далбаанд улаан цагирагаар бэлгэдэн дүрсэлжээ.



Дараах асуултын дагуу ярилцаж мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Ниппон, шинто, самурай, шёогун хэмээх үгсийг тайлбарлана уу.
2. Японд хаант засаглалын үндсийг хэн тавьсан бэ?
3. Японд Хятадын соёлын нөлөө үлэмж байсныг жишээгээр тайлбарлана уу.
4. Японд феодалын харилцаа тогтсон гэдгийг юугаар нотлох вэ?
5. Япон дахь монголчуудын довтолгооны талаар юу мэддэг болсон бэ?

ДҮГНЭЭРЭЙ

3.12

ҮНЭЛЭЭРЭЙ

Японд хаант засаглалын үндэс тавигдсан, самурай үүссэн цаг хугацааг зуунаар илэрхийлнэ үү.	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Японд ямар өөрчлөлт гарав.			Энэ өөрчлөлтийн үр дүн юу вэ?
		Төрт ёс, засаг захиргаа	Нийгмийн давхраа, харилцаа	Соёл, шашин	
Энэ хоёр үйл явдлын хооронд хэдэн зуун жил байгааг тооцоолоорой.	Японы арлууд Ази тивийн хаана байгааг заагаарай.	Тайлбарлаарай.			Дүгнэн ярилцаарай.

## ДЭД БҮЛГИЙН ДҮГНЭЛТ


1. Тохируулна уу. Дараах үгс ямар утга илэрхийлэх вэ?
  - а. Шинто 1. “бурхны салхи”
  - б. Харакири 2. “бурхны зам”
  - в. Камиказе 3. “гэдсээ хүүлэх”
2. Япончууд улсаа “Ниппон” гэж нэрлэсэн нь ямар утгатай вэ?
  - а. “Халуун ногооны арал” б. “Өглөөний цэвэр тунгалагийн орон”
  - в. “Мандах нарны орон”
3. Арабуудын эх орон нь:
  - а. Бага Ази б. Хойд Африк в. Дундад Ази г. Арабын хойг
4. Хижрийн тоолол аргын тооллын хэдэн оноос эхэлсэн бэ?
  - а. 570 он б. 622 он в. 630 он г. 711 он
5. Дараах үгсийг хүснэгтэд ялгаж бичнэ үү.  
Коран, хадж, Библи, епископ, Мухаммед, Иус, Аллах, индульгенц, мечеть

Лалын шашин	Загалмайтны шашин

6. Мужуудын нэрсийг баганад зөв ялган бичнэ үү.
  - а. Испани б. Мексик в. Иран г. Сири д. Хятад е. Өмнөд Энэтхэг

Арабын халифт улсын бүрэлдэхүүнд орсон	Арабын халифт улсын бүрэлдэхүүнд ороогүй

7. Аль нь буруу нотолгоо болох вэ? Майягийн түүх
  - а. Энэ ард түмэн Юкатаны хойгт амьдарч байв.
  - б. Майягийн хот бүр өөрийн захирагчтай байв.
  - в. Майя нар бичиг үсэггүй байв.
  - г. Чичен-Ица хотод одон орныг ажиглах байгууламж байсан нь өнөөг хүртэл уламжлан иржээ.
8. Аль нь буруу нотолгоо болох вэ? Ацтекийн түүх
  - а. Ацтекууд орчин үеийн Мексикийн газар нутагт нутаглаж байв.
  - б. Хүүхэд бүр сургуульд ижил боловсрол эзэмшиж байв.
  - в. Ацтекуудын нийслэл нь Теночтитлан байв.
  - г. Тариалах талбай хүрэлцэхгүй байсан тул ацтекууд “хөвөгч талбайд” тариалах болов.
9. Нөхөж бичнэ үү.  
Баруун Европ – рыцарь  
Япон - .....
10. Эртний Мексикийн пирамид ямар зориулалттай байсан бэ? Тэдгээр нь Хоёр мөрний Зиггурат, Египетийн пирамидын алинтай нь ижил төсөөтэй байсан бэ?
11. Үгийн сүлжээг бөглөөрэй.



### Хөндлөнгөөр

1. Арабын төрийн барьсан хоёр дахь халиф
2. Умард Алтан улсын нийслэлээ болгосон хот
3. Энэтхэгийн нийгмийн давхаргыг илэрхийлсэн үг
4. Тан улсын хүчирхэгжилтийн үед төр барьсан хаан
5. Япон улсын газар нутгийг бүрдүүлэгч том арлуудын тоо

### Босоогоор

1. Лалын шашныг үндэслэгч
2. Японы уламжлалт шашин

## IV БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН (XIII-XV ЗУУН)

### 4.1. ЧИНГИС ХААН БА МОНГОЛЫН ИХ ГҮРЭН

#### 1. Бидний мэдэх Чингис хаан

Түүхийн дунд үед монголчуудыг сэргээн мандуулсан Монголын үндэсний баатар Чингис хааны угсаа гарал, бүтээсэн гавьяа, үлдээсэн өвийг судлах нь чухал юм.



**ЧИНГИС ХААН**  
(1162-1227)



Тэмүжиний талаар юу мэдэх вэ? Монгол ба дэлхий дахинд ямар өв үлдээсэн бэ?

#### Сурвалжийн мэдээ


“Чингис хааны язгуур. Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж...”  
(МНТ. УБ., 2011. §. 1)



1. Тэмүжиний дээд өвөг хэнээс эхэлж байна вэ?
2. Энэ домгийн мэдээгээр Бөртэ чоно хаана ирсэн бэ ?

#### ЧИНГИС ХААНЫ ӨВӨГ ДЭЭДЭС

Бөртэ чоно  
Хоо Марал



1. "Монголын нууц товчоон"-д Тэмүжиний өвөг дээдсийн хэдэн хүнийг тэмдэглэсэн байна вэ?
2. Тэмүжин ямар хааны гуч хөвүүн бэ?

Тэмүжин 1162 оны өвлийн тэргүүн сарын шинийн нэгэнд Онон мөрний Дэлүүн болдог (Хэнтий аймгийн Дадал сумын төвийн зүүнтээ буй)-т Есүхэй баатрын Өүлэн хатнаас төржээ. Тэмүжин нь төмөрчин гэсэн утгатай үг юм. Багадаа эцгээс өнчирч, Тайчуудад баригдаж, ширүүн сорилтыг давж гарав. Агт морьдоо дээрэмдүүлж, Мэригийн довтолгоонд хатан Бөртэ-г булаалгаж байв. Тэмүжин хүүг амьдрал хатуу чанга, ухаалаг, зоримог, сэргэлэн, зальтай, алсын хараатай хүчирхэг эр хүн болгож төлөвшүүлэв.

Тэмүжин бөөгийн шашинтан, тэнгэр шүтлэгтэн байв. Түүний бүх амьдрал, үйл ажиллагаа бөөгийн шашинтай нягт холбоотой. Тэмүжин бөө нарын итгэлийг олж, тэднийг бусдыг өөртөө татах, улс байгуулах хатуу ширүүн тэмцэлдээ чадамгай ашигласан юм.

Чингис хаан бол Монголын нийгмийн захиалгаар гарч ирсэн түүхэн хүн юм. Тэр одтой тэнгэр орчиж, хөрсөн дэлхий хөрвөж байсан үймээнтэй цаг үед олон овог аймаг улсуудыг нэгтгэн нэгдсэн улс байгуулж, энх амар тайван амьдрах нийгмийн захиалгыг биелүүлсэн юм. Чухам тийм учраас түүний тэмцлийг өргөн олон нийт дэмжиж байв.

#### Тодруулга:

Чингис хааныг өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдөр төрсөн хэмээн үзэж, 2012 оноос Монгол улсад билгийн тооллын уг өдрийг “Монгол бахархал”-ын өдөр болгон жил бүр тэмдэглэж байна.

**Чингис хааны Монголд үлдээсэн өв.** Чингис хаан Монгол үндэстнийг сэргээн мандуулсан түүхэн гавьяат хүн юм. Хүннү гүрний үед Модун шаньюйн удирдлагаар мандан бадарч явсан эртний монголчууд аажим бууран доройтсон билээ. Дунд үеийн монголчуудын сэргэн мандалт, хүчирхэгжилтийг удирдан зохион байгуулагч нь Чингис хаан байв. Олон овог, аймаг, улсуудыг нэгэн улсад нэгтгэн захирч засаг захиргаа, хууль зүй, соёлын нэгдсэн бодлого явуулсан юм. Үүний үр дүнд Монгол үндэстэн бүрдэн тогтсон билээ.

Засаг захиргааны хувьд Хүннү гүрний үеийн мянганы зохион байгуулалтыг сэргээн хэрэглэсэнээр овог аймгаараа амьдрах хуучны ёсыг халжээ.

Чингис хаан олон жилийн салангид тархай, дайн самуунтай байдлыг эцэслэж, нэгдсэн улс байгуулснаар Монголын нийгэм-эдийн засаг, соёлыг хөгжүүлсэн их гавьяатай хүн юм.

Монголын нийгмийн амьдралын салбар бүрд их эзэн Чингис хааны хийсэн шинэчлэл, явуулсан бодлого тод ул мөрөө үлдээсэн ажээ. Үүнд худам (язгуур эртний) бичгийг төрийн албан бичиг болгосон соёлын бодлогоос эхлээд “Өнчдийн авлига” буюу өнчин ядуусыг тэтгэх нийгмийн халамжийн бодлого хүртэл бүгд багтана.

Чингис хааны удаах түүхэн гавьяа бол Монголын нийгмийн харилцааг өөрчилсөн явдал юм. Тэрбээр овог аймгийн зохион байгуулалт, овгийн ёс журмыг халж, эзэн харьяатын шинэ харилцааг тогтоосон билээ. “Их засаг” хуулиар шинэ нийгмийн харилцааг зохицуулан баталгаажуулжээ.



1. Тэмүжин хэзээ, хаана төрсөн бэ?
2. Тэмүжин улс байгуулах тэмцэлд бөө нарыг яагаад ашигласан бэ?
3. Өргөн олон нийт яагаад Тэмүжинг дэмжиж байсан бэ? Саналаа дэвшүүлээрэй.
4. Чингис хаан Монгол үндэстний өмнө ямар гавьяа байгуулсныг хэлэлцээрэй.

**Чингис хаан төр, цэргийн гарамгай зүтгэлтэн мөн.** Чингис хаан дэлхийн хэмжээний цэргийн агуу жанжин мөн. Түүний төмөр мэт хатуу сахилга баттай, нарийн зохион байгуулалттай цэргийн морины туурай хүрсэн газар бүртээ ялалт байгуулж байв. Монголын хөнгөн морин цэрэг дэлхийн хамгийн хүчирхэг цэрэг болж чадсан нь Чингис хааны нэртэй шууд холбоотой.

Чингис хаан дэлхийн дипломат харилцаанд шинэ ёсыг бий болгогч мөн. Тэр төрийн элчийг “алтан аргамж” гэж хүндлэн үзэж байв.

Чингис хаан бол дэлхийд шинэ дэг журам тогтоогч мөн. Ази ба Европ тивийг дамнасан “Монголын энх амгалан” буюу “Пакс Монголика” гэдэг үзэл суртлын үндсийг тавигч нь Чингис хаан юм. Ази ба Европ тивийг тэгнэн оршсон Монголын эзэнт гүрэн даяар нийтийн амар амгалан, энх тайван ноёрхож байлаа. Тиймээс XIII-XIV зууныг дэлхийн түүхэнд “Монголын зуун” хэмээн нэрийддэг юм.

**Чингис хааны дэлхий дахинд үлдээсэн өв.** Чингис хаан эдийн засгийн хамтын ажиллагааны үндсийг тавигч мөн. Чингис хаан Монголын ба эзлэгдсэн бусад орнуудын эдийн засгийн хөгжлийг дэмжин тэтгэгч байсан юм. Их хааны ивээл доор худалдаа наймаа хийж ашиг орлогоосоо төрд тушаадаг “ортог” гэдэг худалдаачид, худалдааны байгууллага бий болж, улс орон дамнах худалдаа хийх болжээ.

Чингис хаан оюун санааны чөлөөт үзлийг үндэслэгч мөн. Тэмүжин бөөгийн шашинтан байсан боловч бусад бүх шашин шүтлэгт хүндэтгэлтэй ханддаг байв. Их Монгол улсад ч, түүний үндэс суурийг нь тавьсан Монголын агуу эзэнт гүрэнд ч шашин хоорондын зөрчил тэмцэл, мөргөлдөөн гарч байгаагүй юм.

Чингис хаан салангид тусдаа байсан дорно ба өрнийн соёлыг холбож, дэлхийн хөгжлийг урагшлуулагч мөн. Дорно, өрнийн эдийн ба оюуны соёлын солилцоо худалдааны замаар болон шашнаар дамжин явагдаж байв.

Чингис хаан дэлхийчлэл буюу даяаршлын үндсийг тавигч мөн. Чингис хаан салангид, хол хөндий, дайсагналцсан Дорно, Өрнө хоёрыг монголчуудын туган дор даяаршуулах үндсийг тавьжээ.

Чухам ийм дэлхийн хэмжээний өөрчлөлт хийсэн учраас Чингис хааныг Дэлхийн II мянганы хүнээр өргөмжилсөн юм.

#### ТАЙЛБАР

Хориг гэдэг нь хориглосон, хориотой гэсэн утгатай үг юм.

#### Сурвалжийн мэдээ


“...хожим түүнийг мянгантай нь хамт Бурхан халдунд байдаг Чингис хааны их хоригийг хамгаалуулахаар томилон явуулжээ...Толуй хан, түүний ураг Хубилай хаан, Мөнх хаан, тэдний овгуудыг цөмийг тэр хоригт оршуулжээ. Чингис хааны бусад овог өөр хоригт байдаг” (Судрын чуулган. I боть. I дэвтэр)





1. Чингис хааныг яагаад дэлхийн хэмжээний хүн гэж үздэг вэ?
2. Пакс Монголика гэж юу вэ?
3. Чингис хааныг хэзээ II мянганы хүнээр тодруулсан талаар мэдэж аваарай.
4. Чингис хаан ба түүний хөвүүд, ач нарыг хаана оршуулсан бэ?

Он тооллын шугамд байгаа зарим үйл явдалд тохирох оныг гүйцээж бичнэ үү.



ДҮГНЭЭРЭЙ

4.1

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүх судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Чингис хаан			
		Уг гарал	Төрх байдал	Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг	Дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг
Тооцоолоорой.	Чингис хааны амьдралд холбогдох газар нутгаас нэрлээрэй.	Дүрслэн тайлбарлаарай.		Дүгнэн ярилцаарай.	

## 2. ЧИНГИС ХААН ИХ МОНГОЛ УЛСЫГ БАЙГУУЛСАН НЬ

Талын язгууртан баатар Тэмүжин Монголын аймаг, улсуудыг нэгтгэн 1206 онд Их Монгол улсыг байгуулжээ.



Тэмүжин Их Монгол улсыг хэрхэн байгуулсан, түүний ач холбогдол юунд орших вэ?

### Монголд нэгдсэн улс байгуулагдах түүхэн шаардлага:

- Аймаг улсуудын байнгын зөрчил, дайн самууныг зогсоох
- Аж ахуйгаа тайван эрхлэх, хөгжүүлэх
- Зүрчидийн Алтан улсын дарлал, түрэмгийллийг зогсоох
- Нэгдмэл төрийн доор энх амгалан амьдрах



1. Их Монгол улс байгуулагдах дотоод ба гадаад түүхэн шаардлагыг ялгаж, тайлбарлана уу.
2. Дээрх шаардлагуудыг хамгийн чухлаас нь эрэмбэлж дугаарлана уу.

### 1 үе. Монгол улсын хаан болохын төлөөх тэмцэл (1178-1189)

Тэмүжинг эх Өгэлүн (Өүлэн) язгууртны үзлээр хүмүүжүүлж хаан болох ёстойг багаас нь ойлгуулжээ. Монгол улсын анхны хаан Хабулын гуч хөвүүн Тэмүжин эрийн цээнд хүрээд хаан болохын төлөөх тэмцлээ эхлэв. Уг тэмцэл эцгийн анд байсан Хэрэйд улсын Тоорил хантай “эцэг, хөвүүний” харилцаа тогтоосон 1178 оны үеэс эхтэй.

1179 оны үед Тэмүжин Мэргидийн довтолгоонд өртөж, эхнэрээ алдав. Тоорил хан, багын анд Жамуха хоёрын тусламжтайгаар Мэргидийг ялж, хатан Бөртийг эргүүлэн авав. Тэмүжин, Жамуха хоёр жил гаруй хамт байгаад салсан нь тэдний хаан болох хүсэлтэй байснаас болсон хэрэг юм. Тэмүжин бөө нар болон хэдэн язгууртны дэмжлэгтэйгээр 1189 онд Хар зүрхний Хөх нуур гэдэг газар 28 настайдаа Монгол улсын хаанд өргөмжлөгджээ. Түүнд Чингис хаан цол өгсөн байна.

Гэхдээ тэр үед монголчуудын олонх Жамуха сэцний захиргаанд байв. Мөн цөөнгүй аймгууд биеэ даасан байдалтай оршиж байв. Жамуха түүнийг хууль бусаар хаан болсон хэмээн довтолов. 1190 онд Далан балжудад болсон уг байлдаанд Чингис хаан ялагджээ.


### ТАЙЛБАР

“Чингис” цолыг тэнгис гэсэн утгатай, бөөгийн догшин тэнгэрийн нэр, чин сэтгэл гэх үг зэргээр олон янз тайлбарладаг.



1. Тэмүжин хэнтэй холбоотон болсон бэ?
2. Тэмүжин хаана, хэзээ Монгол улсын хаан болсон бэ?
3. Тэмүжинд “Чингис” цолыг анх хэзээ өгсөн бэ?
4. Тэмүжин, Жамуха хоёр яагаад муудалцаж салсан бэ?
5. “Чингис” цолны тайлбарын талаар саналаа хуваалцаарай.

Зураг 4.1. Чингис хааны түүхэнд холбогдох газар нутаг



1. Он тооллын шугамд байгаа зарим онд болсон үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



## II үе. Монголын нэгдсэн улс байгуулахын төлөөх тэмцэл (1189-1206)

1189-1206 оны хооронд Чингис хаан өөрийн биеэр 17 удаа их, бага байлдаан хийсэн байна. Хааны даалгаснаар жанжин Чулуун, Худу, Хубилай, Зэв нар бие даан дайсан этгээдийг мөрдөн байлдаж байв.

1196 онд Тэмүжин Улз голд зугатан ирсэн Татар аймгийг Тоорил хантай хамтран довтолж бут цохив. Үүний тул Алтан улсаас Тоорил ханд “ван”, Тэмүжинд “чаутхури” цол шагнасан байна. Чингис хааныг эсэргүүцэгч язгууртнууд 1201 онд Жамуха сэцнийг Эргүнэ голд Гүр хаанд өргөмжилжээ. Тийнхүү Монгол улс 2 хаантай болжээ. 1202 онд Чингис ба Гүр хааны цэрэг Хэрлэн мөрний Хүйтэн гэдэг газар ширүүн байлдахад Чингис хааны тал ялав. 1202 онд Татар аймгуудыг Нөмрөг голын газарт байлдан дарж бүрэн устгажээ. Мөн онд Чингис хаан Мэргид аймгийг довтолж ялж эрхэндээ оруулжээ.

Хэрэйдийн Тоорил хан, Монголын Чингис хаан хоёрын зөрчил даамжирсаар эцэстээ байлдахад хүрсэн байна. Учир нь энэ хоёр хүний аль нэг нэгдсэн улсын хаан болох ёстой байв. 1203 онд хэрэйдүүд “багалзуур ид” хэмээн Тэмүжинийг хуурахаар завдсан нь амжилтгүй болов. Хоёр талын цэрэг Мау өндөрийн газар байлдахад Чингис хаан ялагдсан байна. Ялсан Хэрэйдийн Тоорил ханыг гэнэгүй найрлаж байхад нь Чингис хаан бүсэлж байлдаад Хэрэйд улсыг мөхөөжээ.

1204 онд говийн өмнөх Онгуд аймаг Чингис хаанд дагаар оров. Монголыг довтлохоор завдаж байсан Найман улсыг Чингис хаан 1204 онд дайлж, Наху гүн уулын тулаанд ялсан байна. Үүний өмнө бүх цэргээ мянганы зохион байгуулалтад оруулж, бие хамгаалагч 150 цэргийг бий болгожээ. 1205 онд Найман улсыг гүйцээн эзлэв. 1206 онд Онон мөрний эхэнд болсон их хуралдайгаар Тэмүжинийг Монгол улсын хаанд өргөмжилж, Чингис цолыг хоёр дахь удаагаа өгсөн байна.




1. Чингис хаан нэгдсэн улс байгуулах гэж хэрхэн тэмцсэн бэ?
2. Чингис хаан, Тоорил хан хоёр юунаас болж зөрчилдсөн бэ?
3. Нэгдсэн Монгол улсыг хаана, хэзээ тунхагласан бэ?

#### ТАЙЛБАР

Худ ураг болж буй хүмүүс залуу хосыг урт удаан хамт амьдрахыг бэлгэдэн хүзүүний мах чанаж хамт идэх ёсыг “багалзуур идэх” гэнэ.



1. Он тооллын шугамд тэмдэглэсэн үйл явдлууд хаана болсон бэ? Газар зүйн зурагт заана уу.



#### Тэмүжин хаан ширээнд залрав



Зураг 4.2.  
("Судрын чуулган"-ы чимэг зураг)

#### Их Монгол улс байгуулагдсаны ач холбогдол

- Аж ахуйн хөгжил түргэсэж, малын тоо толгой нэмэгдэв.
- Хүн ам өссөн.
- Монголчуудын амьжиргаа дээшилсэн.
- Тусгаар байдлаа хамгаалах цэргийн хүчтэй болсон.
- Дотоодын хямрал, дайн самуун зогссон.
- Монголчуудын төр ёсны шинэ үе эхэлсэн.



1. Их Монгол улс байгуулагдсан ач холбогдлыг эрэмбэлэн дугаарлана уу.
2. Их Монгол улс байгуулсны түүхэн ач холбогдлыг тайлбарлан ярилцана уу.
3. Монгол язгууртнуудын хувцас, хэрэглэлийг зургаас ажиглаж ярилцаарай.

### III үе. Их Монгол улсын гадаад байдлыг бэхжүүлсэн үе (1206-1227)


Чингис хаан олон жилийн хатуу хүчир тэмцлийн эцэст 1206 онд Их Монгол улсыг байгуулав. Харин шинэ залуу Монгол улсын гадаад орчин хүндэвтэр байв. Монголын зүүн өмнөд талд Зүрчидийн Алтан улс, урд талд Тангуд улс байв. Харин баруун талд Хар Хятан улс, түүний цаана хүчирхэг Сартуул улс оршиж байв. Тэдгээр улсууд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байв. Тиймээс Чингис хаан тэднийг довтолж, доройтуулах замаар гадаад байдлыг бэхжүүлэхэд хүрсэн ажээ. 1211 онд Алтан улсыг довтолж ялаад найрамдал тогтоов. Тангуд улсыг 1207, 1208 онд довтолж ялж холбоотноо болгов.

1207 онд ахмад хөвүүн Зүчийн (Зочи) цэргийг хойд зүг илгээж Ойрад, Хиргис, Хорь Түмэд, Ойн иргэдийг Монгол улсын бүрэлдэхүүнд оруулан авчээ. Мөн 1216 онд Хорь Түмэд аймгийн бослогыг дарж хойд нутгаа амар тайван болгов. 1209 онд Монголын баруун урд тал буюу Тэнгэр уулын хойгуур орших Уйгурын Идүгүд хаан, Хар Хятан улсын харьяат Харлуугийн Арслан хан нар Чингис хаанд дагаар оров.

1218 онд Чингис хаан Зэв жанжны цэргийг илгээж Хар Хятан улсыг эзлэн авчээ. Чингис хааны хийсэн гадаад дайнууд ихэвчлэн гадаад шалтаг, шалтгаантай байв. Тийнхүү хөрш зэргэлдээх улсуудыг эрхэндээ оруулснаар Чингис хаан Их Монгол улсын гадаад байдлыг маш сайн бэхжүүлж чадсан байна.


1218 онд Солонгос “зүүн хараат улс чинь больё” гэсэн захидал ирүүлж дагаар оров. Худалдаачид элч нарыг алж дээрэмдсэн тул Чингис хаан 1218-1225 онд Хорезм буюу Сартуул улсыг байлдан эзлэв. Баруун гар болох холбоотны үүргээ биелүүлээгүй Си Ся хэмээх Тангуд улсыг 1227 онд довтолж мөхөөв. Чингис хаан 1227 онд Тангуд улсыг дайлаар явж байхдаа мориноос унаж бэртсэний улмаас 65-тайдаа нас баржээ. Түүнийг Бурхан халдун (Их Хэнтий) уулын Их хориг гэдэг газар авчирч нутаглуулжээ.

Зураг 4.3. Их Монгол улс ба хөрш улсууд





1. Их Монгол улсын гадаад хөрш улсуудыг газар зүйн зургаас тодорхойлно уу.
2. Чингис хаан яагаад хөрш улсуудаа довтлох болсон бэ?
3. Чингис хаан хэзээ, юуны улмаас нас барсан бэ?
4. Он тооллын шугамд байгаа зарим онд болсон үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



ДҮГНЭЭРЭЙ

4.2

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Тэмүжин			Их Монгол улс байгуулагдсаны ач холбогдол
		Монголын хаан болов.	Их Монгол улсыг байгуулав.	Улсын гадаад байдлыг төвшитгөв.	
Тэмүжин Монгол улсын хаан болсон, Их Монгол улс байгуулагдсан оныг зуунаар илэрхийлнэ үү. Чингис хаан Их Монгол улсыг байгуулахад хичнээн жил зарцуулсан бэ?	Их Монгол улсыг байгуулахад түүхэнд холбогдох гол газар орныг нэрлээрэй.	Он цаг, газар нутаг, гол үйл явдлыг тодорхойлоорой			Тодорхойлоорой.

### 3. ЧИНГИС ХААН ТӨР УЛСАА ТӨВХНҮҮЛСЭН НЬ

1206 онд байгуулагдсан Монголын нэгдсэн улсын засаглалын хэлбэр ямар байв. Мөн төрийн тогтолцоо, засаг захиргааны зохион байгуулалт зэрэг зүйлийг энэ сэдвээс олж мэднэ.



Тэмүжин Их Монгол улсыг хэрхэн зохион байгуулж тогтоосон бэ?

1206 онд байгуулагдсан Монгол улс 1211 онд Алтан улсыг ялж хүчирхэг болсноо баталсны дараа нэрээ Их Монгол улс болгож өөрчлөв. Их Монгол улс бол хэмжээгүй эрхт хаант засаглалтай улс юм. Монголын төрийн дээд эрхийг хаан барьж байв. Их Монгол улсын төрийн бэлгэдэл болгон цагаан ба хар тугийг бүтээв. Есөн хөлт цагаан туг нь энх тайвны бэлгэдэл юм. Дөрвөн хөлт хар туг нь төрийн дайчин сүр хүчийг илтгэнэ. Хар тугийг дайн байлдаанд авч явдаг. Мөн алаг сүлд гэж бас байв. Төрийн тамгыг үйлдсэн нь хасбуу тамга гэж алдаршжээ. Тэр нь хас чулуугаар хийсэн тамга байв.

Чингис хаан Их Монгол улсыг зүүн, төв, баруун гэсэн гурван том түмэнд хуваан зохион байгуулав. Мөн хойд талын ойн түмэн гэдэг тусгай нэгж бас байжээ.

#### Сурвалжийн мэдээ

1. “Боорчу баруун гарын Алтай дэрлэхүүний түмнийг мэдтүгэй хэмээн зарлиг болов” (МНТ. УБ., 2011. §. 205)
2. “Мухали гоо ван зүүн гарын Харагун жидүнийг (Хянганы нуруу) дэрлэхүүний түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов” (МНТ. УБ., 2011. §. 206)
3. “Эдүгээ Наяа төвийн түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов”. (МНТ. УБ., 2011. §. 220)
4. “Эртиш гудас ойн иргэнд хүртэл нутаг дархлан нутаглаж ойн иргэнийг даруулан Хорчи түмэн мэдтүгэй хэмээн зарлиг болов” (МНТ. УБ., 2011. §. 207)

Чингис хаан төрийн шүүхийг байгуулж, өргөмөл дүү Шихихутугийг улсын дээд заргач (шүүгч)-аар томилжээ. “Их засаг” хуулийг Монголын төрийн гол хууль болгон эмхэлж цэгцлэхийг түүнд даалгажээ.

Чингис хаан хууль зарлигийг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих тусгай албан тушаалыг бий болгов. Энэхүү “засаг хэрэгжүүлэхийг хянагч” тушаалд хоёрдугаар хөвүүн Цагадайг томилжээ.

#### Сурвалжийн мэдээ

1. “Шихихутуг наян хоёр настайдаа заргыг шударгаар шүүж ялтнуудад их тусалж энэрч байжээ. Тэр айж цочин хэрэг хүлээх хэрэггүй гэж нэг биш удаа давтан хэлдэг байсан. Айлгүй үнэнээ хэл гэж хэрэгтэн нарт хэлдэг байсан” (Рашид-ад-дин Судрын чуулган. УБ., 2002)
2. “Цагадайд Их засаг хуулийн биелэлтэд хяналт тавих, шийтгэл гэгсгээлт оногдуулж байх ажлыг хариуцуулав”. (Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I. УБ., 2006. т.32)

Чингис хаан бөөгийн шашныг Монгол төрийн гол шашин болгон тунхаглав. Монголын бөөгийн шашны тэргүүнээр Баарин аймгийн Үсүн өвгөнийг томилсон байна.



#### Сурвалжийн мэдээ

1. "...бидний дотор дээрээс бэхи Үсүн өвгөн болтугай. Бэхи өргөөд цагаан дээл өмсөж цагаан агт унуулж суурь дээр суулгаж тахиж бас он сар саатаж тийн атугай хэмээн зарлиг болов". (МНТ. УБ., 2011. §. 216)
2. "Тэд аливаа мөргөл, аливаа шашныг үл хязгаарлана. Хязгаарлах нь битгий хэл тэд бүх шашныг тэтгэн дэмждэг" (Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I. УБ., 2006. т.12)

Зураг 4.4. Бөө

1217 онд улсын ван буюу гоо вангаар Мухалийг томилжээ. Мухали их хааны нэрийн өмнөөс зүүн хойд Хятадын нутгийг захирч байв. Их Монгол улсын цэргийг ерөнхийлөн захирах жанжин нь Хубилай баатар байв.

Чингис хаанд "дөрвөн хүлүг" ба "дөрвөн нохос" гэж нэрлэгдсэн цэргийн жанжин баатрууд байдаг байв. Харин "есөн өрлөг" гэж нэрлэгдсэн есөн хүн байгаагүй ажээ.

#### Сурвалжийн мэдээ

1. "Чингис хаан тэнд Боорчу, Мухали, Борохул, Чулуун баатар эд дөрвөн хүлгүүдээ цэрэг засаж илгээв" (МНТ. УБ., 2011. §. 163)
2. "Бас Чингис хаан ... эд Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй та дөрвөн нохсоо сэтгэсэнд зориулж илгээвээс..." (МНТ. УБ., 2011. §. 209)

Чингис хаан "Өнчдийн авлига" гэдэг нийгмийн халамжийн сан байгуулжээ.

#### Сурвалжийн мэдээ

"Хатгалдаанд амиа өрж урьд ам нээсний тусын тул ургийн ургаа хүртэл өнчдийн авлига аван автугай" (МНТ. УБ., 2011. §. 217)

Худам (язгуур эртний) монгол бичгийг төрийн албан бичиг болгож тунхаглав. 1220 онд улсын нийслэлийг Хэрлэн мөрний Ауруг ордоос Орхон голын Хархорум хотод шилжүүлэв.

Чингис хаан Их Монгол улсад хоёр хурлын байгууллага байгуулжээ. Эхнийх нь их хааны алтан ургийнхан оролцдог "Их эе" юм. Алтан ургийн "Их эе"-эр дайн хийх, хааны залгамжлагчийг сонгох зэрэг төрийн чухал асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргадаг. "Их хуралдай" бол Их Монгол улсын бүх ноёд, цэргийн жанжид оролцдог өргөн хэмжээний том хурал юм. "Их хуралдай"-гаар хаан өргөмжлөх, дайтах, алба татварын хэмжээ тогтоох зэрэг олон асуудлыг хэлэлцдэг байв.

Чингис хаан мянганы зохион байгуулалтыг Их Монгол улсын засаг захиргааны үндсэн нэгж болгон тогтоов. Мянган нь 1000 цэрэг гаргах мянган өрх айлаас бүрдэнэ. Мянганд олон овог аймгийн хүмүүсийг шинээр хуваарилан оруулсан тул урьдын овгийн байгууллыг өөрчилсөн хэрэг болжээ. Нийт 88 мянганы ноёдыг томилсон байдаг. Мянганы ноёдын ихэнх нь энгийн харц гаралтай хүмүүс байв.

Чингис хааны зарлигаар их хааны биеийг хамгаалах 150 хүнтэй хишигтэн цэргийг түм болгон нэмэгдүүлж, нарийн зохион байгуулалт тогтоов.

#### Сурвалжийн мэдээ


"Чингис хаан зарлиг болруун...надад хишигтэн, турхаг мянгад мянгадаас ялгаж...түмэн дүүргэн оруулагтун. Оруулахдаа хэвтүүл, хорчин, турхаг, мянгад мянгадаас оруулагтун." (МНТ. УБ., 2011. §. 224)






1. Юуны учир улсын нэрийг Их Монгол улс гэж өөрчилсөн бэ?
2. Их Монгол улс ямар засаглалтай байсан бэ?
3. Цагадай, Шихихутаг нарын хариуцсан ажил одоогийн ямар албан тушаалтай адил вэ?
4. Төрийн бэхи ямар үүрэгтэй вэ? Чингис хааны дөрвөн хүлүг ба дөрвөн нохост хэн хэн ордог бэ?
5. Их Монгол улсын төрийн байгууллага, засаг захиргааны зохион байгуулалт, нийгмийн бодлогыг тайлбарлаарай.
6. Их Монгол улсын төр, засаг захиргааны бүдүүвчийг нөхөн гүйцээнэ үү.

Бүдүүвч 4.1. Их монгол улсын төр, засаг захиргааны бүтэц



Он тооллын шугамд байгаа зарим онд болсон үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



ДУГНЭЭРЭЙ

4.3 ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Их Монгол улс				
		Хаан	Цэрэг, засаг захиргаа	Их эе, хуралдай	Шүүх, хууль цааз	Хүлүг ба нохос
Чингис хаан Их Монгол улсын хаан ширээнд хэдэн жил суусан бэ?	Их Монгол улсын түмнүүдийн орших нутгуудыг нэрлээрэй.	Тодорхойлоорой		Нэгтгэж дүгнээрэй		Нэрлээрэй

## 4. МОНГОЛЧУУДЫН АХУЙ АМЬДРАЛ, СОЁЛ

1206 онд Их Монгол улс байгуулагдаж, дотоодын олон жилийн дайн зогсов. Монгол нутагт төрийн нэгдмэл бодлого хэрэгжснээр хүн ардын аж амьдрал дэвжив. Монголын нийтлэг хэл, соёл бий болж улмаар хөгжив.



Монголчуудын нийгмийн байгуулал, ахуй амьдрал, соёл ямар байв?

**Нийгэм.** Их Монгол улсын хүн ам язгууртан ноёд, энгийн ард олон гэсэн ялгавартай байжээ. Язгууртнуудад хааны удмынхан буюу алтан ургийнхан, мөн түмэн, мянганы ноёд, улсын заргач, бэхи зэрэг тушаалтнууд багтана.

Улсын хүн амын үндсэн хэсэг нь малчид, анчин гөрөөчин ардууд байв. Тэд харьяалагдах байдлаараа хоёр янз байдаг. Хаан ба түүний удмынхны өмч болж, зөвхөн эзэндээ зүтгэх хүмүүсийг хувь буюу өмч иргэн гэнэ.

Мянганы ноёдод захирагдаж улсын албыг залгуулах хэсгийг “харьяат иргэн” гэнэ. Харьяат иргэд тайван цагт мал маллаж, хааны тогтоосон албыг гаргана. Мөн улсын өртөөг залгуулна. Дайны цагт цэрэг болно.

Мөн хүн амын зарим хэсэг байнгын цэрэг болж, хааны болон улс орны аюулгүй байдлыг хамгаалж байв. Түүнийг “хишигтэн” цэрэг гэнэ.

**Аж ахуй.** Монгол нэгдмэл төрт улс тогтож, малчид хот айлаар аж ахуйгаа хөтлөх болсноор малын тоо толгой өмнөхөөс өсөв. Үүний өмнө аймаг, улсууд гадны довтолгооноос хамгаалахын тулд хүрээний зохион байгуулалтаар нүүдэллэн аж төрдөг байжээ.

Монголчуудын эрхлэх үндсэн аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй хэвээр байв. Мал аж ахуй улсын эдийн засгийн гол тулгуур, айл өрхийн амин зуулга юм. Малчид улирал, цаг агаарын байдалд тохируулан таван хошуу малаа хариулж, бүх ашиг шимийг нь боловсруулан хэрэглэнэ. Адууг бусад малаас илүүтэй эрхэмлэн өсгөдөг байсан нь тээврийн гол хэрэгсэл, дайн байлдааны чухал унаа байсанд оршино.

Ан гөрөө эрт цагаас аж ахуйн чухал салбар хэвээр байв. Монголчууд ан гөрөөг хүнсний хэрэгцээгээ хангах болон цэрэг дайны бэлтгэл болгож хийдэг.

Гар урлал, тэр дундаа төмөрлөг боловсруулах ажил улам бүр хөгжив. Монгол цэргийн бүх зэвсэг хэрэглэлийг төмрөөр хийх тул төмрийн хүдэр хайлуулах, боловсруулах, эд хэрэглэл дархлах ажил хөгжив.

Монгол нутаг эрс тэс уур амьсгалтай тул газар тариалан эрхлэх тохирохгүй, гол мөрний саваар бага сага тариалан байв. Харин нэгдсэн улс байгуулагдснаас хойш тариа тарих явдал нэмэгдэж, олон цэргийг хүнсээр хангах зорилготой цэргийн тариалан бий болов. Монголын хаад Орхон, Сэлэнгэ голууд, Буйр нуурын сав газар, Алтайн нурууны өвөр зэрэг газруудад олзлогсод болон цэргээр тариа тариулж байв. Монголын цэргийн тариалангийн баруун цэг нь Алтайн нурууны Шаргын цагаан нуурын орчмын Чингай балгас юм.

### Сурвалжийн мэдээ

1. “Тэд тэмээ, үхэр, хонь, ямаа, адуугаар үлэмж баян.” (Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988)
2. “Мал сүрэг ихтэй болохоор...хоолонд хэрэглэнэ. ...Махыг нь хатааж борцолно. ...өвөлд бэлтгэн үүцлэн хадгална. Зунд нь гүүний сүү буюу айраг хэрэглэх учир өөр төрлийн хоолонд нэг их санаа тавихгүй”. (Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988)
3. “Монголчууд хэрвээ мориноосоо салбал юуг ч үл хийж чадна.” (Рашид-ад-Дин. Судрын чуулган. УБ., 2002)



1. Монголчууд ямар аж ахуй эрхлэн аж төрж байсан бэ?
2. Монголчууд хүнс хоолоо хэрхэн хадгалдаг байсан бэ? Бидэнд юу уламжлан ирсэн бэ?
3. Монголчууд өвөл ихэвчлэн мах, зундаа цагаан идээ хэрэглэхийн сайн тал юу вэ?

**Эдийн ба оюуны соёл.** Монгол улс байгуулагдах хүртэл монгол хэлт олон хүн ард өөрсдийгөө Хэрэйд, Мэргид, Татар гэх мэтээр тус тусын аймаг, улсаар нэрлэдэг байв.

Чингис хаан олон аймаг улсыг захиргаандаа оруулснаар бүгд Монгол улсын харьяат болов. Тэр цагаас хүн ардын ухамсарт “Монгол хүн”, “Монгол улсын газар нутаг”, “Монгол улсын төлөө” гэсэн нэгдмэл ойлголт төлөвшжээ. Монгол үндэстэн бүрдэн тогтоход төрийн албан ёсны худам монгол бичиг чухал үүрэг гүйцэтгэв. Нэгдсэн бичиг үсгээ дагаад нэгдмэл хэл, соёл бий болов.

Монголчуудын язгуур соёл нүүдлийн мал аж ахуйд суурилсан байдаг. Монголчуудын язгуур соёлыг эдийн ба оюуны хэмээн хуваан үзнэ.

Монголчуудын эдийн соёлд хувцас хунар, гоёл чимэглэл, гэр орон, малын тоног төхөөрөмжөөс авахуулаад хүний оюун ухаан гараар дамжин хүрч хийгдсэн бүх эд зүйл багтаж байв.

### Сурвалжийн мэдээ

1. “Эрэгтэй нь ч тэр, эмэгтэй нь ч тэр...дээл өмсөнө. Дээл нь дээрээсээ аван хормойгоо хүртэл задгай, цээжин хавьдаа давхар”.
2. “Эрд гарсан хүүхнүүд нь урдуураа задгай энгэртэй их л өргөн, газар шүргэсэн ууж өмсөнө. Тэд толгой дээрээ дугуй богтаг хэмээх нэгэн зүйл малгай тавина”. (Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988)



1. Монголчууд хувцсаа голчлон юугаар хийж байсан бэ?
2. XIII-XIV зууны монголчуудын дээл ямар байсан бэ? Өнөөгийн байдалтай харьцуулаарай.

### Сурвалжийн мэдээ

1. "...бургасан хана, унь хийж дээр тоононд өлгөн гэрээ босгоно. Гэрээ цагаан эсгийгээр бүрэх бөгөөд...заримдаа хар эсгий хэрэглэнэ. Орох хаалгандаа мөн үүд хэмээх эсгий зүүж түүнийгээ хээ гарган ширж оёсон байдаг".(Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988)
2. "Зарим гэрийг амархан буулгаж хурааж, ачиж тээж болдог байхад заримыг нь огт буулгаж болдоггүй зөвхөн тэргэн дээр бариастай зөөнө".(Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988)

Зураг 4.5. Гэр тэрэг



1. Гэр тэрэг гэж ямар гэрийг хэлэх вэ?
2. Гэр тэрэгт ямар хүмүүс амьдардаг вэ?

Монголчуудын оюуны соёлд ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэг, зан суртахуун, бичиг үсэг, боловсрол хүмүүжил зэрэг олон зүйл багтана. Монголчуудын олонх бөөгийн шашинтан байсан агаад бусад бүх шашин шүтлэгийг хүндэтгэдэг байв. Монгол хаад бөөгийн шашны зэрэгцээ тусгайлан тэнгэр шүтдэг байсныг тэнгэризм хэмээдэг. Монголчуудын оюуны соёлын төвд бөөгийн шашин оршиж байв.

Бичиг үсгийн соёлын хөгжилд Жужан (Их Нирун) улсын үеэс хэрэглэж ирсэн худам монгол бичиг чухал байр суурьтай байв. Монгол бичгээр бичсэн түүх, уран зохиолын олон зохиол бичигдснээс цөөхөн хэдэн дурсгал бидний үед иржээ.

Монголчуудын түүх, уран зохиолын хосгүй дурсгал бол "Монголын нууц товчоон" юм. Уг зохиолыг 1228 онд монгол газар, монгол хэлээр, нэр үл мэдэгдэх монгол хүн зохиожээ. "Монголын нууц товчоон"-д Чингис хааны түүхийг өвөг дээдсээс нас барах хүртэл бичжээ. Энэ зохиолыг хожим Өгэдэй хааны түүхийг өгүүлсэн 269-282-р зүйлийг нэмж залган бичсэн байна.

### Тодруулга:

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Монголын нууц товчоон"-ыг айл бүр гэртээ хүндэтгэн залах болсон юм.

Монгол бичгийн хамгийн эртний дурсгал бол 1225 онд сийлсэн “Чингисийн чулууны бичиг” юм. Түүнд “Чингис хаан Сартуул иргэнийг дагуулж бууж хамаг Монгол улсын ноёд Буха Сочигайд хурсанд Есүнгэ ондутрун гурван зуун гучин таван алдаст ондутлууаа” гэж бичжээ.

### Тодруулга

Алд гэдэг нь уламжлалт уртын хэмжүүрийн нэгж юм. Энэ нь хүн хоёр гараа дэлгэж сунгасан хэмжээ. Нэг алд 1.6 метр орчим байдаг.

### Сурвалжийн мэдээ

1. “Тэр (Өгэдэй хаан) орой бүр нумчид, бөхчүүдийн тэмцээн явуулан шалгарсныг нь шагнадаг байсан”. (Плано Карпини. *Монголчуудын түүх. УБ., 1988*)
2. “Тэдний он хоёдугаар сард эхэлдэг, их хаан түүний бүх харьяат нар нь баяр хийхдээ эрэгтэй, эмэгтэйчүүд цөм чадлынхаа хэрээр цагаан хувцас өмсдөг.” (Марко Поло. *Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987*)

### Чингисийн чулууны бичиг



Зураг 4.6. ОХУ. Санкт-Петербург

Монголчууд дан ганц малаа дагаж нүүхээс өөр юм мэддэггүй ард түмэн биш, хот суурин газрууд олныг байгуулсан ирсэн билээ. Монголчуудын хот суурин газруудыг хаадын орд өргөө, цэргийн бэхлэлт хот, гар урлал-тариалангийн суурин, үйлдвэрлэлийн суурин, тахилга тайлгын газар хэмээн ангилдаг. Их Монгол улсын үед хот байгуулалт шинэ өнгө төрхтэй болж өөрчлөгдөн хөгжив.

### Сурвалжийн мэдээ

1. “Тайзү Шэнвү хаан (Чингис хаан) ширээнд заларсан 15 дахь он (1220 он) ... тэр Хэлин (Хархорум)-ийг нийслэлээ болгохоор тогтов”. (*Хархорумын хөшөөний бичээс. 1346 он*)
2. “Тэнд хоёр хороо (дүүрэг) байдаг үүнд нэг нь Саррацин нарынх бөгөөд тэнд зах зээл бий ... худалдаачид, элч, нар тэнд олноор хуран цуглардаг. Нөгөө нь катайчуудын (хятад) хороо, тэд цөм гар урчууд болно. Эдгээр хорооны гадна ордны түшмэдийн олон том ордон байрлана. Тэнд янз бүрийн иргэний онгод шүтээний (шашны) 12 дуган ... лалын хоёр сүм ... христосын нэг сүм байдаг. Хотын эргэн тойрон шавар хэрэмтэй бөгөөд 4 хаалгатай. Зүүн хаалганы дэргэд шар будаа зэрэг амуу будаа, баруун хаалганы дэргэд хонь, ямаа, өмнөд хаалганы дэргэд шар үхэр, тэрэг, умард хаалганы дэргэд агт морь худалдаалдаг”. (*Г.Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 193-194*)

### ТАЙЛБАР

Европчууд Лалын шашинтнуудыг “саррацин” гэж нэрлэдэг байв.

### Тодруулга:

Нийслэл Хархорум хот Хангайн нурууны зүүн бие, Орхон голын эхэн урсгалын газар оршиж байв. Одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт үлдэл туурь нь оршдог.



Зураг 4.7. Хархорум хотын дээрээ бичигт хөшөөтэй чулуун яст мэлхий



1. “Монголын нууц товчоон”-ыг хэзээ, хаана, ямар хэлээр бичсэн бэ?
2. Чингисийн чулууны бичгийг хэнд, юуны учир, хэзээ босгосон бэ? Есүнгэ 335 алд харвасан нь хэдэн метр болох вэ?
3. Монголчууд ямар наадам хийдэг байсан бэ?
4. Хархорумыг хэн, хэдэн онд Их Монгол улсын нийслэл болгосон бэ?
5. Хархорум хотын оршин суугчдын шашин, соёл, аж ахуйг төсөөлж ярилцана уу.

### ДҮГНЭЭРЭЙ

4.4

### ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүх судалсан бэ?	Их Монгол улс				Хархорум хотын хөгжил цэцэглэлтийн талаар дүгнэлт өгөөрэй.
	Нийгмийн харилцаа	Аж ахуй	Хүн ардын ухамсар	Соёл, шашин	
Тодорхойлоорой	Дүрслэн тайлбарлаарай.				Дүгнэн ярилцаарай.

## 5. ЧИНГИС ХААН МОНГОЛЫН ИХ ГҮРНИЙГ ҮНДЭСЛЭСЭН НЬ


Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулав. Шинэ улсынхаа аюулгүй байдлыг хангах, тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэх шаардлага тулгарав. Чингис хааны явуулсан олон аян дайны үр дүнд Монголын эзэнт гүрний үндэс суурь тавигдав.



Их Монгол улс хөрш улс орнуудтай ямар харилцаатай байсан бэ? Хэрхэн улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хангасан бэ?

Их Монгол улс нь Алтан улс, Тангуд, Хар Хятан улсуудтай шууд нутаг залгаж оршиж байв. Чингис хаан эдгээр хөрш орнуудтай эрх тэгш найрсаг харилцаа тогтоох, тэдгээр улсаар хүлээн зөвшөөрүүлэх, гадаад аюулгүй байдлаа баталгаажуулахыг эрхэмлэжээ. 1218 онд Их Монгол улсад Солонгос улс дагаар орсон байна. Солонгосын вангаас “зүүн хараат улс чинь больё” гэсэн захиа ирүүлэв. Үүнд “Чингис хаан асар их баярлаж, их шан хүртээсэн” ажээ.

Зураг 4.8. Чингис хааны хийсэн аян дайнууд



### Чингис хаан Алтан улсыг доройтуулсан нь

Зүрчидийн Алтан улс (1115-1231) одоогийн зүүн хойд Хятадын нутагт оршиж байв. Алтан улс (Жин) нүүдэлчдийг хооронд нь эвдрэлцүүлж, ямагт дарлаж иржээ. Монгол аймаг, улсуудын хүн амыг хядах, мал сүргийг дээрэмдэх харгис аян дайныг 3 жил тутам явуулдаг байв. Мөн хаад язгууртнуудыг нь барин “модон илжиг”-т хадаж, тамлан алдаг байжээ. Алтан улсын хаан Монгол улсыг хүлээн зөвшөөрөх нь байтугай алба өгөхийг шаарджээ.

1211 онд Чингис хаан эцэг өвгөдийн өс хонзонг авах, ах дүү Хятан нарыг чөлөөлөхөөр Алтан улсыг довтолжээ. Олон боомт хотоо алдсан Алтан улс найрамдахыг хүсэж, гүнж, их хэмжээний алт мөнгө, эд агуурс өгсөн тул 1213 онд

дайнаа зогсоов. Гэвч уг найрамдал удаан үргэлжилсэнгүй. Хятадын Өмнөд Сүн улсад илгээсэн Монголын элчийг алсан тул 1214 онд дахин Алтан улсыг довтлов. Монголчууд нийслэл Жүндү ба бусад олон чухал газрыг эзлэв. 1217 онд Чингис хаан үлдсэн газрыг эзлэх үүргийг жанжин Мухалид даалгаж нутагтаа ирэв.

#### Сурвалжийн мэдээ

“Алтан ханы эсрэг дайлаар орохынхоо өмнө өөрийнхөө заншлаар овооны орой дээр ганцаар гарч бүсээ тайлж хүзүүндээ ороогоод дээлийнхээ товчийг тайлан өвдөг сөгдөж байж өгүүлрүүн Мөнх тэнгэр минь ээ, Алтан хаан самуун дэгдээх салхийг үүсгэж, хэрүүлийн эхийг тавьсныг та мэдэж захирч байгаа билээ. Татарууд баривчлан авч хүргүүлсэн гэм зэмгүй Охинбархаг, Амбагай хааныг минь хөнөөсөн билээ. Тэр бол миний аав, түүний өвөг дээдэс өвөг минь байсан болохоор цусан өшөөг тэднээс авах гэсэн байгаа билээ. Хэрэв чиний санаа шударга гэж болгоовол надад дээр тэнгэрээс хүч хайрла...Тэр мөргөлөө нэн их сүсэглэн үйлдэв” (*Рашид-Ад-Дин. Судрын чуулган. УБ., 2002. II боть. II дэвтэр. III анги*)

#### Чингис хаан Хар Хятан улсыг эзэлсэн нь

Монгол угсааны Хятан улс 1115 онд унахад нэг хэсэг нь Елюй Дашийн удирдлагаар баруун зүг нүүжээ. Тэд Или мөрөн ба Иссыккул нуурын сав газар очиж шинэ улс байгуулсан нь Хар Хятан (1124-1218) юм. Чингис хааны нэг дайсан Найман улсын хааны хөвүүн Хүчүлүг Монголын баруун талд орших Хар Хятан (баруун Ляо) улсад зугатан очиж, улмаар засгийн эрхийг авчээ. Ингэж Монгол улсын баруун талаас довтлох аюул бий болжээ. Иймд Чингис хаан Хар Хятан улсыг байлдан эзлэхээс өөр аргагүй болсон юм. 1218 онд Чингис хаан Зэв жанжны цэргийг илгээж, Хар Хятан улсыг эзлэн авав. Тийнхүү Их Монгол улс баруун талаараа Хорезм улстай хил залгах болжээ.

#### Чингис хаан Хорезм улсыг мөхөөсөн нь

Хорезм буюу Сартуул (1097-1225) нь Амударья ба Сырдарья мөрний сав газраар оршиж байсан газар тариалан, гар урлал, худалдаа их хөгжсөн улс юм. Чингис хааны 1219 онд илгээсэн Ухуна тэргүүтэй 450 худалдаачныг Отрар хотод хөнөөж, эд барааг нь дээрэмджээ. Чингис хаан Хорезм улсын хаан Мухаммед шахад элч илгээн буруугаа хүлээхийг шаардав.

Чингис хаан тэр үед зүүн зүгт Алтан улстай байлдаж байсан тул баруун зүгт Хорезм улстай байлдах төлөвлөгөө байсангүй. Нэгэн зэрэг 2 улстай байлдах нь монголчуудад эрсдэл ихтэй байсан юм. Гэтэл элч нарын хоёрыг нь алж, нэгийг нь доромжлон буцаажээ. Тиймээс Чингис хаан 1219 онд Хорезм улсыг дайлаар мордов. Монголын цэрэг Отрар, Женд, Балк, Хожент, Бухар, Самарканд, нийслэл Ургенч хотуудыг дараалан эзлэн авч, Мухаммед шах ба түүний хүү Желал-ад-динийг нэхэж Энэтхэгийн Инд мөрөн хүрсэн байдаг. Тийнхүү Чингис хаан 1225 он гэхэд Хорезм улсыг бүрэн эзлээд эх нутагтаа эргэж иржээ.



### Сурвалжийн мэдээ

“...Чингис хааны Сартуул иргэнээ, Ухуна тэргүүтэн зуун элчээ зэтгэж алагдаж, Чингис хаан өгүүлрүүн: «Алтан аргамжаа Сартуул иргэнээ, хэр тасалдан бүлгээ?» хэмээн Ухана тэргүүтэн зуун элчийнхээ өшил өшин, хясал хясан Сартуул иргэнд морильё хэмээн морилохуйд...” (МНТ. УБ., 2011. §. 254)

### Чингис хаан Тангуд улсыг мөхөөсөн нь

Тангуд буюу Си Ся улс (1038-1227) одоогийн Монгол улсын урд талаар оршиж байв. Чингис хаан Тангудыг Зүрчидийн Алтан улстай хүч хавсрахаас сэргийлэх, гадаад байдлаа бэхжүүлэх зорилгоор довтолсон юм. Анх 1205, 1207 онуудад Монголын цэрэг Тангудыг довтолсон байна. 1209 онд Чингис хаан өөрийн биеэр цэргээ авч Тангудыг дайлж, цэргийг нь хэдэнтээ бут цохижээ. Ялагдсан тангудууд Монголын холбоотон болохыг зөвшөөрч, гүнж, их эд агуурс, олон тэмээ өгчээ.

1218 онд Монголын цэрэг Тангудыг дахин дайлав. Хамгийн сүүлд 1225-1227 онд холбоотны үүргээ биелүүлж Хорезмын дайнд яваагүй, Алтан улстай Монголын эсрэг холбоо тогтоосон, Монголыг довтолсон гэсэн шалтгааны улмаас Чингис хаан Тангуд улсыг дайлж бүрмөсөн мөхөөжээ.

### Сурвалжийн мэдээ

“...Тангуд иргэний Бурханд элчин илгээрүүн: «Баруун гар чину болсу хэмээлээ, чи. Сартуул иргэнээ алтан аргамжаа тасалдаж, ололцон морилов, би. Баруун гар болон морил хэмээж илгээвээс, Бурхныг донгодоогүйеэ (дуугарахаас) урьд Аша Гамбу өгүүлрүүн: «Хүч ядан бөгөөтөл хан болтол юун?» хэмээж цэрэг үл нэмэн, их үг өгүүлж илгээжээ... Тэнд Чингис хаан өгүүлрүүн Мөнх тэнгэрт игээгдэж, алтан жолоо батад татаж ирвээс, тэнд мага (магад) болтугай...” (МНТ. УБ., 2011. §. 256)

### Отрар хотыг довтолсон нь



Зураг 4.9. (“Судрын чуулган”-ы чимэг зураг)



Дараах асуултын дагуу хариулж, мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

- Их Монгол улсын хөрш улсуудыг газар зүйн зурагт заана уу.
  - Хар Хятан
  - Тангуд
  - Хорезм
  - Алтан улс
- Алтан улс хэдий үед, хаана оршиж байсан бэ? Алтан улс Монголын аймаг, улсуудыг хэрхэн дарлаж байв?
- Чингис хаан яагаад Зүрчидийн Алтан улсыг довтлох болсон бэ? Чингис хааны Алтан улсыг довтлохын өмнө үйлдсэн ёслолыг тайлбарлана уу.




4. Хар Хятан улс хэдий үед, хаана оршиж байсан бэ? Чингис хаан хэзээ, юуны учир эзэлсэн бэ?
5. Сартуул улс хэдий үед оршиж байсан бэ?
6. Чингис хаан яагаад Хорезм улс руу дайрах болсон бэ?
7. Алтан аргамж гэж юуг хэлж байна вэ?
8. Зургаас Чингис хаан, түүний цэргүүдийг ялгаж олоорой. Тэдний төрх байдал, хувцас, морь, зэвсэг, хэрэглэл зэргийг нэрлэж ярилцаарай.
9. Тангуд улс хэдий үед, хаана оршиж байсан бэ? Чингис хаан яагаад Тангудыг довтлон мөхөөсөн бэ?

Хүснэгтийг нөхөж гүйцээнэ үү.

Улсууд	Дайлах болсон учир шалтгаан	Он цаг	Үр дүн
Алтан улс			
Хар Хятан			
Хорезм			
Тангуд			

Он тооллын шугамд байгаа зарим дутуу он ба үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



ДҮГНЭЭРЭЙ

4.5


ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Чингис хааны аян дайн		Чингис хаан цэргийн түүхэнд ямар байр суурь эзлэх бэ?
		Шалтгаан	Үр дүн	
Чингис хаан улсынхаа гадаад аюулгүй байдлыг хангахад хэдэн жил зарцуулсан бэ?	Чингис хааны байлдан дагуулсан улс орнуудыг нэрлээрэй.	Тодорхойлоорой.		Дүгнэн ярилцаарай.

## 4.2. МОНГОЛЫН ИХ ГҮРЭН БА ЭЗЭНТ УЛСУУД

### 1. Өгэдэй хаан Монголын их гүрнийг төвхнүүлсэн нь

Чингис хааны үндэслэсэн Монголын их гүрэн Өгэдэй хааны үед өргөжиж тогтов.



ӨГЭДЭЙ ХААН  
(1186-1241)



Өгэдэй хаан Монголын их гүрнийг хэрхэн байгуулж, өргөтгөсөн бэ?

#### **Улсаа бататгаж, хөгжүүлсэн нь**

1229 онд Хэрлэн мөрний Хөдөө аралд болсон Их хуралдайгаар Чингис хааны гуравдугаар хөвүүн Өгэдэйг Их Монгол улсын хаан болгов. Түүнд Далай хаан цол өргөмжилжээ. Чингис хааны үндсийг тавьсан эзэнт гүрэн Өгэдэй хааны үед Их гүрэн болж өргөжин тогтов. Их гүрний албан ёсны нэр нь “Их Монгол улс” юм.

Өгэдэй хаан их гүрнийг засаглан түвшитгэв. 1234 онд засгийн хэргийг ерөнхийлэн шийтгэх яам байгуулав. Их Монгол улсын бүх ажил хэргийг Иргэй ноёд, сангийн хэргийг Чингай ноёд, эзэнт гүрний баруун хэсгийн захиргаа, санхүүг М.Ялавач, зүүн хэсгийн захиргаа санхүүг Елюй чу цайд хариуцуулжээ. Тэрээр мянган бүрээс нутагчин гаргаж, бэлчээр нутаг олгож дуусгав.

Эзэн, харьяатын харилцааг бататгасан хууль гаргав. Уг хуулиар нэг арванаас өөр арванд орохыг хатуу хоригложээ. Хааны ордны дэг журмыг чангатгаж нарийсгав.

Далай хаан уургын улааг халж, нэгдсэн өртөөг байгуулав. Их гүрний бүх нутгийг нийслэл Хархорумтай өртөөгөөр холбожээ. Үүгээр Монголын эзэнт гүрний нутгаар аюулгүй, шуурхай зорчих болов. Говь цөл газар худаг ухуулж, малын бэлчээрийг ихэсгэсэн нь малчдын амьдралд сайнаар нөлөөлөв.

Эзэнт улсыг хамарсан татварын тогтолцоо бий болгожээ. Үүний тулд 2 удаа хүн амын тооллого явуулав. Монголчуудаас мал, бусад эзлэгдсэн орноос зоос, тариа, будаа, гар урлалын бүтээгдэхүүн авна. Худалдаанд гааль тогтоож, давс, мяндас эдлэлийн арилжаанд татвар оногдуулав. Гэхдээ худалдаачдыг гааль, татвараас хөнгөлөх, аюулгүй байдлыг нь хангах зэргээр дэмжжээ.

Эзлэгдсэн газар орноос уран дархчуулыг Монголд авчирч гар урлал, үйлдвэрийг хөгжүүлэн, хот суурин байгуулахад ашиглаж байв. 1235 онд Өгэдэй хаан нийслэл Хархорумыг их хотын хэмжээнд хүргэж өргөтгөв.



1. Чингисийн тооллын хэдэн онд Өгэдэй их хаанаар өргөмжлөгдсөн бэ?
2. Өгэдэй хаан төрийг засах ямар бодлого явуулсан бэ?
3. Өгэдэй хаан Хархорум хотыг хөгжүүлсний зорилго юу вэ?

### Өгэдэй хаан ширээнд заларсан нь



Зураг 4.10. ("Судрын чуулган"-ы чимэг зураг)

#### ТАЙЛБАР

Нэг бээр газар нь одоогийнхоор хоёр км орчим газар юм.

### Сурвалжийн мэдээ

1. "Өгэдэй хаан өгүүрүүн...бид элчин уулгалахдаа, улс бидүүлэн (хэсүүлж, тойруулж) уулгалмуй. Уулгалахун элчийн бээр явдал удаан буй. Улс иргэнээ бээр зовлон буй." (МНТ. УБ., 2011. §. 279)
2. "Цагадай...би эндээс замууд эсрэг барилдуулсугай. (угтуулан олон өртөөг байгуулсугай)...Бат бээр эсрэг замуудаа барилдуултугай..." (МНТ. УБ., 2010. §. 279)
3. "Ямар нэг самуун дэгдээсэн орон, эсхүл ямар нэг ноён, эсхүл аль нэгэн чухал хэргийн тухай их хаанд айлтгах хэрэг гарвал элч нар өдөрт хоёр зуу, зарим үед хоёр зуун тавин бээр явдаг...элч төчнөөн бээр явах хэрэг гарвал шонхортой гэрэгэ түүнээ өгнө... гэдсээ боогоод, толгойгоо ороогоод, байдаг тараар давхиулан хорин таван бээр газар нэг өртөөнд ирэхэд сэлэх морьд, хурдан морьдыг бэлтгэсэн байдаг. Тэд огт сааталгүй морьдыг дөнгөж унамагцаа мориныхоо хар хурдаар давхин дараагийн өртөөнд очиход мөн л морьд бэлтгэсэн байдаг." (Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987)



1. Их хаан ба монголчуудын хувцас, морь зэрэг бусад зүйлсийг тайлбарлаж ярилцана уу.
2. Өгэдэй хаан яагаад улсын өртөө байгуулах болсон бэ? Өгэдэй хааны өртөө байгуулах төлөвлөгөөг хэн дэмжиж, байгуулалцсан бэ?
3. Элч чухал, яаралтай зарлиг мэдээг өртөөгөөр хэрхэн зохих хүнд нь хүргэдэг вэ? Элч нарыг өртөөгөөр явах эрх юугаар баталгааждаг байв? Шуурхай хэрэг гарсан үед өртөөгөөр нэг өдөрт ойролцоогоор хэдэн км газар туулдаг байсан бэ?

### Сурвалжийн мэдээ

1. “Өгэдэй хаан өгүүлрүүн...зуун хониос нэг хонь гаргаж, мөн зуур үгээгүүн дутуунаа (ядуу зүдүү хүмүүст) өгтүгэй.” (МНТ. УБ., 2011. §. 279)
2. “Өгэдэй хаан өгүүлрүүн...усгүй газраа худгууд эрүүлж (малтуулж), гаргуулж, улс иргэнийг ус өвснөө (өвсөнд) хүргүүлэв.” (МНТ. УБ., 2011. §. 281)
3. “Тайзун (Өгэдэй хаан) хааны ивээлд бүх хүн амьтан энх тунх, өнөр өтгөн байлаа. Хаан бээр (Хархорумд) анх удаа нэгэн ордон (Түмэн амгалант)-ыг барьж байгуулав. Тиймээс нэгэн буддын шашны сүм ч барилаа.” (Хархорумын хөшөөний бичээс. 1346 он.)

### Өгэдэй хааны мөнгөн зоос



Зураг 4.11.

Хархорум хотод 1237-1238 онд дэлдсэн зоос Өгэдэй хааны дэгрээ тамгатай, монгол бичгээр ХОРМ, арабаар КХ-Р КХОР-М хэмээн бичсэн. Хархорум хотын тууриас олджээ.



1. Өгэдэй хааны үед монголчуудын аж байдал ямар байсан бэ? Өгэдэй хаан нийгмийн ямар хэсгийг өргөж тэтгэж байсан бэ?
2. Яагаад говьд худаг малтаж ус гаргуулав? Үүний ач тус юу вэ?
3. Өгэдэй хаан ямар ордон, шашны сүм бариулсан бэ?
4. Өгэдэй хаан зоос дэлдүүлсний учир юу вэ?

### Далай хаан Өгэдэй агуу их гүрнийг байгуулав

Өгэдэй хаан улс орныхоо гадаад аюулгүй байдлыг бүрэн хангах эцгийн бодлогыг үргэлжлүүлэв. Тэрээр гол дайсан Алтан улсыг 1231-1234 он гэхэд гүйцээн эзлэн авав.

Монголын элчийг алсан Солонгосыг 1231, 1232, 1235 онд довтлон эзэлж, түүнийг захирах 70 даргачийг суулгажээ. 1235 оны Их хуралдайгаар өрнө зүгт дайн хийхээр тогтов. Зүчийн (Зочи) хүү Бат уг дайныг удирджээ. Эл аян дайныг Кипчакийн аян гэдэг. Батын цэрэг 1236-1241 онд Булгар, Москва, Рязань, Киев зэрэг Оросын хот улсууд, улмаар, Крым, Польш, Унгарыг эзлэв. Монгол цэрэг Адриатын тэнгис, Австрид хүрчээ.

Чормаган ноёны цэрэг 1236 онд Иран, Ирак, Сирийн зарим нутгийг эзлэн авчээ. Түүний дараа 1239 онд Армен, Гүрж улсуудыг эрхэндээ оруулжээ. Өгэдэй хааны байлдан дагууллаар Их Монгол улс дэлхийн хэмжээний агуу гүрэн болов. Далай хаан Өгэдэй эзэлсэн газар орнуудыг захиран алба татвар хураах алгинч, таммачин, даргачин нарыг өргөтгөж бүхэл бүтэн тогтолцоо болгов.

Зураг 4.12. Өгэдэй хааны байлдан дагуулал



Мэдээлэл, газар зүйн зургийг ашиглаж асуултад хариулаарай.

1. Өгэдэй хааны аян дайны шалтгааныг тодорхойлно уу.
2. Өгэдэй хаан Алтан улсыг хэзээ, хэрхэн эзэлсэн бэ?
3. Өгэдэй хаан өрнө зүгт ямар улсуудыг байлдан дагуулсан бэ?
4. Өгэдэй хааны үеийн Монгол гүрний хил хязгаарыг тогтооно уу.
5. Өгэдэй хаан эзэлсэн газар орноо хэрхэн захирч байв?




Өгэдэй хаан өөрийн үйл ажиллагааг дөрвөн сайн, дөрвөн муу үйлээр тодорхойлж хэлснийг “Монголын нууц товчоон”-д тэмдэглэжээ. Түүний сайн, муу үйлийг ялгана уу.

- Алтан улсыг эзэлсэн.
- Бор дарсанд ялагдсан.
- Өртөө замууд тавиулсан.
- Овгоосоо охин авчруулсан.
- Эцгийн шадар Доголху-г хилсээр хорлосон.
- Усгүй газар худаг ус гаргуулсан.
- Гөрөөсийг бусдын нутагт оруулахгүй гэж хороо босгосон.
- Алгинчин, тамгачин тавьж улсыг амар тайван болгосон.

Сайн үйл	Муу үйл

## Монгол цэрэг



Зураг 4.13. Монгол цэрэг



1. Монгол цэргийн хувцас, зэвсэг, хэрэгслийг жагсаан бичиж тайлбарлана уу.

Он тооллын шугамд байгаа зарим онд болсон үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



### ДҮГНЭЭРЭЙ

4.6

### ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Өгэдэй хааны бодлого үйл ажиллагаа				Монгол болон дэлхийн түүхэнд Өгэдэй хаан ямар байр суурь эзлэх вэ?
		Төр, цэрэг, засаг захиргаа, хууль	Аж ахуй, эдийн засаг, хүн ардын амьдрал	Хот, шашин суртал	Байлдан дагуулалт	
Өгэдэй хэдээс хэдэн онд, хичнээн жил хаан суусан бэ?	Газар зүйн зурагт нэр гарсан улс орон, газар нутгийг олж заагаарай.	Хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг тус бүрд нь оновчтой нэг үгээр тодорхойлоорой.				Дүгнэн ярилцаарай.

## 2. ГҮЮГ, МӨНХ ХААДЫН ҮЕИЙН МОНГОЛЫН ИХ ГҮРЭН

Гүюг ба Мөнх хаадын үед Монголын их гүрэн (Их Монгол улс) өргөжин тэлж, цэцэглэн хөгжжээ.



Гүюг ба Мөнх хаан Их Монгол улсыг хэрхэн удирдан жолоодсон бэ?

**Их хаан Гүюгийн засаглал.** 1246 онд Тамир голын Шар ордонд болсон Их хуралдайгаар Өгэдэй хааны хөвүүн Гүюгийг Их Монгол улсын хаанаар өргөмжилжээ. Гүюг хаан 1248 он хүртэл Монголын агуу эзэнт гүрнийг захирав. Тэрээр эх Дөргэнэ хатны төр хамаарах үед суларч алдагдсан хууль ёсыг сэргээжээ. Дөргэнэ хатны зарлиг болон алба татвар авах эрх олгосон гэрэгэг хүчингүй болгов. Төр үймүүлсэн Абдул аль Рахман, Фатима нарыг цаазалсан байна. Чингай ноёныг эзэнт гүрний сайдаар томилжээ. Эзэлсэн нутгаа 3 хувааж захируулсан байна. Хойд Хятадыг Мухаммед Ялавач, Төв Азийг Масуд Ялавач, баруун Азийг Аргун нараар захируулав. Эзэнт гүрний алба татвар, цэрэг татах явдлыг цэгцлэх үүднээс 1247 онд хүн амын тооллого явуулжээ.

1247 онд Гүюг хаан өмнөд Хятадын Сүн улсыг эзлэх дайныг эхлүүлэв. Мөн онд Элжигидэй ноёны цэргийг баруун Ази руу илгээжээ. Их хаан 1248 онд Эмил нутагт очиж биеэ илааршуулна хэмээн баруун зүг хөдөлжээ. Үүнийг өөрийн өрсөлдөгч Батыг гэнэдүүлэн цохихоор хөдөлсөн гэж үзсэн нь бий. Гэвч Гүюг хаан 1248 оны 4 сард замдаа өвчний улмаас нас баржээ.

### Сурвалжийн мэдээ

1. "... их хааныг сонгох ёслолын их хуралдайд ... бэлэг хүргээр ирсэн ба алба гувчуур өргөөр ирэгсэд, дагаар орсон газрын олон султан болон бусад ноёдууд, хурилдайд уригдан оролцогсод, эзэлсэн газрын даргач нар гэх мэтээр чухамдаа дөрвөн мянга гаруй элч байсан" (Г.Рубрук. *Дорно этгээдэд зорчсон минь*. УБ., 1988. т. 70)
2. "их хаан ... дунд зэргийн нуруутай, маш хэрсүү ухаалаг бөгөөд хэтэрхий зальжин байртай бас буурьтай бөгөөд ихэмсэг зантай ажгуу. Түүнийг хий хоосон инээвхийлэх буюу ямар нэгэн гэнэхэн дэмий явдал гаргахыг хэн ч үзээгүй." (Г.Рубрук. *Дорно этгээдэд зорчсон минь*. УБ., 1988. т. 76)



1. Чингисийн тооллын хэдэн онд Гүюг их хаанаар өргөмжлөгдсөн бэ?
2. Гүюгийг хаан суух ёслолд гадны олон төлөөлөгчид оролцсоны учир юу вэ?
3. Гүюг хааны бие бялдар, зан байдлыг тодорхойлно уу.



### Гүюг хааны тамганы дардас



Зураг 4.14.

Уг тамгыг Гүюг хаанаас Ромын Пап лам IV Иннокентийд илгээсэн захидалд даржээ. Тэр захиаг 1920 онд Ватиканы архиваас олсон байна. Тамганы үг нь “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын Далай хааны зарлиг ил булха иргэн дор хүрвээс бүширтүгэй аюутугай” юм.

#### ТАЙЛБАР

Ил-харьяат, булха-дайсан, дайсагнагч гэсэн утгатай үг юм.



1. “Мөнх тэнгэрийн хүчин дор” гэж эхэлж байгаагийн учрыг хэлнэ үү.
2. Уг тамганы бичээс ямар утга илэрхийлж байгааг тайлбарлаарай.

Он тооллын шугамд байгаа зарим онд болсон үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



**Их хаан Мөнхийн засаглал.** 1251 онд Хэрлэн мөрний Хөдөө аралд болсон Их хуралдайгаар Толуйн хөвүүн Мөнхийг Их Монгол улсын хаанд өргөмжлөв. Мөнх хаан 1259 он хүртэл Их Монгол улсын хаан ширээнд сууж, агуу эзэнт гүрнийг захирсан юм. Түүнийг хаан болоход Зүчийн улсын эзэн Бат гол үүрэг гүйцэтгэжээ. Мөнх хаан болмогцоо өөрийн эсрэг байсан Өгэдэй, Цагадайн угсааны олон ноёдыг цаазаар авчээ. Мөнхсарыг их заргачаар томилж, төв засгийн газрыг хариуцуулав. Төв засгийн газар мөнгө санхүү, татвар, худалдаа, өртөө зам, хааны сан хөмрөг гэсэн салбаруудтай.

1251 онд Мөнх хаан эзэлсэн суурьшмал нутгийг 3 бүсэд хуваажээ. Хойд Хятадад Мухаммед Ялавачийг, Төв Азид Масуд Ялавачийг, Иранд Аргун нарыг төлөөний сайдаар суулгажээ. Төлөөний сайдаас бусад ноёд алба татвар татах, зарлиг тараахыг хориглосон байна.

Мөнх хаан өртөөг цэгцэлж, албаны хүмүүс илүү хэрэглэхийг хориглов. Алба татварыг шинэчлэн цэгцлэв. Малчдаас 100 мал тутмаас 1 мал татварлаж, 100 хүрэхгүй малтайг татвараас чөлөөлөв. Хятад, Төв Азийн баян хүнээс жил бүр 10 алтан зоос, ядуу хүнээс 1 алтан зоос татаж байхаар болов.

Мөнх хаан агуу эзэнт гүрэн даяар бүх шашин шүтлэгийг хүндэтгэж, шашин сүм хийдүүдэд тэгш хандаж байв. Түүний үед нийслэл Хархорумд дэлхийн янз бүрийн шашинтны шашны маргаан мэтгэлцээн 4 удаа болжээ.

### Сурвалжийн мэдээ

1. Бат хаан "... Чи (Бэрх) түүнийг (Мөнхийг) хаан ширээнд суулга, хэн яса-гаас (Их засаг хуулиас) гажваас тэр хүн алдах, үхэх". (*Рашид ад дин. Судрын чуулган. II боть. УБ., 1994*)
2. Мөнх хаан "...Бөө удган ба бэлэгдэх, төлөгдөх ёсыг даанч итгэмүй". (*Юань улсын судар. III бүлэг*)



1. Мөнхийг хаан суухад Бат яагаад дэмжсэн бэ? Таамаглал дэвшүүлж ярилцаарай.
2. Мөнх хаан Өгэдэй, Цагадайн удмын ноёдыг цаазалсан шалтгаан юу вэ?
3. Мөнх хаан өртөө, алба татварын талаар ямар бодлого хэрэгжүүлсэн бэ?
4. Мөнх хаан шашин шүтлэгийн талаар ямар бодлого явуулсан бэ?
5. Мөнх хаан хэний хөвүүн бэ?
6. Чингисийн тооллын хэдэн онд Мөнх их хаан болсон бэ?

### Мөнх хаан ширээнд заларсан нь




Зураг 4.15. ("Судрын чуулган"-ы чимэг зураг)

### Сурвалжийн мэдээ

1. "Биньчэн жил (1256 он) нэгэн том суварга босгов. Дээр нь нэгэн сүрлэг сайхан асар барив...Асар нь таван давхар байлаа. Өндөр нь 300 тохой. Хамгийн доод давхар дөрвөн талдаа танхимтай. Танхим бүр долоон тасалгаатай Тэдгээрийг тойруулаад бурхан багшийн дүр баримлуудыг байрлуулсан. Энэ нь ном сударт заасан ёсонд бүрэн нийцжээ". (*Хархорумын монгол бичээс. 1346*)
2. Мөнх хаан "...христос шүтлэгтэн, саррацин, туин...та нарын хэн нь ч өөрийн ёс (шашин)-ыг илүү сайн, бичиг ном (судар ном)-оо илүү үнэн гэдэг. Иймд та нар цөм нэг дор хуран цуглаж, сургаал номоо харьцуулан үзэж, жинхэнэ үнэн зөвийг мэдүүлэхийн тулд хүн бүр дагадаг сургаалаа бичтүгэй гэлээ". (*Г.Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 199-204*)

### Хархорум хотын мөнгөн мод



Зураг 4.16.

Мөнх хаан Хархорум хотыг хөгжүүлэхэд их анхаарав. Тэр Өгэдэй хааны барьсан Түмэн амгалант ордны хэсэгт Францын дархан Вильгельмээр том мөнгөн мод урлуулжээ. Мөнгөн модны орой дээр бүрээ барьсан Ангель гэдэг тэнгэрийн элчийн дүрийг урлажээ. Модны дотуур дөрвөн хоолой татаж, тэдгээрийн амсрыг алтан шармал могойн ам маягтай үйлдэж, сүүлээр нь мөнгөн модыг ороолгожээ. Эдгээр хоолойн нэгээс дарс, нөгөөгөөс айраг, гурав дахиас балын ундаа, дөрөв дэхээс будааны шар айраг гоождог. Модны доор тэдгээр амттан ундааг юүлэх мөнгөн савыг хоолой бүрийн доор байрлуулжээ.



1. Хархорум хотод ямар, ямар шашинтнууд амьдарч байсан бэ? 1256 онд Хархорумд ямар шашны сүм барьж дуусгасан бэ?
2. Мөнх хааны шашин шүтлэгийн талаарх бодлогыг дүгнэнэ үү.
3. Мөнгөн модноос урсах дөрвөн амттанг ямар аргаар гаргаж байсан бол?

Зураг 4.17. Гүюг, Мөнх хааны байлдан дагуулал



Мөнх хаан өмнөд Хятадын зарим нутаг, өнөөгийн Иран, Ирак болон Ар Кавказ, Бага Азийн газар орныг эрхшээлдээ оруулжээ.

Хойд Хятадыг бүрэн захирах цэргийн даргаар дүү Хубилайг томилжээ. Тэрээр 1257 онд Ганьсу муж, дараа жил нь Юньнан дахь Дали улсыг байлдан эзэлжээ.

Мөнх хааны дүү Хүлэгү Ираны үлдэгдэл Исмайлитын улсыг эзлэх дайныг удирджээ. Тэр 1256 оны сүүлээр Исмайлитын улсыг, 1258 оны 2 сард Багдад хотыг эзэлж Ираныг бүрэн байлдан дагуулсан байна.

1256 онд Их Монгол улсын ноёд язгууртнуудын Их хуралдай хуралдаж, Хятадын өмнөд Сүн улсыг дайлах шийдвэр гаргав. Уг дайн 1257 онд эхэлжээ. Мөнх хаан Хятадын боомт хотыг байлдан эзэлж яваад Сычуань орчим 1259 онд өвчнөөр нас баржээ.

### Мөнх хааны гэрэлт хөшөө




Зураг 4.18. Монгол улс. Үндэсний музей

1257 онд Мөнх хаан Сүн улсад дайтаж байх зуур тавнан Барс түгэ, гүнж Исүгий нар хөшөө босгуулжээ. Уг хөшөөг Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Дэлгэр хан уулын өврөөс 1953 онд олсон байна. Одоо Монголын Үндэсний Музейд хадгалагдаж байгаа. Хөшөөнд “Ургийн ургаар хэдэн хэдэн үест Мөнх хаан түмэн түмэн насалтугай хэмээж Барс түгээ босгуул... хүртэл ана (энэ)-д давирганд (учралт) буян хүртүгэй” хэмээн монгол бичгээр бичжээ.



1. Мөнх хааны гадагш явуулсан дайны шалтгаан юу вэ?
2. Хубилай ямар улсыг дайлж эзэлсэн бэ?
3. Хүлэгү ямар улсыг дайлж эзэлсэн бэ?
4. Мөнх хаан ямар улсыг биеэр цэрэг удирдаж дайтсан бэ?

Он тооллын шугамд байгаа зарим он ба үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



### ДҮГНЭЭРЭЙ

4.7

### ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Гүюг, Мөнх хааны бодлого үйл ажиллагаа				Монголын түүхэнд Гүюг, Мөнх хаан ямар байр суурь эзлэх вэ?
		Төр, цэрэг, засаг захиргаа, хууль	Аж ахуй, эдийн засаг, хүн ардын амьдрал	Хот, шашин суртал	Байлдан дагуулалт	
Гүюг, Мөнх хаан хэдээс хэдэн онд, хичнээн жил хаан суусан бэ?	Газар зүйн зурагт нэр гарсан улс орон, газар нутгийг олж заагаарай.	Хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг тус бүрд нь оновчтой тодорхойлоорой.				Дүгнэн ярилцаарай.

### 3. МОНГОЛЫН ИХ ЮАНЬ УЛС

Монголын агуу гүрэн Мөнх хааны дараагаас дөрвөн улс болон задрах үйл явц эхлэв. Тэдгээр улсууд бүгд эхэн үедээ Их Юань улсад ёс төдий боловч захирагдаж байв.



**ХУБИЛАЙ ХААН**

(1215-1294)



Яагаад Их Юань улсыг эзэнт улс гэдэг вэ? Монгол хаадын бодлого, үйл ажиллагаа ямар үр дүнд хүрсэн бэ?

1260-1264 онуудад Их Монгол улс Хубилай, Аригбөх гэсэн хоёр хааны засаглал зэрэгцэн оршиж байв. Тэд хоорондоо хоёронтоо байлдахад Хубилай ялж хаан болов. Их Юань улсыг Толуйн хөвүүн Хубилай 1271 онд байгуулжээ. Тэр 1271 он хүртэл Их Монгол улсын хаан байв.

Хубилай хаан өмнөд Сүн улсыг 1279 онд эзэлж дууссанаар бүх Хятад монголчуудын мэдэлд оржээ. Тийнхүү олон мянган жил салангид байсан Хятадыг нэгтгэж өгөв. Их Юань улсын их нийслэл нь Дайду, дээд нийслэл нь Шанду юм. Их Юань улсын захиргаанд Монгол, Төвөд, Солонгос, Хятадын нутаг багтаж байв.

Их Юань улсыг хаан удирдана. Төрийн хэргийг Төвлөн засах яам мэдэж явуулдаг байв. Түүний дор шүүх, цэрэг, сан, түшмэл, ёслол, үйлдвэр хариуцсан яамд ажиллана. Улсын гол хуулийг “Их Юань улсын нэвтэрхий дүрэм” гэж нэрлэжээ.

Юань улсын хүн амыг дөрвөн зэрэглэлд хуваав. Монгол хүнийг тэргүүнд тавьж, дараагаар өнгөт нүдтэн хэмээгдэх уйгур, араб, перс хүмүүсийг оруулжээ. Гуравт умард Хятад дахь зурчид, хятан нар, хамгийн доор өмнөд хятадын нанхиад нарыг эрэмбэлжээ. Удирдах тушаалд монгол хүнийг, түүний дор өнгөт нүдтэн хүнийг ажиллуулж байлаа.

Хубилай бурхны шашныг төрийн шашин болгосон боловч Монгол хаад лал, загалмай, бумба, бөө зэрэг бүх шашин шүтлэгт тэгш хандаж байв. Ийнхүү соёл, шашны ялгаа бүхий угсаатнууд энх тайвнаар зэрэгцэн орших болов. Хубилай хаан 1260 онд Төвөдийн Пагва ламыг улсын багшаар өргөмжилж, төр ба шашны харилцааг тэгш явуулах хоёр ёсыг тогтоожээ. Пагва ламаар дөрвөлжин бичиг зохиолгож, улс даяар хэрэглэх болов.



1. Юань гэдэг үг ямар утгатай вэ?
2. Хүн амыг яагаад 4 зэрэглэл болгосон бэ?
3. Монгол хаад шашны талаар ямар бодлого явуулж байв?
4. Хоёр ёс гэж юуг хэлж байна вэ?


#### ТАЙЛБАР

Их Монгол улсын нэрийг Юань хэмээн өөрчлөх “Жуух бичиг”-т “тэнгэр, тэргүүн их утгыг үндэслэсэн болой” гэж тайлбарлажээ.

### Сурвалжийн мэдээ

“Муж арван нэгийг байгуулсан...Юань улс бол зам, тойрог, хошуу, сум дөрөв зэрэг буй. Их төлөв зам хошууг захирна. Хошуу сумыг захирна.” (Юань улсын судар. 58-р дэвтэр)

Их Юань улсын засаг захиргааны бүтэц.




1. Их Юань улсын засаг захиргааны нэгжүүдийг нэрлэнэ үү.
2. Бүдүүвчид Их Юань улсын засаг захиргааны бүтцийг бөглөж бичнэ үү.

### ТАЙЛБАР

Язгуур Монгол орноо Линбэй буюу Давааны арын муж гэх болжээ.

Зураг 4.19. Монголын Их Юань улс



1. Их Юань улсын газар нутгийн 4 захыг нэрлэнэ үү.
2. Их Юань улсын нийслэл Дайду одоогийн ямар хот вэ?
3. Давааны арын муж гэж ямар газар нутгийг хэлж байна вэ?
4. Их Юань улсын бүрэлдэхүүнд байсан улсуудыг заана уу. Өнөөгийн ямар улс вэ?

### Аригбөх, Хубилай хоёр байлдсан нь



Зураг 4.20. ("Судрын чуулган"-ы чимэг зураг)

### Сурвалжийн мэдээ

"Номын засаг үгүй бөгөөс амьтан уньюу. Хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдэрьею." (Арван буянт номын цагаан түүх УБ., 2002. т. 68)



1. Номын засаг гэж юу болох тухай саналаа хуваалцаарай.
2. Хоёр ёсны үзлээр бол хааны засаг ямар үүрэгтэй вэ?
3. Аригбөх, Хубилай нар хэний хөвүүд вэ?
4. Ах дүү хоёр хоорондоо яагаад байлдаж? Аригбөх, Хубилай нар байлдсан нь ямар уршигтай байсан бэ?
5. Зургаас монгол цэрэг эрсийн зэвсэг, хэрэглэл, хүлэг морийг ажиглаж ярилцана уу.

Их Юань улсын эдийн засагт тариалан, мал, худалдаа, гар урлал голлох үүрэгтэй байв. Тариаланг дэмжсэнээр ургацын хэмжээ нэмэгдэж, эдийн засаг, хүн амын амьжиргаа дээшилжээ. Малчдыг татвараас чөлөөлөх, хөнгөлөх, худаг гаргах, хашаа барих, хадлан бэлтгэх зэргээр мал сүргийг өсгөхөд анхаарч байлаа.

Их Юань улсад усан ба хуурай замын тээвэр сайн хөгжжээ. Улсын хэмжээнд 1500 орчим өртөө байжээ. Мөн Ил хаант, Цагадайн улс, Алтан орд улстай өртөөгөөр холбогдсон байв. Гадаад, дотоод худалдаа эрчимтэй хөгжиж Ази, Европ, Африкийн олон оронтой худалдааны өргөн харилцаатай байжээ. Соёл, боловсрол, шинжлэх ухаан хөгжиж, олон хүрээлэн байсны нэг нь Судар бичгийн хүрээлэн юм.

Хятадын тариачдын бослогын улмаас 1368 онд тэнд байсан монголчуудын олонх нутагтаа эргэн иржээ. Их Юань улсын төрийг 10 хаан барьсан бөгөөд сүүлчийн хаан Тогоонтөмөр 1370 онд нас барав.



1. Их Юань улсын эдийн засгийн үндсэн салбарууд юу байв? Тэдгээр салбарыг хэрхэн хөгжүүлэв?
2. Их Юань улсад боловсрол, шинжлэх ухаан хөгжиж байсны илрэл юу вэ?
3. Их Юань улс мөхсөн 1370 он Чингисийн хэдэн он болох вэ?

## ДӨРВӨЛЖИН БИЧИГ



Мон

гол



1. Дөрвөлжин бичгийг хэн зохиосон бэ? Яагаад дөрвөлжин бичиг гэж нэрлэсэн бэ?
2. Дөрвөлжин бичгийг зохиох болсон учрыг хэлэлцээрэй.

### Сурвалжийн мэдээ

“...Их хааны мөнгө, зоос хийх газар байдаг. ... бүх цаасан мөнгөн дээрээ их хааны тамгыг дардаг байжээ”. (Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987. т. 119)



1. Мөнгө, зоос хоёрын ялгаа юу вэ?
2. Мөнгө, зоос хийх эрх мэдэл хэнд байдаг вэ?



Зураг 4.21.

Хубилай хаан 1260 онд цутгуулсан зоос. “Их төрийн гүйлгээний эрдэнэ” гэсэн хятад бичигтэй.



1. Уг зоосыг хятад бичигтэй гаргасан учрыг тайлбарлаарай. Яагаад голдоо дөрвөлжин нүхтэй байна вэ?

Торгоны зам бол Дорно, Өрнө хоёрыг хуурай газраар холбосон худалдааны зам юм. Азийн торго Европт энэ замаар очиж байсан тул ингэж нэрлэжээ. Хятадаас торго, гар урлалын бүтээгдэхүүн шаазан, дарь очиж байв. Мөн Баруун Азиас хивс, арьс ширэн эдлэл ирнэ. Италийн дархчуудын алтан эдлэл, Венецийн шилэн эдлэл, шүр сувд Азид ирдэг байв. Их Юань улсын үед торгоны зам монголчуудын бүрэн мэдэлд оржээ. Энэ замаар монголчуудын хамгаалалт доор худалдаачид ямар ч айх аюулгүй явдаг болов.

Зураг 4.22. Торгоны зам



1. Торгоны зам ямар ямар тивийг холбож байна вэ?
2. Торгоны зам дэлхийн эдийн засагт ямар ач тустай байсан бэ?
3. Торгоны замын аюулгүй байдлыг хангах нь Их Юань улсад ямар ашиг тустай вэ?



## Он тооллын шугамд байгаа зарим үйл явдалд тохирох оныг гүйцээж бичнэ үү.



### ДҮГНЭЭРЭЙ

4.8

### ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид хаагуур аялсан бэ?	Их Юань улс				Их Юань улс дэлхийн түүхэнд ямар байр суурь эзлэх вэ?
		Төр, засаг захиргаа	Хүн ам, нийгэм	Аж ахуй	Соёл, шашин	
Их Юань улс байгуулагдсан, унасан оныг зуунаар илэрхийлж, тус улсын оршин тогтносон хугацааг тооцоолоорой.	Их Юань улсын бүрэлдэхүүнд байсан улс орнуудыг нэрлээрэй.	Тодорхойлоорой.		Дүгнэн ярилцаарай.		Хэлэлцээрэй.

### Солонгос улс

XIII зуунд Солонгос монголчуудын довтолгоонд өртөж хараат түшмэг улс нь болов.



Монголын агуу гүрний үед Солонгосыг хэн захирч, ард олон нь хэрхэн аж төрж байсан бэ?

Солонгос нь Их Монгол улс, Юань улсын түшмэг улс байсан тул алба барьж, цэрэг гаргах үүрэгтэй байв. XIV зууны дунд үеэс Корё улсад монголчуудын нөлөө сулрав. Конмин 1351 онд хаан ширээнд сууж, монголчуудын тогтоосон зарим дүрэм, алба, хэргэм цолыг халжээ. 1356 онд Юань улсыг дэмжигчдийг засгийн эрхнээс зайлуулав. 1392 онд язгууртан Ли Сонг өөрийгөө хаанд өргөмжилж, улсаа Чусон хэмээн нэрийдэв. Нийслэл нь Сөүл хот болжээ. Түүний угсааныхан 500 жил Солонгосыг захирчээ. Тэжон хааны үе 1401 онд Чусон улсыг Мин улс хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ Чусон хятад тооллыг хэрэглэж, жил бүр Мин улсын хаанд элчээ илгээх болов. Элч улс орныхоо чухал хэргийг айлтгаж, бэлэг барьж байлаа.

Солонгосын үндсэн аж ахуй нь цагаан будаа, хүнсний ногоо, хүн орхойдойн тариалан байв. Солонгосчууд анх хятад ханз бичгийг хэрэглэж байв. 1443 онд Сежун хаан “хангыл” бичгийг зохиолгон дэлгэрүүлжээ. Гэхдээ хятадын ханз бичгийг төрийн хэрэгт давхар хэрэглэсээр ирэв. Солонгосчуудын дунд Күнзийн суртал дэлгэрч, бурхны шашны сүм хийдийн байр суурь суларчээ.


# 한글

Хан гил

“Хангиль” гэдэг нь эртний солонгос хэлээр “агуу бичиг”, орчин үеийн солонгос хэлээр “Хангийн бичиг” гэсэн утгатай.

## ТАЙЛБАР

“Чусон” гэдэг нь “Наран мандахын орон” гэсэн утгатай.



1. Монгол гүрний үед Солонгост ямар улс оршиж байсан бэ?
2. Монгол гүрний өмнө Корё улс ямар үүрэг хүлээж байв?
3. XIV зууны дундаас Солонгост Монголын нөлөө суларсны шалтгаан юу вэ?
4. Солонгосын үндэсний бичиг юу вэ? Хэзээ зохиогдсон бэ?
5. Солонгост ямар, ямар шашин дэлгэрч байсан бэ?


## Япон улс

Камакурын угсааны шёогун нар төр барьж байх үед Япон улс Монголын улс төр, цэргийн бодлогод өртжээ. Тэр үед Япон улсыг Камакурын угсааны шёогун нарын өмнөөс Хоожё Токимунэ захирагч цолтойгоор удирдаж байв. Хубилай хаан 1266-1272 онд Японд элч илгээж харилцаа тогтоохыг хүсэхэд хүлээж авсангүй.

Иймд 1274, 1281 онд Японд довтолсон ч далайн хар шуурганы улмаас амжилтгүй болов. Юань улс 1281 оны дайнд 140 мянган цэрэг, 4400 онгоц бүхий усан флотыг илгээсэн байдаг. Японы түүхэнд “Юань улсын цэрэг гайхалтай эрчтэй нум сумтай. Хорт сум, дарь зэрэг японы цэрэгт байхгүй шинэ зэвсэг хэрэглэж, цан, хэнгэргийн дохиогоор бөөнөөр давшин байлдаж байв” гэжээ. Хэдий Их Юань улс Японтой дайтсан ч худалдаа, шашны зохих харилцаатай байлаа.

1333 онд Шёогуны засаглалыг хааны угсааны Годайго унагаж, төрийн эрхийг эргүүлэн авчээ. Гэвч тэр улсын дотоод зөрчлийг шийдвэрлэж чадаагүй юм. Улмаар Годайго-гийн улс төрийн эрхийг 1336 онд Асигака-гийн удмынхан булаан авчээ. Үүгээр Японд Шёогуны буюу цэргийн засаглал дахин сэргээжээ. Энэ үед Киото, Нара, Камакура зэрэг том хотууд байв.

XII-XIV зууны хооронд Японы хүн ам 10 саяас өсөж, 17 сая хүрчээ. Япончууд цагаан будааны зэрэгцээ тамхи, чихэр өвс, олс, хөвөн тариалах болжээ. Мөн торго болон шаазан, шавар эдлэлийн үйлдвэрлэл хөгжив. XIII-XIV зуунд Японд бурхан шашны Зэн урсгал ихэд дэлгэрчээ. Япончууд өөрсдийн гэсэн өвөрмөц зан заншил, уламжлалтай ард түмэн юм. Цайны ёслол, но (авьяас чадвар гэсэн үг) театр, цэцгийн урлаг энэ үед үүсжээ.





1. Японд засгийн эрхийн төлөө ямар угсааныхан тэмцэлдэж байсан бэ?
2. Тэдгээр хүчний аль нь ялж, төрийн эрхийг хэзээ хүртэл барив?
3. Хубилай хаан Япон улстай холбоо тогтоох гэсний учир юу вэ? Таамаглал дэвшүүлж ярилцана уу.
4. Монголчууд яагаад Японыг эзэлж авч чадаагүй вэ?
5. XIV-XV зууны Японы улс төрийн байдлыг тодорхойлно уу.

ДҮГНЭЭРЭЙ

4.9

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид хаагуур аялсан бэ?	Хэн захирч байв?		Ямар өөрчлөлт гарав?	
		Япон	Хүн ам, нийгэм	Аж ахуй	Соёл, шашин
Японд Миномото угсааныхан төрийн эрхэнд гарсан, тус улс задран хуваагдсан цаг хугацааг тодорхойлно уу.	Японы арал, Солонгосын хойгийг газар зүйн зурагт заана уу.	Нэрлээрэй.		Дүгнэн ярилцаарай	

## 4. МОНГОЛЫН АЛТАН ОРД УЛС

Мөнх хааны дараа Монголын агуу гүрэн Их Юань, Цагадайн, Алтан орд (Зүчи улс), Ил хаант улс гэсэн дөрвөн улсад хуваагдаж эхлэв. Тэдний нэг нь Алтан орд улс юм.



Алтан орд улсын газар нутаг, засаг захиргаа, аж ахуй, шашин ямар байсан бэ?

Чингис хааны ахмад хүү Зүчийн (Зочи) хувь эзэмшил Алтан орд улсын үндэс болсон юм. 1242 онд Зүчийн эзэмшил улсыг хөвүүн Бат байгуулсан нь Их Монгол улсын баруун гар болж байв. 1264 онд Бэрхийн үеэс бие даасан төр улс болжээ. Тус улс Кипчакийн тал, Орос ба зүүн Европын өмнөд нутаг, Крымын хойгоор оршиж байв. Газар нутаг нь Эрчис мөрнөөс Дунай мөрний доод урсгал хүрнэ. Эзэнт улсын нийслэл нь Ижил мөрний доод урсгалын Сарай Бат, Сарай Бэрх хот юм.

Алтан орд улсын засаг захиргаа эхэн үедээ баруун, зүүн, төв гэсэн хэсэгт хуваагдаж байв. Хожим Ордын түмэн, Оросын түмэн болгож, 10 тойрогт хуваан захирчээ. Бат хаан Оросын вангуудад харьяат хот улсаа захирах эрхийг олгож, алба татвар авах, хянах үүрэгтэй даргач (баскак) нарыг суулгав.

Монголчууд Алтан орд улсад цөөнх болох боловч ноёлогч байр суурьтай байлаа. Алтан орд улсад захирагдсан хүн амын ихэнх нь тариачид юм. Тариалан улсын орлого бүрдүүлэх, цэргийн хүнсний хэрэглээг хангахад чухал үүрэгтэй тул төрөөс дэмжжээ. Батаас эхэлж эзэлсэн газар орныхоо худалдааны хуучин замуудыг сэргээж, өртөө байгуулсан байна. Үүгээр төрийн үйл хэрэг, худалдаа арилжаа түргэн шуурхай, аюулгүй явагдах нөхцөл бүрдсэн юм. Алтан орд улс Ази, Европыг тэгнэн оршиж байсан тул худалдаа арилжаа, соёлын солилцоо өргөн дэлгэр явагдаж байв.

Алтан орд улсын хаад бөөгийн шашныг шүтэж байгаад Өзбег (1312-1342) хааны үеэс Лалын шашинд орсон юм. Гэхдээ Монгол төрийн аливаа шашин шүтлэгийг ялгаварлахгүй, тэгш ханддаг зарчим мөн хэрэгжиж байлаа.

Алтан орд улсаас Казань, Крым, Сибирь улс, Ногай, Казахын орд тасран байгуулагдав. Алтан орд улсад 33 хаан төр барьжээ. Монголын хаад төр, засаглалын дэвшилт хэлбэр, алба татварын тогтолцоо, хүн амын тооллого, өртөө зэрэг олон дэвшилт зүйлийг Орос, зүүн Европт үлдээжээ. Алтан орд улс 1502 онд мөхсөн байна.




1. Алтан орд улс байгуулагдсан 1264 он Чингисийн тооллын хэдэн он болох вэ?
2. Алтан орд улсын нийслэл одоогийн ямар улсын нутагт байсан бэ?
3. Алтан орд улсын хаад эзэлсэн орнуудаа хэрхэн захирч байв?

### ТАЙЛБАР

Улсын хааны орд өргөөг алтаар чимэглэсэн тул Алтан орд гэсэн нэр үүсжээ.

Зураг 4.23. Монголын Алтан орд улс



1. Алтан орд улсын нутаг дэвсгэр, хил хязгаарыг заана уу.
2. Алтан орд улсын нийслэл хотуудыг заана уу.

### Алтан орд улсын зоос

#### Сурвалжийн мэдээ

“Бат аль нэг мөргөл буюу шашныг тухайлж үл шүтдэг, ганцхан тэнгэрт л итгэдэг...аливаа шашныг сохроор үл дагана” (А.Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. УБ., 2006)



Зураг 4.24.


Зоосны нүүрэн талд “Аугаа их Султан Тогтох” нөгөө талд бурхны авралд Сарай хотод 710 онд цутгав” гэжээ. Тогтох хааны нэрийг монгол бичгээр, бусад үгийг арабаар бичжээ.



1. Бат ямар шашинтан байсан бэ?
2. Алтан орд улсын хаад зоос цутгаж, гүйлгээнд оруулсны зорилго юу вэ?
3. Хижрийн тооллын 710 онд уг зоосыг цутгасан ажээ. Хижрийн тооллыг ямар шашинт улсууд хэрэглэдэг вэ?

### Абдулла хааны гэрэгэ

Алтан орд улсын хаан Абдулла (1367-1368)-ийн мөнгөн гэрэгэ Ижил мөрний сав газраас олджээ. Хэмжээ 28х9 см, жин 359.03 грамм. Монгол бичгээр нэг талд "Мөнх тэнгэрийн хүчин дор Их суу залийн ивээл дор", нөгөө талд нь "Абдулла"-гийн зарлиг хэн үл бишрэх хүн алдах үхэх" гэжээ.



Зураг 4.25.

ОХУ. Санкт-Петербург  
Эрмитаж музей



1. Гэрэгэг юунд хэрэглэдэг вэ?
2. Гэрэгэний дээд хэсэгт гаргасан нүх ямар зориулалттай вэ? Бичээсийн утгыг тайлбарлан ярилцана уу.

XIII-XIV зууны үеийн Монголын уран зохиол, түүхийн ховор дурсгал бол Алтан ордны үйсэн дээрх бичиг юм. Уг бичиг 1930 онд Ижил мөрний хөвөөнд нэгэн булшнаас олджээ. Нийт 25 хуудас бөгөөд ихэнх хэсгийг монгол, уйгур бичгээр, цөөн хэдэн мөрийг дөрвөлжин үсгээр бичжээ.



Зураг 4.26.

#### ХҮҮГИЙН ҮГ

Эх элбүр, эх минь ээ  
Өлөнгийн өвс гундахад хүрэв  
Өнөр садан буцахад хүрэв  
Өргө нутагтаа буцсу


#### ЭХИЙН ҮГ

Өвчүүний чинь үсхэн  
Үүдмэл алт болоосой хэмээлээ  
Эмгэг зовлонд бүү таараг  
Эгүүн дээд чагаа сүр минь



1. Монголчууд цаасны оронд юу хэрэглэж байсан бэ?
2. Алтан орд улсад ямар бичиг хэрэглэгдэж байв?
3. Шүлэгт юуны тухай өгүүлж байна вэ?

Он тооллын шугамд байгаа зарим үйл явдалд тохирох оныг гүйцээж бичнэ үү.



Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Алтан орд улс			Алтан орд улс удаан оршиж чадсаны учир юу вэ?
		Төр, засаг захиргааны тогтолцоо	Аж ахуй	Соёл, шашин	
Алтан орд улс байгуулагдсан, задарсан оныг зуунаар илэрхийлж, оршин тогтносон хугацааг тооцоолоорой.	Алтан орд улсын газар нутаг хил хязгаар, эрхшээлд байсан улсуудыг газарзүйн зурагт заагаарай.	Дүрслэн тайлбарлаарай.			Дүгнэн ярилцаарай.

### Оросын хот улсууд (XIII-XV зуун)

“Тэнд (Орос) хаа сайгүй татарууд (монгол)-ын тогтоосон энхийн журам буюу пакс татарика ноёрхож байдаг”. (Франческо Балдуччи Пеголит гэгчийн 1340 онд бичсэн номын хэсэг)



Монголын тогтоосон энх журам Орос оронд ямар үр дагавар авчирсан бэ?



Киевийн Орос улс XII зууны эхээр 15 хот улс, XIII зууны эхээр 50 хот улс болон задарчээ. Тэдгээрээс Владимир-Суздаль, Галицк-Волын, Новгород, Полоцк, Рязан, Смоленск, Черниговын хант улс томоохонд тооцогдож байв. Тархай бутархай Орос орон Герман, Швед улсын түрэмгийлэлд өртөж өртөж байв. Мөн Ромын пап лам Оросын ард түмнийг католик шашинд оруулах шахалт үзүүлж байлаа. Үүнийг Оросын зарим ван эсэргүүцжээ. 1234 онд Владимир Суздалийн ван Ярослав Германы цэргийг, 1240 онд түүний хүү Александр Шведийн цэргийг тус тус ялсан байна.

Католик шашинтнуудад шахагдсан Оросын хант улсуудыг Бат хаан байлдан дагуулав. Оросын олон хот Алтан орд улсын бүрэлдэхүүнд орсонгүй алба барьдаг хараат байдалтай байжээ. Алтан орд улсын хаад Оросын вангуудад харьяа нутгаа захирах эрхийн бичиг олгодог байв. Мөн Оросын хотуудад татвар хяналт тавих “Баскак” хэмээхийг байгуулжээ. Оросоос цэрэг дайчлан мянганаар зохион байгуулж, даргаар нь монгол хүн тавина. Уг цэрэг “Баскак”-ын мэдэлд байв.

Бат хаанд дагаж орсон Невийн Александр монгол цэрэгтэй хамтарч 1242 онд Чуд нуурын тулалдаанд герман цэргийг бут цохив. Энэ ялалт немцийн загалмайтнуудын дорно зүгт газар нутгаа тэлэх гэсэн олон жилийн дайныг зогсоожээ.

Оросын нэгдмэл улс байгуулагдахад Москва хот, түүний вангууд гол үүрэг гүйцэтгэжээ. Бат хааны Москваг дэмжих бодлогын үрээр тус хот олон хүн амтай, аж ахуй, худалдааны том төв болж чадсан юм. Улмаар Оросын хот улсууд XIII зууны сүүлээс Москвагийн хант улсад нэгдэж эхлэв.

Москвагийн хант улс гол эсэргүүцэгч Тверийн хант улсыг 1325 онд Алтан орд улстай хамтран цохижээ. Монголыг эсэргүүцсэн Тверийг дарахад тусалсан



Москвагийн ван Иван Калитад Алтан ордны хаанаас хан цол өгч, Оросын бүх нутгаас татвар авахыг зөвшөөрчээ. Мөн тэр Оросын үнэн алдартны шашны тэргүүнийг Владимирийн хант улсаас Москвад шилжүүлж чадсанаар нэр хүнд, нөлөө нь нэмэгдсэн байна.

1352 онд Москвагийн хан болсон Дмитрий Иванович Литва, түүний холбоотон Тверь, Смоленск, Рязаны хант улсуудыг ялжээ. Үүний дараа тэр 1380 онд Донын эрэгт Алтан орд улсын хаан Мамайн цэргийг бут цохижээ. Үүгээр Москвагийн хант улс Алтан орд улсын хараат байдлаас ангижирсан байна. Үүний дараа Алтан орд улсын Тогтомыш, Ахмед зэрэг хаад Москвагийн хант улсыг дахин эрхшээхийг оролдсон ч төдий л амжилт олоогүй байна.

Москвагийн дараагийн хан III Иван Ростов, Ярослав, Новгородын хант улсуудыг нэгтгэж авав. Түүний үед Москвагийн Кремлийг байгуулжээ. Ийн XV зуунд Оросын нэгдсэн улс байгуулагдсан юм.

Алтан орд улсын үед Орост олон эерэг өөрчлөлт гарчээ. Үүний нэг нь Оросын аж ахуй, гар урлал, худалдааны хөгжилт юм. Энэ үед тариалангийн талбай нэмэгдэхийн сацуу тариаг хоёр, гурван талбайн аргаар тариалах болов. Мөн төмөр анжис, усан тээрэм шинээр бий болжээ. Малын тоо өсөж, хүнсний ногооны ургац нэмэгдэж, зөгийн аж ахуй бий болов.

Хотуудад гар урлал хөгжиж, төмрийн дархан, арьс шир боловсруулах, ваар сав хийх гар урлалын газрууд үүсэв. Аж ахуйн өсөлтөөр Оросын хотуудын худалдаа арилжаа нэмэгдэв. Оросын худалдаачид Монгол хаадын чөлөөт худалдааны бодлогын үрээр Иран, Бухар, Хорезм, Армен зэрэг Дорнын оронтой худалдаа хийж байлаа. Алтан орд улсын хаадын аж ахуй, худалдааг сэргээх бодлогын үрээр Орос орон эдийн засгийн талаар бэхжив. Эдийн засгийн хөгжилт Орост нэгдмэл улс байгуулагдах гол үндэс болсон юм.

Оросын нийгмийн харилцаанд ч өөрчлөлт гарав. Ван тойрон хүрээлэгч язгууртнууд, ордны түшмэдэд газар шагнан олгожээ. Тэдгээр шинэ газрын эздийг помещик гэнэ. Тариачид ямар нэг газрын эзэнд харьяалагдаж, түүнд зүтгэх болов. Тэднийг хамжлага гэнэ.

#### ТАЙЛБАР

Нева мөрний тулалдаанд Шведийн цэргүүдийг ялсан Александрыг Невийн хэмээн алдаршуулжээ.

#### Тодруулга

Куликовын тал Дон мөрний савд багтдаг. Куликовын талд Дмитрий ван Монголын цэргийг ялснаар Доны хэмээгдэх болжээ.

#### Тодруулга

Кремль гэдэг нь хот, хэрэм гэсэн утгатай үг юм.

Кремль Москва хотын төвд байх ба Оросын Холбооны улсын Ерөнхийлөгчийн өргөө байрлана.



1. Монголын байлдан дагууллын өмнөх Орос орны байдлыг тодорхойлно уу.
2. Алтан орд улсын хаад Оросын хот улсуудын талаар ямар бодлого явуулав?
3. Алтан орд улс, Оросын вангуудын хооронд ямар харилцаа тогтов?
4. Оросын нэгдмэл улс хэзээ байгуулагдав? Үүний ач холбогдол юу вэ?



Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Монголын		Үр дагавар
		байлдан дагууллын өмнөх Орос	захиргаан дахь Орос	
Киевийн Орос улс задарсан, Оросын нэгдмэл улс байгуулагдсан зууныг тодорхойлж, хэдэн зуун жилийн түүх судалснаа тооцоолоорой.	Оросын хот улсуудыг нэрлээрэй.	Дүрслэн тайлбарлаарай.		Дүгнэн ярилцаарай.

## 5. МОНГОЛЫН ЦАГАДАЙН УЛС

Мөнх хааны дараах үеэс Монголын агуу гүрэн дөрвөн улсад хуваагдах үйл явц эхэлжээ. Тэр дөрвөн улсын нэг нь Цагадайн улс байв.



Монголын Цагадайн улсын газар нутаг, засаг захиргаа, нийгэм, аж ахуй, шашин ямар байв?

Чингис хаан хоёрдугаар хүү Цагадайд Или Тарвагатайн нуруунаас баруун тийш одоогийн Төв Азийн нутгийг өгчээ. Түүний өмч нутгаар 1224 онд Цагадайн эзэмшил улс байгуулагдсан нь Их Монгол улсын баруун гарт багтаж байв. 1264 онд Алгуй хааны үеэс Цагадайн улс бие даасан байна. Цагадайн улсад одоогийн Казахстан болон Хятадын Шинжааны ихэнх нутаг, Узбек, Тажик, Киргиз улсын нутаг багтаж байв. Нийслэл нь Алмалиг, Аксу, Кашгар хотууд байв. Цагадайн улсад монголчууд ноёрхох байр суурьтай байв. Барулас, Жалайр, Хэрэйд зэрэг монгол аймгийнхан голлон сууж байв. Нутгийн хүн амын олонх нь лалын шашин шүтдэг, түрэг хэлтнүүд байжээ. Дува хаан (1282-1307)-ы үед Цагадайн улс нэлээд хүчирхэг болжээ.

Цагадайн улсын Кебек хаан (1319-1326) улсдаа шинэчлэлт хийжээ. Улс даяар нэг ханшаар хэрэглэх зоосон мөнгө гүйлгээнд оруулав. Мөн засаг захиргааг шинэчлэн, хэд хэдэн түмэнд хуваан зохион байгуулж, төлөөний сайдуудаар захируулжээ. Кебек хаан бөөгийн шашинтан байсан ч лалын шашны сүм хийд, соёлыг дэмжин тэтгэж байв.


Цагадайн улсын хүн амын нүүдэлчин хэсэг нь мал аж ахуй, суурин иргэд нь тариалан, худалдаа, гар урлал эрхэлдэг байв. Цагадайн улсын нутаг Торгоны замын чухал зангилаа болж байсан тул худалдаа, хотын хөгжилд чухал нөлөө үзүүлжээ.




1. Цагадайн улс хэний өмч эзэмшлээр үүссэн бэ?
2. Кебек хаан улсдаа ямар шинэчлэлт хийсэн бэ? Үр дүнг тодорхойлно уу.
3. Кебек хаан шашны талаар ямар бодлого явуулж байв?
4. Цагадайн улсын аж ахуй ямар салбаруудтай байсан бэ?

### ТАЙЛБАР

1. Могулистан гэдэг үг Могул буюу монгол, стан буюу улс гэсэн утгатай. Могулистан гэж Цагадайн улсын зүүн талын Или мөрөн, Долоон ус голын сав нутгийг хэлнэ.
2. Мавераннахр баруун талын нь Амударья, Сырдарья мөрний хоорондох нутгийн нэр юм.



Зураг 4.27. Монголын Цагадайн улс



1. Цагадайн улсын нийгмийн дээд хэсэгт хэн багтах вэ? Цагадайн улсын нийгмийн доод хэсэгт хэн багтах вэ? Цагадайн улсын газар нутгийг заана уу.
2. Цагадайн улсын нийслэл хотуудыг заана уу.

Дотоод зөрчил хямрал ихэдсний улмаас 1330-аад оны дундаас хойш Могулистан, Мавереннахр гэж хуваагдав. Могулистанд малчид нүүдэлчид голдуу, Мавереннахрт тариаланчид, гар урчууд илүүтэй амьдарна. Сүүл үедээ Цагадайн улсын монголчуудын дунд ялгарал гарсан байна. Хот сууринд суугчдыг эрлийзүүд, талын нүүдэлчдийг бүдүүлгүүд хэмээн зөрчилдөх болов. Түклүктөмөр 1348 онд Могулистаны хаан болж, улмаар Мавереннахрыг нэгтгэн 1363 он хүртэл хаан суужээ. Цагадайн улсын төрийг 26 хаан барьсны сүүлийн хаан нь Түглүктөмөр юм. Цагадайн улсын баруун нутгаар 1370 онд Төмөр ноён өөрийн улсыг байгуулж Самаркандыг нийслэлээ болгожээ. Энэ улсыг Төмөрийн улс гэдэг.



1. Цагадайн улс хэзээ, хэд хуваагдсан бэ?
2. Монголчуудын дунд ялгарал гарсны учир шалтгааныг ярилцаарай.
3. Чингисийн тооллын хэдэн онд Цагадайн улс мөхсөн бэ?

### Кебек хааны зоос



Зураг 4.28.

1320 онд Бухар хотод цутгасан. Зоосны нүүрэн талд арабаар “Кебек хаан”, ар талд “Цагадай хааны тамга” сийлжээ.

### Тодруулга

Кебек хааны цутгуулсан зоосыг кебекүүд гэдэг байв. Хожим уг үг орос хэлэнд орж сунжран копейка (задгай мөнгө, зоос) гэх болжээ.

Он тооллын шугамд байгаа зарим онд болсон үйл явдлыг гүйцээж бичнэ үү.



ДҮГНЭЭРЭЙ

4.12

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Цагадайн улс			Цагадайн улс Монголын эзэнт гүрний түүхэнд ямар байр суурь эзлэх вэ?
		Гол түүхэн зүтгэлтнүүд, үйл явдал	Аж ахуй	Соёл, шашин	
Цагадайн улс байгуулагдсан, мөхсөн оныг зуунаар илэрхийлж, хэдэн жил оршин тогтносныг тооцоолоорой.	Төв Азийн том гол мөрөн, нуур, уул нуруу, хотыг нэрлээрэй.	Дүрслэн тайлбарлаарай.			Дүгнэн ярилцаарай.

## 6. МОНГОЛЫН ИЛ ХААНТ УЛС

Мөнх хааны дараах үеэс Монголын агуу гүрэн Их Юань, Цагадай, Алтан орд, Ил хаант гэсэн дөрвөн улсад хуваагдаж эхэлжээ. Тэдний нэг нь баруун Азид байсан Ил хаант улс юм.



Ил хаант улсын газар нутаг, засаг захиргаа, аж ахуй, шашин ямар байв?



**ХҮЛЭГҮ ХААН**  
(1217-1265)

Мөнх хааны даалгаснаар дүү Хүлэгү баруун Азийн улсуудыг эзлэхээр морджээ. Тэр Кавказын Азербайжан, Армен, Гүрж болон Ираныг дагаар оруулав. 1256 онд Хүлэгү хаан Ил хаант улсыг байгуулжээ. Тэрбээр улсаа зүүн, баруун, төв гурван гар болгон захирч байжээ. Ил хаант улсын нийслэл нь Марага, Тебриз, Султания хотууд юм. Хүлэгү хаан Исмалайтыг довтлон 1258 онд Багдадын халифт улсыг мөхөөв. 1260 онд Дамаск хотыг эзэлсэн ч дараа нь Египетийн цэрэгт алджээ. Монголчууд эзэлсэн орны хүн амыг алж хядаж байсангүй. Сүм хийд, түүх соёлын дурсгалыг хэзээ ч устгаж байгаагүй юм.

Ил хаант улс Газан хаан (1295-1304)-ы үед ихэд хүчирхэгжжээ. Хааны засаглал хүчтэй болсноор орон нутгийн эрх баригчдын дураар авирлах явдал эцэс болжээ. Тэрбээр мянганы зохион байгуулалтыг нэвтрүүлэхийг оролдов. Татварын тогтолцоог шинэчилж, тарианы талбайг услах далан суваг байгуулав.

Ил хаант улсын гол дайсан нь Египет буюу Мамлюкын улс байлаа. Ил хаад Европын загалмайн шашинт Франц, Англи улс болон Ромын Пап ламыг Мамлюкийн эсрэг дайнд татан оруулахыг оролдож байв.

Ил хаант улсын төрийг нийтдээ 9 хаан барьжээ. Сүүлийн хаан Абу сайд 1335 онд нас баржээ.



1. Ил хаант улс байгуулагдсан 1256 он Чингисийн тооллын хэдэн он болох вэ?
2. Хүлэгү ямар улс орнуудыг эзэлсэн бэ?
3. Газан хаан ямар шинэчлэлт хийсэн бэ? Үр дүнг тодорхойлоорой.
4. Ил хаант улсын гадаад бодлогыг тайлбарлаарай.

### ТАЙЛБАР

Ил гэдэг нь харьяат гэсэн утгатай монгол үг юм.



Зураг 4.29. Монголын Ил хаант улс



1. Ил хаант улсын нутаг дэвсгэр, нийслэл хотуудыг заана уу.

### Өлзийт хаанаас Францын ван Филиппт илгээсэн захидал

“Манай сайн өвөг, сайн эцэг, сайн ахтай (та нар) найрамдалтай явсан журмаа үл эвдэх буй за... Эдүгээ бидэнд ба та нарт үл зохилдон эвлэх (этгээдийг) тэнгэрийн хүчээр цөм хамтран эсэргүүцэж байхыг тэнгэр мэдтүгэй.”



Зураг 4.30.




1. Уг захидлыг ямар бичгээр бичсэн байна вэ?
2. Захидлыг хэрхэн баталгаажуулсан байна вэ?
3. Захидлын энэ хэсгийн агуулгыг ярилцаарай.

Газан хааны бунхан



Зураг 4.31.. ("Судрын чуулган"-ы чимэг зураг)

Хүлэгү хаан Багдад хотыг довтолсон нь



Зураг 4.32. ("Судрын чуулган"-ы чимэг зураг)



1. Уг бунхан ямар шашны барилга вэ? Бунханг хэнд зориулж барьдаг вэ?
2. Монгол цэрэг ямар зэвсэгтэй байна вэ?
3. Хүлэгү хаан Багдад хотыг хэдэн онд эзэлсэн бэ? Багдад одоо аль улсын нийслэл вэ?

Ил хаант улсын монголчууд нүүдэлчин амьдралаа хадгалж байв. Тэд Армяны нутагт зусаад өвөл нь өөр муж руу нүүдэг байжээ. Тус улсын хүн амын олонх нь тариачид байв. Газан хааны шинэчлэлтээр тариачид эзэмшил газартай болжээ. Хуулиар тариачдын эрх ашгийг хамгаалах болов.

Ил хаад татварын хэмжээг бууруулах, хөрөнгө ба орлогод нийцүүлэх, чөлөөлөх бодлого явуулжээ. Хүлэгү хаан дархан мэргэд, хөгшид, өвчтэй, ядуучууд, хүүхдийг татвараас чөлөөлжээ.

Ил хаад мөнгө-зоосны гүйлгээг худалдаа, татварт бүрэн нэвтрүүлж, жин хэмжүүрийг жигдэлжээ. Ил хаант улсын нутаг Торгоны замын нэг хэсэг нутаг болж байсан тул худалдаа, гар урлал ихэд хөгжжээ.



1. Газан хаант тариачдыг дэмжсэний учир юу вэ?
2. Ил хаадын татвар, санхүүгийн бодлогыг тодорхойлно уу.
3. Ил хаант улсад худалдаа хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйл юу вэ?

## Газан хааны зоос



Зураг 4.33.

1301 онд Тбилист цутгасан уг зоосны нүүрэн талд монгол бичгээр “Тэнгэрийн хүчин дор Газаны дэлдэгүүлсэн”, арабаар голд нь “Газан махмуд”, доод хэсэгт дөрвөлжин бичгээр “Газан Махмуд” хятадаар товчлон бичсэн. Нөгөө талд Коран судрын үг “Калима” ба “Тбилист цутгав” гэж арабаар бичжээ.



1. Зоосон дээр монгол, араб, хятадаар бичсэний учир юу вэ? Саналаа солилцоорой.

Ил хаад бүх шашин шүтлэгийг хүлээн зөвшөөрч байсан тул лал, загалмай, бөө, бурхны шашин зэрэгцэн оршиж байлаа. Харин Газан хаан лалын шашныг төрийн шашин болгов.

Ил хаант улсад түүх, анагаах ухаан, одон орон судлал хөгжжээ. Хүлэгү хаан Марага хотод одон орны төв байгуулав. Монголчуудын түүхийн талаар Рашид-Ад-дин “Судрын чуулган”, А.Жувеини “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” зохиол бичжээ.

Бурхны шашны урлагийн нөлөөгөөр лалын шашинтны зураг урлалд хүний дүрсийг анх удаа зуржээ. Уран барилга сэргэн хөгжив. Тэр үеийн хаадын харш, цайз бунхан нь уран барилгын онцгой байгууламжууд юм.

### Сурвалжийн мэдээ

“Хүлэгү...одон орон судлалын газрыг барьж дуусгах гэж мэрийсэн. Тэр эрдэмд маш дуртай байсан бөгөөд онол ухааны талаар эрдэмтэд маргалдахыг урамшуулж тэдэнд тухайлсан хэмжээний мөнгө хэрэглэл өгч эрдэмтэн, мэргэдийг байлган ордныхоо чимэг болгоно”. (Рашид-Ад-Дин. Судрын чуулган. УБ., 2002)



1. Хүлэгү хаан ямар судалгааны газар бариулсан бэ?
2. Хүлэгү хаан ордондоо эрдэмтдийг цуглуулахын зорилго юу вэ?

### “Судрын чуулган”-ы өмнөх үг



Зураг 4.34. (“Судрын чуулган”-ы чимэг зураг)


Ил хаант улсын төрийн албан түүх “Судрын чуулган” (Жами-ат-таварих)-ыг төрийн сайд Рашид-ад-дин 1301-1311 онд бичиж дуусгажээ.

“Судрын чуулган”-ы I ботид Монгол аймгуудын угсаа гарал түүхээс Чингис хааныг хүртэл бичжээ. II ботид Өгэдэйгээс Өлзийттөмөр хаан хүртэлх, III ботид Хүлэгүгээс Газан хүртэлх их хаадын түүхийг бичсэн байдаг.



1. Судрын чуулганыг ямар бичгээр бичсэн байна вэ? "Судрын чуулган" ямар ач холбогдолтой вэ?
2. Судрын чуулганыг хэдэн ботиор бичсэн бэ? Боть тус бүрд юуны тухай өгүүлдэг вэ?

Он тооллын шугамд байгаа зарим үйл явдал болсон оныг гүйцээж бичнэ үү.



ДҮГНЭЭРЭЙ

4.13

ҮНЭЛЭЭРЭЙ

Хэддүгээр зуунаар аялж, хэдэн жилийн түүхийг судалсан бэ?	Бид дэлхийн аль бүс нутагт очсон бэ?	Ил хаант улс			Ил хаант улс дэлхийн түүхэнд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
		Төр, засаг захиргааны тогтолцоо	Аж ахуй	Шашин, соёл, шинжлэх ухаан	
Ил хаант улс байгуулагдсан, унасан оныг зуунаар илэрхийлж, оршин тогтносон хугацааг тооцоолоорой.	Ил хаант улсын нутгийн хил хязгаар, эрхшээлд байсан улсуудыг газар зүйн зурагт заагаарай.	Дүрслэн тайлбарлаарай.			Дүгнэн ярилцаарай.



## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- Тэмүжиний төрсөн газар Дэлүүн Болдог ямар аймаг, сумын нутагт байгааг газар зүйн зурагт заана уу.
- Тэмүжин аргын 1162 онд төржээ. Энэ нь Чингисийн хэдэн он бэ?
- Тэмүжин хэзээ Монгол улсын хаан болсон бэ?
  - 1130
  - 1201
  - 1165
  - 1189
- Чингис хаан Их Монгол улсыг хэзээ байгуулсан бэ?
  - 1211 он
  - 1206 он
  - 1204 он
  - 1207 он
- Чингис хааны довтолсон улсуудын нэр, оныг тохируулна уу.
  - Алтан улс
  - Хар Хятан
  - Сартуул улс
  - Тангуд улс
  - 1218 он
  - 1211 он
  - 1227 он
  - 1225 он


а. 1б, 2а, 3г, 4в б. 1а, 2б, 3в, 4г в. 1г, 2в, 3б, 4г г. 1в, 2г, 3а, 4б
- Дутуу өгөгдлийг нөхөж бичнэ үү.
  - Боорчу
  - .....
  - Наяа
  - .....
  - .....
  - Зүүн гар
  - .....
  - Ойн иргэд
- Их Монгол улсын засаг захиргааны нэгж аль нь вэ?
  - Арван, зуун, мянган, аймаг, түмэн
  - Арван, сум, хошуу, мянган
  - Баг, сум, хошуу, аймаг
  - Баг, зуун, мянган, түмэн
  - Арван, зуун, мянган, түмт, түмэн
- Чингис хааны хөвүүдийг насаар зөв эрэмбэлсэн нь аль вэ?
  - Зүчи, Өгэдэй, Цагадай, Толуй
  - Цагадай, Зүчи, Өгэдэй, Толуй
  - Зүчи, Цагадай, Өгэдэй, Толуй
  - Өгэдэй, Зүчи, Толуй, Цагадай
- Гурван их хааны өргөмжлөгдсөн оныг Чингисийн тоололд шилжүүлнэ үү.
  - Өгэдэй хаан. 1229. = Чингисийн .....он
  - Гүюг хаан. 1246. = Чингисийн .....он
  - Мөнх хаан. 1251. = Чингисийн .....он
- Их Монгол улсын хаадын төр барьсан он цагийг тохируулна уу.
  - Чингис хаан
  - Өгэдэй хаан
  - Гүюг хаан
  - Мөнх хаан
  - 1229-1241 он
  - 1246-1248 он
  - 1251-1259 он
  - 1206-1227 он

а. 1а, 2б, 3в, 4г б. 1г, 2в, 3б, 4а в. 1г, 2а, 3б, 4в г. 1в, 2б, 3а, 4г
- Монголын эзэнт улсуудын оршин тогтносон хугацааг нөхөж бичнэ үү.
  - Монголын Их Юань улс
  - Монголын Алтан орд улс
  - Монголын Цагадайн улс
  - Монголын Ил хаант улс
  - .....
  - .....
  - .....
  - .....
- Хос онуудын хооронд адилтгал (=), эсрэг тэсрэг байдал (↔), эсвэл үр дагавар (→) гэсэн нөхцөлт тэмдэгтүүдийг байрлуулж, тайлбарлана уу.

а.1162.....1127 б.1189.....1206 в.1218.....1219-1225

## V БҮЛЭГ. ЧИНГИСИЙН ЭРИН ҮЕИЙН ДЭЛХИЙ ДАХИН (XII-XV ЗУУН)

### 1. ФЕОДАЛУУД БА ТАРИАЧИД



1. Бүдүүвчийг гүйцээнэ үү. Дундад зууны нийгмийн ямар давхаргуудыг дүрсэлсэн байна вэ?
2. Ямар давхарга эрх мэдлийг гартаа атгаж байв?
3. Дундад зууны нийгэмд яагаад тэгш бус байдал ноёрхож байсан талаар таамаглал дэвшүүлээрэй.

Феодалууд дундад зууны нийгэмд ноёрхогч байр суурьтай байжээ.

Дундад зууны үед “Эзэнгүй (сеньор) газар үгүй” гэдэг дүрэм үйлчилж байлаа. Талбай, ой, нуга, мөн гол, нуур хүртэл тэдний өмч болов. Феодалын эдлэн газар бий болж, түүний төвд эзний шилтгээн байрлаж байв. Энд феодалын орон гэр, үр тариа, хүнсний агуулах, морины зүчээ, эдлэнгийн даамал, зарц нарын байр байв.

Шилтгээн бол феодалын орон байр, хоргодох бэхлэлт болж байв. Шилтгээнийг модоор барьж байсан бол VIII зуунаас норманн, унгаруудын довтолгооны улмаас чулуугаар барих болжээ. Шовх оройд цамхаг бүхий хүчирхэг хана шилтгээнийг найдвартай хамгаална. Шилтгээнийг дов толгод эсвэл өндөр хаданд барьж, шуудуугаар хүрээлж байв. Заримдаа гол, нууранд орших арал дээр барина. Шуудуу, голын усан дээгүүр гүүр дамнуулан барьж, шөнө, эсвэл дайсан довтолох үед гүүрийг гинжээр өргөн хураадаг байв. Цамхагийн оройд байнгын харуул гаргаж, дайсан ойртон ирвэл бүрээ үлээн түгшүүр зарлана. Тэр үед цэргүүд хана, цамхагт байрлалаа яаравчлан эзэлнэ. Шилтгээнд нэвтрэхийн тулд олон саадыг давах хэрэгтэй. Шуудууг шороогоор дүүргэж, шилтгээнд хүрэх эсвэл хана эвдэгч модон дүүгүүрээр шилтгээний хаалгыг эвдэх хэрэгтэй болно.



Зураг 5.1. Рыцаруудын халз тулаан. Номын чимэглэл зураг. Манессийн хууль. 1300 он

Цэрэг, дайны хэрэг бараг феодал бүрийн ажил байв. Тэд бүх л амьдралынхаа туршид дайн, тулаанд орно. Феодалууд цэрэг дайны хэрэгт багаасаа бэлтгэгдэж байжээ. Сэлэм, жадаар тулалдах, морь унах, барилдах, усанд сэлэх, жад шидэх зэргээр байнгын сургуулилт хийнэ. Газрын эзэд аж ахуйгаа өөрөө эрхэлдэггүй, үүний тулд

эдлэн бүрт аж ахуйн даамал бий. Тэд ихэнх цагаа дайн, сургууллт, ан ав, найр наадам хийж өнгөрөөнө. Рыцариудын ан ав, халз тулааны тэмцээн тэдний цэргийн хэрэгтэй нь холбоотой байв.

Ван, сурвалжит феодалууд рыцариудын халз тулааныг зохион байгуулна. Сурвалжит ноёд, хатагтай нар, шүүгчид индэр дээр сууж, ард олон тулааны талбайг тойрон тэмцээнийг сонирхоно. Тусгай зарлагч халз тулалдах рыцариудын нэр, хороог зарлана. Тулаанд оролцогчид талбайн хоёр талд өөд өөдөөсөө харан зогсож, шүүгчдийн дохиогоор морио гуядан бие биесийг угтуулан давхиж, халз тулалдана. Тулаанд ялагч өрсөлдөгчийнхөө морь, бамбайг шагнал болгон хүртэнэ. Халз тулаан найраар өндөрлөнө. Мөн дайн тулаанд ялах, хаан өргөмжлөх, язгууртны хуримын үеэр рыцариудын халз тулааныг зохион байгуулдаг байжээ.

Үдэш нь шилтгээний суугчид том танхимд цугларч, задгай зуухны дэргэд шоо хаян, шатар тоглож, дарс, шар айраг ууж, ажил хэргээ шийднэ. Баяр ёслол, гийчид ирэх үеэр найр хийж, зоогийн ширээг дүүргэнэ. Задгай галд ангийн мах шарж, уригдсан жүжигчин, алиалагч, мөн яруу найрагчид зочдыг зугаацуулдаг байжээ.

Феодалын эдлэн газар эзний ба тариачдын ноогдол газраас бүрдэнэ. Хараат тариачид ноогдол газраа үе залгамжлан эзэмшиж, эзэндээ алба гувчуур барина. Феодалууд өөрийн эзэмшилд амьдрах хараат тариачдыг шүүх эрхтэй. Алба гувчуураа цаг хугацаа хожимдуулсан зэргээр тариачдыг эзний шүүхэд дуудаж, торгууль, шийтгэл онооно. Хувийн хараат тариачдын байдал газрын хувьд хараат тариачдаас илүү хүнд байв. Тэд эзний зөвшөөрөлгүйгээр тосгоноо орхиж, ноогдол газраа худалдах, шилжүүлэх эрхгүй байжээ. Ийм тариачин охиноо өөр эзний тариачинтай гэрлүүлэхэд эзэндээ алба гувчуур төлнө.

Тариачдын амьдардаг тосгодод голчлон 10-15 хашаа байжээ. Хашаа бүрт тариачдын орон байраас гадна малын саравч, хашаа, хороо, үрийн агуулах зэрэг аж ахуйн байгууламж байв. Хашааны дэргэд цэцэрлэг, ногооны талбай, усан үзмийн тариалан байжээ. Тариачид байшингаа ихэвчлэн гуалингаар барьж, шавардаж, дэрс, зэгсээр дээвэрлэнэ. Тулгандаа гал түлж, таазанд гаргасан нүх, хаалгаар утаа нь гадагшилна. Тариачид утаа гадагшлуулдаг яндантай зуух барьж суртлаа их хугацаа зарцуулсан юм. Тийм учраас хана, таазанд утааны тортог тогтоно. Жижиг цонх нь шилгүй, шөнө модон хаалтаар таглаж, хүйтэн үед үхрийн цөсний хүүдийг хатааж хийсэн нимгэн арьсаар халхалдаг байжээ.

Тариачид арвайн тутан, шош мөн манжин, сонгино зэрэг хүнсний ногоо өдөр тутам хүнсэндээ хэрэглэж, мах, загас, бяслаг ховорхон зооглоно. Төмс, эрдэнэ шиш, улаан лооль Европт дэлгэрээгүй байжээ. Элсэн чихэр мэддэггүй, зөгийн балаар орлуулдаг байна. Зөгийн бал, усан үзэм, жимсээр ундаа, дарс бэлтгэж арвайгаар шар айраг исгэнэ. Эзэд илүү тансаг хоол зооглоно. Мах, загасыг перец, гоньдоор амтлан зооглоно. Цөцгийн тос, дарс, шар айргийг тогтмол хэрэглэдэг байжээ.

Тариачид ургацынхаа 1/3-ийг бүтээгдэхүүний алба болгон эзэндээ өгч, 1/10-ийг сүмд өгнө.


Тариачид хөдөө аж ахуй, гар урлалын бүтээгдэхүүнээр өөрсдийгөө болон эзэд, түүний гэр бүлийг хангана. Ийм учраас бүх хэрэгцээт зүйлээ эдлэнд үйлдвэрлэж байжээ. Ийм аж ахуйг эдлэхүүний аж ахуй гэнэ.

XI зууны үеэс хөдөө аж ахуй, гар урлал, худалдаа хөгжиж, хотууд үүсэв. Эзний эдлэн газар таваар-мөнгөний харилцаанд татагдан орж, биеэр гүйцэтгэх алба, бүтээгдэхүүний албыг мөнгөн татвараар сольжээ.

Ган гачиг болж, ургац алдах, феодалуудын дайн, дээрэм тонуул, алба гувчуур нэмэгдэх зэргээр тариачдын аж ахуйг хоосруулж байв. Ийм тохиолдолд тариачид эзэндээ ажиллахаас татгалзах зэргээр эсэргүүцдэг байжээ. Дундад зууны түүхэнд Английн Уот Тайлер, Францын жакууд (борчууд) зэрэг тариачдын том бослого дэгдэж байжээ.



1. Дараах алхмын дагуу төлөвлөгөө зохиож, уншсан мэдээллийн агуулгыг танилцуулна уу.
  - а. Бичвэр мэдээллийг анхааралтай уншаарай.
  - б. Дэд сэдвүүдэд утгачилан хуваагаарай.
  - в. Дэд сэдэв бүрийн гол санааг тодорхойлж, товч илэрхийлээрэй.
2. Эдлэн, шилтгээн, рыцарь зэрэг шинэ ойлголтыг тайлбарлаарай.




Зураг 5.2. Феодалын шилтгээн

1. Донжон (гол цамхаг).
2. Бэхлэлт хана.
3. Хамгаалалтын цамхаг.
4. Дотор хашаа
5. Хаалга, дээд талынх нь цамхаг
6. Гүүр.
7. Шуудуу.
8. Далан.

#### ТАЙЛБАР

Рыцарь –морь унасан хүн гэсэн утгатай латин үг юм. Үүнийг морьт цэрэг гэж ойлгож хэрэглэсээр иржээ.



Зураг 5.3. XI, XV зууны рыцариуд




Даалгаврыг гүйцэтгэж, мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Феодалууд шилтгээнээ хаана барьж байсан бэ? Яагаад?
3. Өөрийгөө энэ шилтгээний эзэн гэж төсөөлөөрэй. Хэрэв хэн нэгэн шилтгээн рүү дайрвал хэрхэн хамгаалах вэ? Хамгаалагчдаа хаана байрлуулах вэ? Яагаад?
4. Зургийг ажиглаж, рыцариуд ямар өмсгөл, зэр зэвсэгтэй байсныг тайлбарлана уу. XI, XV зууны рыцариудын өмсгөл, зэвсэглэлд ямар ялгаа бий болсон байна вэ?.

### Сурвалжийн мэдээ

“Юуны өмнө тэд (тариачид) намрын өдөр шөнө тэнцэх өдөр 6 мер шар айраг, 3 мер улаан буудай алба гувчуур төлнө. 3 акр ( акр-0.405 га) газар хагалан үр суулгаж, 3 мер арвай алба болгон барьж, ургацаа нуруулдан 4 тэрэг түлээ бэлтгэн хөрөөдөж, 16 ярд (1ярд-91.44см) хашаа сэлбэн засаж, Пасхийн өдөр (Улаан өндөгний баяр) 2 хургатай хонь өгнө”



Даалгаврыг гүйцэтгэж, мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Бүдүүвчийг гүйцээн тариачдын эрхийн байдал, алба гувчуурын төрлийг ялган тайлбарлана уу.
2. Феодалууд тариачдыг хэрхэн захирдаг вэ?
3. Ямар албыг биеэр гүйцэтгэх, ямар албыг бүтээгдэхүүний алба гэх вэ?
4. Зурагт эздийн эсрэг тариачдын тэмцлийн ямар хэлбэрүүдийг дүрсэлсэн бэ?.

Зураг 5.4. Тариачдын эсэргүүцэл, тэмцэл



Эзнийхээ талаар хаанд гомдол мэдүүлэх



Загалмайтны аян дайнд оролцох



Өөр эзэнд зугтан очих



Эрх чөлөөгөө худалдан авах

### ДҮГНЭЭРЭЙ

5.1

### ҮНЭЛЭЭРЭЙ

Давхарга	Бүрэлдэхүүн	Өмч ба хийх ажил	Эрх
Феодалууд			
Тариачид			

## 2. ДУНДАД ЗУУНЫ ЕВРОПЫН ХОТУУД

### Баримт 1.

#### VIII-IX зуун

- Европ даяар хэдэн арван хот байгуулагдав.
- Хот бүр 10 мянгаас цөөнгүй хүн амтай байв.

#### XI-XV зуун

- Европ даяар хэдэн мянган хот байгуулагдав.
- Парис, Флоренц, Генуя, Праг, Вена, Гамбург, Брюгге, Севилья, Лондон зэрэг 50-200 мянган хүн амтай "аварга хотууд" үүсэв.

### Баримт 2.

Дундад зууны хотын гудамж нарийн давчуу, байшингууд нь хана, дээврээрээ нийлсэн байх тул нэг байшинд гал гарахад нөгөөд нь түргэн авалцан шатна. Бэхлэлт хананы доторх орон байр, агуулах богино хугацаанд үнс болон хувирна. Хүрэл хонх ч хайлахаар тийм халуун гал дүрэлзэнэ. Ийм үйл явдал зуун жилийн дотор нэг хотод хэд хэдэн удаа тохиолдсон байдаг. Мөн цэцэг өвчин, халуун хумх, тахал багагүй аюул учруулна. XVI зууны дунд үед "хар тахал" Бремен хотод 7000, Любект 9000, Базельд 14000, Эрфуртад 16000 хүний амийг авч оджээ. Амьд үлдсэн цөөн хүмүүс хүүрээр дүүрсэн хотоос гарч түгжиж орхисон тохиолдол ч байв.



1. Дээрх хоёр мэдээллийг харьцуулна уу.
2. Хотын амьдрал ийм атал хүмүүс яагаад хот руу тэмүүлж байсан бол?



X зууны үеэс Европт гар үйлдвэр хөгжих нөхцөл бүрджээ. Тариачид шинэ газар (ой, намаг) эзэмшин тариалж, хөдөө аж ахуйн хөдөлмөрийн багаж боловсронгуй болж, ургацын хэмжээ эрс нэмэгдэв. Тэд өөрсдийгөө болон эздээ тэжээгээд зогсохгүй илүүдэл бүтээгдэхүүн хуримтлуулах болов. Гэвч тариачид газар тариалан, гар үйлдвэрийг хослуулан эрхлэх боломжгүй байв. Нөгөө талаар гар үйлдвэрийн бүтээгдэхүүний эрэлт өссөн байна. Иймд тариачдаас гар үйлдвэрийн мэдлэг, чадвартай нь уг ажлыг дагнан эрхлэх болжээ. Гар урчууд бүтээгдэхүүнээ борлуулахын тулд олон хөлийн газар суурьшив. Ийнхүү гар урлал хөдөө аж ахуйгаас тусгаарлаж, гар урчуудын суурин аажмаар хот болон өргөжжээ. Хотод худалдаачид, феодал болон тариачид бараа бүтээгдэхүүнээ авчирч худалдана. Хотынхон суурингийнхаа гадуур суваг шуудуу татаж, далан, чулуун хэрэм босгон рыцарь болон дээрэмчдийн халдлагаас хамгаалдаг байлаа. Ингэж X-XI зуунд Төв ба Баруун Европт хотууд үүсжээ.

Тэр үеийн хотууд 2-3 давхар байшинтай, нарийн давчуу гудамжтай, зах зээлийн том талбайтай бөгөөд түүний ойролцоо сүм, хотын зөвлөл байрлана. Хотын усан хангамж тааруу, бохир, давчуу байснаас элдэв өвчин, гал түймэр гарч олон хүн үрэгддэг байв.

Европын хотууд газрын эзний эзэмшилд үүссэн тул эзэд хотыг захиргаандаа байлгаж, алба авч байв. Харин XII-XIII зуунд хотынхон эрх чөлөөгөө худалдан авч, коммун (өөрийн удирдлагатай хот) байгуулан гэрээгээ зөрчсөн эзний эсрэг тэмцэж, бие даасан байдлаа олжээ. Хотууд удирдах зөвлөлөө байгуулж, цэрэг, шүүх, санхүүтэй болсон байна.



Дараах асуултад хариулж уншсан мэдээллийн агуулгыг танилцуулаарай.

1. Европын хотууд хэзээ, хаана, хэрхэн үүссэн бэ?
2. Европт хот үүсэхэд юу нөлөөлсөн бэ?
3. Коммуныг хэн, ямар зорилгоор байгуулсан бэ?



Зургийг ажиглан хотын нутаг дэвсгэр ямар байгууламжаас бүрдэж байгааг тайлбарлана уу (хамгаалалтын байгууламж, төв гудамж, хотын барилга байгууламж, тэдгээрийн зориулалт)

Зураг 5.5. Дундад зууны хот

### Хотын хүн амын бүрэлдэхүүн

Хотын баячууд: худалдаачин, хотын газар, том байр эзэмшигчид	Хотын удирдлагыг гартаа барьж байсан.
Дундаж давхарга: цехийн мастер, жижиг худалдаачин, лангуу эзэмшигчид	Гар урлалын газар, лангуу эзэмшиж, хотын өөрийн удирдлагад оролцож байжээ.
Хотын борчууд: хар ажилчин, туслах мастерууд, ядуучууд	Хотын өөрийн удирдлагад оролцох эрхгүй.

### Сурвалжийн мэдээ

1. Хэрэв ямар нэгэн хүн хотод ирж амьдран, нэг жил нэг хоног болсон бол ... бусад иргэдийн адил эрх чөлөөтэй. болно.
2. Дундад зууны Европчууд “хотын агаар хүнийг эрх чөлөөтэй болгодог” хэмээн хэлэлцдэг байв.

**Гар урлалын цех.** Гар урчуудаас нарийн мэргэшсэн мастерууд буй болжээ. Мастеруудын гар үйлдвэрт туслах мастерууд, сурагчид ажилладаг байв. Улмаар мастерууд мэргэжил мэргэжлээрээ нэгдэн цех байгуулсан байна. Ийнхүү хотод гуталчин, нэхмэлчин, чулуучин зэрэг цехүүд ажиллах болов. Цехийг ахлах мастер тэргүүлж, туслах мастер ба сурагчдыг захирна. Цех бүр дүрэмтэй. Дүрмээр тухайн цех нэг загварын өндөр чанартай бүтээгдэхүүн гаргахыг тогтож, хотод нь гадны урчууд ирж ижил бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдахыг хоригложээ. Хотын худалдаачид мөн нэгдэн өөрсдийн холбоо байгуулсныг гильд гэнэ.



Дараах асуултад хариулж уншсан мэдээллийн агуулгыг танилцуулаарай.

1. Хотын хүн ам ямар давхаргаас бүрдэж байна вэ?
2. Сурвалжийн мэдээнд дундад зууны хотын тухай юу өгүүлсэн бэ?
3. Цехийн дүрмийн ач холбогдлыг тайлбарлаарай.

Тэр үед Газар дундын тэнгисийн эрэг, ялангуяа Италид олон хот үүссэн юм. Энэ нь гадаад худалдаа хөгжсөнтэй холбоотой. Тэдгээр хотын худалдаачид Араб, Ираны худалдаачдаар дамжуулан Дорнын орны барааг авч байв. Гэхдээ Италийн Венеци, Генуя хотын худалдаачид л эл худалдааны замыг эзэмшиж байжээ.

Мөн Европт жил бүр яармаг худалдаа нээгдэж, өргөн арилжаа хийдэг байв. Яармаг худалдааны үеэр олон орны зоос гүйлгээнд орох ба түүнийг сольж ашиг олдог хүмүүс гарч иржээ. Улмаар тэд мөнгө хүүлэн ашиг олдог болов. Хожим тэд барьцаалан зээлдүүлэх газар, банкны эзэд болсон юм.

### Сурвалжийн мэдээ

1. Ландрик Толсты (феодал) би Ланграгийн нэгэн худалдаачныг манай нутгаар өнгөрөхөд нь ... эд барааг нь булаан авав ... миний эзэмшлээр чөлөөтэй өнгөрч байхын тулд ... алба төлж байхаар тохиролцов.
2. Худалдаачдыг чөлөөтэй худалдаа хийлгэж байхын тулд хот бүхэн өөрийн хүчээр далайн дээрэмчдээс ... хамгаалж байна.
3. Хэрэв манай хот, хотын орчимд ирсэн ямар нэгэн худалдаачин манай гильдэд эс орвол түүнийг хөөх буюу эд хөрөнгийг нь хураан авна.



Дараах асуултын дагуу ярилцаж, мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Худалдаачдад хэн дайсагнаж байсан бэ?
2. Худалдаачдыг хэн хамгаалж байв?
3. Гильд гэж юу вэ? Ямар үүрэгтэй вэ?
4. Европын гадаад худалдааны төвүүдийг нэрлэж, газар зүйн зурагт заагаарай.

### ТАЙЛБАР

Бург-хэрэм, касл-шилтгээн, бридж-гүүр, форт-бэхлэлт гэсэн утгатай.

### ДҮГНЭЭРЭЙ

### 5.2 ҮНЭЛЭЭРЭЙ

Ньюкасл, Кембриж, Страсбург, Оксфорд. хотууд хаана үүссэн бэ?	Дундад зуунд үүссэн Европын ямар хотуудыг мэдэх вэ?	Хотууд хэрхэн үүссэн бэ?	Хотууд дундад зууны нийгэмд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
Үгийн тайлбарыг ашиглаж тогтоогоорой.	Газар зүйн зурагт заагаарай.	Тайлбарлаарай.	Дүгнэн ярилцаарай.



### 3. ЗАГАЛМАЙТНЫ СҮМИЙН ХҮЧИРХЭГЖИЛТ БА АЯН ДАЙНУУД

XI-XIII зуунд Ромын Пап лам Баруун Европын хаадаас хүчирхэгжиж, сүм хийдийг нь бүрэн хянав. Дундад зууны төгсгөл гэхэд Ромын пап ламын толгойн өмсгөлд 3 титэм дүрслэх болжээ. Эхнийх нь католик ертөнцийн дээд санваартны эрх мэдэл, хоёр дахь нь төрийн эрх мэдэл, гурав дахь нь дээд шүүгч хууль тогтоогчийн эрх мэдлийг билэгджээ.



Яагаад ийм явдал болов? Сүм хийд яаж хүчирхэгжсэн бол?

Дундад зуунд давхарга бүрийн эрх үүргийг хатуу зааглан нийгмийн байр суурийг нь үе залгамжлуулна. Сүм хийдийнхэн нэгдүгээр давхаргад хамаарч байв. Тэд хүмүүсийг бурхадтай холбогч гэх ажээ.

Библид заасан зан суртахууны дүрмийг дагаж мөрдөхийг сүсэгтнүүдээс шаардана. Хулгай хийж, хүн алж болохгүй, эцэг эхээ дээдлэх, ойр дотны хүнээ хайрлахыг сургаж байв. Ийм дүрмийг сүсэгтэн олон даган мөрдөж байсны ачаар зан авир нь зөөлөрч, илүү хүнлэг болжээ.

Хүн нүглээс ангижрахын тулд сүмд очиж, санваартанд үйлдсэн нүглээ нэгд нэгэнгүй өчин бурхнаас өршөөл хүсэж, сэтгэлээ аварна гэж найддаг байв.

Сүм хийд буян үйлдэж, сэтгэлээ авран, диваажинд очихыг уриалж байв. Ван, сурвалжтан, худалдаачин, чинээлэг биш хүмүүс ч ядууст туслахыг хичээн, бага сага мөнгө тараан, тэтгэж байжээ. Загалмайтны зан суртахуунд баялагт шүтэхийг шүүмжилдэг. Сүм хийд орлогынхоо тодорхой хувийг орон гэргүй ядуус, өвчтөнд зориулах ёстой. Тэд ган гачгийн үеэр хүмүүст хоол хүнс тараан, өнчин, өндөр настныг асран сувилж, орон гэргүй хүмүүсийг тэтгэж байлаа. Үүний хамт сүм хийдийнхэн том газрын эзэд байж, үлэмж их баялаг эзэмших болжээ. Тэд энэ их баялгаа тэр бүр шударгаар олоогүй юм.

Сүм хийдийн жинхэнэ нүүр царайг илчлэгч хүмүүсийг тэрслүү үзэлтэн гэнэ. Тэднийг католик сүмийн шүүхээр (инквизици) хатуу шүүн, гэгсгээж байсан гэдэг.

Хүснэгт 7.1.

Загалмайтны сүм хийд ба Ромын пап ламын баялгийн эх сурвалж	
1. Сүмийн аравтын татвар	Лам нар, сүм хийдийн зардалд зориулагдсан онцгой татвар, бүх хүн амаас хураана.
2. Шүтээнд мөргөсний төлөөс	Сүсэгтнүүд шүтээнд мөргөн өвчин зовлонгоос ангижирдаг гэж үздэг.
3. Зан үйлийн төлбөр	Хүүхдээ загалмайлуулах, гэрлэх ёслол, өөд болоочийг үдэх зэрэг зан үйлийг лам нар гүйцэтгэнэ.
4. Индульгенц (латин хэлний өршөөл)	Пап ламын ордонд гэм нүглийн жагсаалт гаргаж, төлбөрийг тогтоосон байна.
5. Сүмийн албан тушаалыг өндөр үнээр зарах	Ромын Пап сүмийн албан тушаалыг өндөр үнээр зарж их ашиг олж байв.



Дараах асуултын дагуу ярилцаж, мэдээлэл, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.


1. Библи, индульгенц, инквизици үгсийг тайлбарлаарай.
2. Библид загалмайтны шашинтны зан суртахууны талаар юу өгүүлсэн бэ?
3. Хүн сэтгэлээ аварч, диваажинд очихын тулд юу хийх хэрэгтэй гэж сургаж байсан бэ?
4. Сүм хийд хэрхэн баяжиж байв? Тэдгээр баялгийн ачаар сүм хийд хэрхэн хүчирхэгжив?
5. Тэрслүү үзэлтнүүд гэж хэн бэ? Сүм хийд тэдэнтэй хэрхэн тэмцэж байсан бэ?

### Сурвалжийн мэдээ

Зөвхөн тэр л хамба лам нарыг томилох, огцруулах эрхтэй.

- Гагцхүү пап л хаанд өргөмжилнө.
- Бүх хаад гагцхүү папын хөлийг үнсэх ёстой.
- Тэр эзэн хааныг огцруулж болно. (Пап лам VII Григорийн (1073-1085) зарлигаас)

Бүдүүвч 5.3. Католик сүм хийдийн зохион байгуулалт





Зураг 5.7. Каносс дахь буулт

Германы эзэн хаан IV Генрих сүмийн дээд лам нарыг өөрөө сонгох шийдвэр гаргав. Үүнийг Пап лам VII Григорий эсэргүүцэж, харьяатуудыг нь түүний эсрэг босгожээ. IV Генрих аргагүйн эрхэнд Пап ламын Каносс өргөөнд очиж, өвдөг сөгдөн уучлал гуйв.



Асуулт, даалгаврыг гүйцэтгэж, эх сурвалж, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Бүдүүвчийг ажиглан католик сүм хийд нэгдсэн зохион байгуулалттай хүчирхэг байгууллага байсныг тайлбарлана уу.
2. Пап VII Григорий сүм хийдийн эрх мэдлийг өргөжүүлэх ямар алхам хийсэн бэ?
3. Каноссын буулт Пап лам, эзэн хааны харилцаанд ямар өөрчлөлт гарсныг илэрхийлж байна вэ?

ДҮГНЭЭРЭЙ

5.3

ҮНЭЛЭЭРЭЙ

Дараах үгсийн утгыг тайлбарлаарай	Католик шашинт ямар улс орнуудыг мэдэх вэ?	Сүм хийд хэрхэн хүчирхэгжсэн бэ? Жишээгээр тайлбарлана уу.	Дундад зууны Европт сүм хийд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
Пап, аравтын татвар, индульгенц, инквизици	Газар зүйн зурагт заагаарай	- Баруун Европын хэд хэдэн хаадтай тэмцэлдэн ялсан. - Тархай, бутархай Баруун ба Төв Европын улсуудын цорын ганц нэгдмэл байгууллага байсан - Сүм хийд үлэмж баялаг эзэмшдэг байсан	Дүгнэн ярилцана уу.


### Загалмайтны аян дайн

XI зуунд Дундад Азиас ирсэн түрэг угсааны сельжук аймаг Ойрх Дорнодод довтлов. Сельжукууд 1071 онд Византийн армид цохилт өгч, улмаар Антиохи, Никей, Иерусалим хотыг эзлэн авчээ. Тэд нар Палестин дахь “Христийн шарил” бүхий ариун газрыг эзлэн авч, мөргөлчдийг шахан хавчиж байгаа цуу мэдээ Европт хүрэв. Тэгээд ч сельжукуудад хавчигдсан Византийн эзэн хаан Алексей Комнин 1095 онд Европт хандаж тусламж гуйгаад байв. Дорнын баялагт шунаж байсан загалмайтнуудад энэ нь аятай шалтаг болж, загалмайтны аян дайн эхэллээ. 1095-1270 онд загалмайтнууд ариун газар руу найман удаа том аян дайн хийжээ.

Аян дайнд сүм хийдийнхэн, феодалуудаас гадна ядуус олноороо оролцжээ. Эдгээр хүмүүс хүнд хэцүү амьдралаас зугтан дорно дахинд очиж, амар жимэр аж төрнө гэдэгт итгэж байв. Эхний аян дайнаар загалмайтнууд Ойрх Дорнодын Иерусалим хүртэлх газрыг эзлэн авч, Эдессийн гүнт улс, Антиохын хант улс, Иерусалимын вант улс, Триполийн гүнт улсыг байгуулсан юм.

1100-1300 онд байгуулагдсан сүмийн рыцарийн орден загалмайтнуудын эзэмшлийг хамгаалж байв. Гэвч 1187 онд Египетийн султан Салах ад дин загалмайтнуудын эсрэг ариун дайн зарлаж, Иерусалимыг эзлэн авчээ. Загалмайтнууд олон жил Салах ад динтэй дайтсан гэдэг.

Зураг 5.8. Загалмайтны I-III аян дайн



IV аян дайнаар 1204 оны 4-р сард загалмайтнууд Константинополийг эзлэн авчээ. Загалмайтнууд Византийн эзэнт улсын суурин дээр улсаа байгуулсныг Латины эзэнт улс гэх болов (византчууд загалмайтнуудыг латинчууд гэдэг байв). Константинополиос хөөгдсөн византчууд Никейн эзэнт улс (Бага Азийн баруун хэсэгт), Эпирийн хаант улс (Эпирт), Трапезундын эзэнт улс (Бага Азийн хойд хязгаарт) байгуулснаас хамгийн хүчирхэг нь Никейн эзэнт улс байв.

1261 онд Никейн эзэн хаан VIII Михаил Палеолог Византийн эзэнт улсыг сэргээсэн юм.

Олон хүн загалмайтны аян дайны золиос болжээ. Тэдний дунд хүүхэд, томчууд, жирийн тэнүүлчнээс авахуулаад эзэн хаан хүртэл байжээ. Загалмайтны III аян дайны үеэр Германы эзэн хаан алдарт Фридрих Барбаросс (Улбар сахалт) Бага Азийн Салеф голд живж үхсэн ажээ.

Загалмайтнууд Ойрх Дорно дахь эзэмшлээ алдсаар дорнын орнуудыг эзэгнэх зорилгодоо хүрээгүй юм. XIII зууны сүүлчээр Ойрх Дорнодоос хөөгджээ. Энэ дайнаар Византийн эзэнт улс Балканы хойгийн багахан хэсэг, Бага Азийн зарим муж, Эгейн тэнгисийн цөөн арлыг эзэгнэсэн багахан улс болж, загалмайтнуудыг зөөж баяжсан Италийн Венец, Генуя хотод худалдааны ноёлох байр сууриа алдлаа.

Загалмайтны аян дайн хүн, хүчний үлэмж хохиролтой ч зарим эерэг үр дүн авчирсан билээ. Газар Дундын тэнгисийн худалдаа цэцэглэн хөгжив. Европчууд хоол идэхийн өмнө гараа угаах, халуун усанд орох, толь хэрэглэх зэргээр дорно дахины ахуйн соёлд суралцсан юм. Тэд цагаан будаа, тарвас, гурвалжин будаа, тоор жимс, чихрийн нишингэ зэрэг хөдөө аж ахуйн шинэ ургамал тариалж, салхин тээрэм, гар урлалын шинэ салбаруудтай танилцжээ.

Европын баян чинээлэг хүмүүс тансаг хэрэгцээгээ (хувцас, ном, зэвсэг, үнэт эдлэл, хивс, тансаг хоол хүнс) хангаж, феодалын аж ахуй бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх болсон юм.

Зураг 5.9. Ойрх Дорнодод байгуулагдсан загалмайтны улсууд



#### ТАЙЛБАР

Орден - Өөрийн хатуу дэг бүхий сүмийн байгууллага



Зураг 5.10. Пап II Урбан

### Баримт 1.

1095 оны 11 сарын 18-нд Францын Клермон хотод Пап лам II Урбан олон хүмүүсийн өмнө үг хэлжээ.

“Та нарын оршин суугаа нутаг чинь уул усаар хүрээлэгдэж, хүн ам олширсноос давчуу уйдхан болжээ. Хөрөнгө баялаг ч багадаж талх тариа дөнгөж хүрэлцэх төдий байна. ...Буруу номтнуудыг тэрхүү газар нутгаас хөөн, бурхны ариун шарилыг эргүүлэн авахын тулд ариун аянд гаратгүн. Тэр нутагт “бал бурам, сүүн гол урсаж байдаг. Иерусалим тана, шүр, сувдын орон, баяр цэнгэлийн хоёр дахь диваажин” (Клермоны шашны их хурал дээр пап II Урбаны хэлсэн үг)



Даалгаврыг гүйцэтгэж газар зүйн зураг мэдээллээс, юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Загалмайтны аян дайн ямар үйл явдлаар эхэлсэн бэ?
2. Загалмайтнуудын хэдэн удаагийн аян дайн болсон бэ? Эхний аян дайн ямар үр дүнд хүрсэн бэ? Газар зүйн зурагт заан тайлбарлана уу.
3. Рыцарийн орден ямар зорилгоор байгуулагдсан бэ?
4. Пап лам хэнд хандаж үгээ хэлсэн бэ? Тэр юунд уриалан дуудсан бэ?
5. Дээрх баримтуудаас Загалмайтны аян дайны шалтгааныг тодорхойлон ярилцаарай.
4. Загалмайтны аян дайн хэрхэн өндөрлөсөн бэ? Аян дайны үр дагаврыг дүгнэн бичээрэй.

#### Загалмайтны аян дайны үр дагавар

Эерэг	Сөрөг

ДҮГНЭЭРЭЙ

5.4

ҮНЭЛЭЭРЭЙ

Загалмайтны аян дайн нийт хичнээн жил үргэлжилсэн бэ?	Загалмайтны аян дайн хаана өрнөсөн бэ?	Аян дайны шалтгаан нь юу байсан бэ?	Ямар үр дүнд хүрсэн бэ?
Он тооллын шугамд тэмдэглэн тооцоолоорой.	“Христийн ариун газрыг” газар зүйн зурагт олж заагаарай.	Дүгнэн ярилцсанаа танилцуулаарай.	Тайлбарлаарай.

## 4. БАРУУН ЕВРОП: ТЭМЦЭЛ БА НЭГДЭЛ

XIV-XV зуунд Ромын пап лам нар Баруун Европын орнуудад эрх мэдлээ тулган хүлээлгэж чадахгүй болжээ. Улс орны хүчин чадал том, жижиг байх эсвэл хүн амын тоогоор хэмжигдэхгүй, харин өөрийн орны хүн амын дэмжлэгт тулгуурласан хүчирхэг хаант засгаар тодорхойлогдох боллоо.



Ямар орнууд ийнхүү тэргүүлэх болсон бэ?

**Франц нэгдсэн нь.** XII зууны эхэн үе гэхэд Баруун Европын улсуудад вангийн засгийн эрх мэдэл сул дорой, нутгийн феодалууд эзэмшил нутгаа бүрэн мэдэж, хууль цааз тогтоож, цэрэглэн байлдаж, тархай бутархай байдал ноёлж байв. Ийм улсын нэг нь Франц орон байлаа.

Зүүн хойд Францын эдийн засаг, улс төрийн төрийн төв нь Парис хот байв. Гэвч дотоодын дайн дажин, зам дагуух дээрэм тонуул улс орны амьдралд хор хохирол учруулах болов. Зөвхөн хүчтэй хаант төр улс оронд хэв журам тогтоож чадах байв. Вангийн мэдэлд Парис, Орлеаны багахан эзэмшил байжээ. Том газрын эзэд вангаас хараат бус эзэмшил бүрдээ эзэн сууж байв. Ван хүн амаас татвар хураах, албатуудаа шүүх эрхгүй байснаас гадна Франц даяар дагаж мөрдөх нэгдсэн хууль, зоос, байнгын цэрэг гэж байсангүй. Энэ үеийн Франц орны байдлыг "Миний харьяатын харьяат миний харьяат биш" хэмээх үг илэрхийлж байсан юм.

XII зууны туршид Францын ван ураг барилдах, байлдан эзлэх, тангарагаа зөрчсөн феодалуудаас газрыг нь хураах зэргээр эзэмшил газраа тэлэв. Шампанийн яармаг худалдаанд ирэх худалдаачдаас татвар хурааж, баяжих болов. II Филипп вангийн үед (1180-1223) Англиас Аквитани мужаас бусад газар нутгаа эргүүлэн авчээ.

IX Людвиг (1226-1270) вангийн үед феодалын эзэмшлийг ванд нэгтгэхийн зэрэгцээ шинэтгэл явуулав. Улс орон даяар нэгдсэн зоос нэвтрүүлэв. Вангийн шүүхийн эрх мэдлийг өсгөв. Дотоодын дайныг хязгаарлаж, "Вангийн 40 өдрийг тогтоов".

1302 онд IV Филипп ван (1285-1314) сүм хийдийнхэн, феодалууд, хотынхны төлөөллийг зарлан хуралдуулав. Түүнийг Ерөнхий штат гэнэ. Ерөнхий штатын гол зорилго нь хүн амаас татвар хураах явдал байв. Ван санхүүгийн хүнд байдлаас гарахын тулд сүм хийдийн эзэмшилд татвар ноогдуулсан нь паптай зөрчилдөхөд хүргэв. Энэ тэмцэлд ван ялж, 1309-1378 онд папын өргөөг Францын Авиньон хотод шилжүүлжээ. Энэ үйл явдлыг түүхэнд "Авиньоны олзлогдол" гэнэ.

100 жилийн дайны дараа XI Людвиг вангийн үед Франц орныг бүрэн нэгтгэв. Ван байнгын арми байгуулж, Франц даяар Вангийн татвар, шүүхийг тогтоов.

Хот, худалдаа, аж ахуй, соёл хөгжиж, франц үндэстэн бүрэлдэх эхлэл тавигдав.


### ТАЙЛБАР

"Вангийн 40 өдөр" -Феодалууд дайн зарлаад дөч хоногийн дотор харилцан тохиролцож эс чадвал дайнаа эхэлж байх тухай хууль юм.



- Асуулт, даалгаврыг гүйцэтгэж, уншсан мэдээллийн агуулгыг танилцуулна уу
1. Франц орны нөхцөл байдлыг яагаад “Миний харьяатын харьяат миний харьяат биш” хэмээх үгээр тодорхойлж байна вэ?
  2. Францын вангууд улс орноо нэгтгэх ямар алхмуудыг хийсэн бэ?
  3. “Вангийн 40 өдөр” хуулийг яагаад баталсан бэ?
  4. Ерөнхий штат ямар үүрэгтэй байгууллага вэ? Өнөөгийн төлөөллийн байгууллагаас ямар ялгаатай байсан бэ?
  5. IV Филипп хаан ямар учраас Пап ламтай зөрчилдөх болов? Үүний үр дүн юу байсан бэ?

Зураг 5.11. 100 жилийн дайн



**Зуун жилийн дайн.** 1337-1453 онд Франц Английн хооронд дэгдсэн дайныг зуун жилийн дайн гэнэ. Францын вангууд улс орноо бүрэн нэгтгэхийн тулд XII зуунаас Английн мэдэлд орсон Аквитанийг эргүүлэн авахаар болов. Английн ван ч эх газрын баян хот бүхий түшиц газраа алдахыг хүссэнгүй. Ийнхүү 1337 онд дайн эхлэв. Англичууд 1360 он гэхэд Францын газар нутгийн 1/3-ыг эзлэн авчээ. Европ даяар “хар тахал” дэгдэж, дайн завсарлав. 1369 онд дайн дахин сэргэж, францчууд Кале-гаас бусад нутгаа чөлөөлөөд байсан ч дотоодын тэмцэл Францыг сөхрүүлжээ. Англитай холбоо тогтоосон Бургундын феодалууд Парисыг эзлэн вангийн өмнөөс төр барив. Англичууд Францыг бүрмөсөн эзлэхийг санаархав. Францын ард түмэн эх орноо өмгөөлөн босож, Англи, бургундын урвагчдын эсрэг тэмцэв. Булаан эзлэгчдийн эсрэг ард түмнийг босгоход Орлеоны Жанна Д.Арк их үүрэг гүйцэтгэжээ.

1453 онд англичуудыг хөөн гаргаснаар 100 жилийн дайн францчуудын ялалтаар өндөрлөв.





Зураг 5.12. Жанна д Арк

**Тодруулга.** 18 настай, чин сүсэгт тариачин охин өөрийгөө Францыг аврах бурхны элч гэдэгт итгэжээ. Тэрээр төрөлх тосгоноо орхиж, англичуудын эсрэг тэмцэлд оролцох болов. Жанна д Арк “Ертөнцөд надаас өөр хэн ч ...Франц орныг аварч чадахгүй” гэжээ. Жанна “Бурхан англичуудыг эх орноос нь хөөн гаргахыг хүссэн” гэдгийг нотлохыг хүсэж байв. Ард түмэн “Охин тэнгэр” эх орноо аварна гэдэгт итгэжээ. Түүнийг Орлеонд хүрэлцэн ирэхэд дайсны эсрэг шийдвэрлэх тулалдаан эхэлж, түүний оролцоотойгоор Францын ихэнх газар нутгийг чөлөөлөв. Гэвч сурвалжтанууд Жаннагийн нэр хүнд өссөнд өширхөн охиныг дайснуудад барьж өгөв. Англичууд Жаннаг түүдэг галд шатаажээ.



Дараах асуултын дагуу ярилцаж баримт, эх сурвалжаас юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. 1347 онд эхэлсэн дайныг яагаад 100 жилийн дайн гэх болов? Дайны шалтгаан юу байсан бэ?
3. Жанна д Арк дайнд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?
4. 100 жилийн дайны үйл явцыг газар зүйн зурагт зааж тайлбарлаарай.
5. Францчууд дайнд ялж, нэгдмэл улс байгуулагдсаны ач холбогдлыг дүгнэн ярилцана уу.

ДҮГНЭЭРЭЙ

5.5

ҮНЭЛЭЭРЭЙ

Асуулт	Франц
Улс орныг ямар арга замаар нэгтгэв. - Энхийн замаар - Зэвсгийн хүчээр	
Улс орныг нэгтгэх үйл явцад ямар саад тохиолдов.	
Ван ямар эрх мэдэлтэй болов.	
Орон нутгийн эрх мэдлийг хэн барьж байв.	

## Англичууд эрх чөлөөгөө тунхагласан нь.


1066 онд Нормандын герцог Вильгельм Английг байлдан дагуулжээ. Тэрээр нийслэл Лондон хотыг эзлэн авч, Вильгельм Байлдан дагуулагч (1066-1087) нэрээр хаан ширээнд залрав. Вильгельм ван англи, саксын феодалуудаас газрыг нь булаан авч, рыцариуддаа өгчээ. Гэхдээ нэг дор том газар олгосонгүй, өөр өөр мужид газар хуваарилсан тул Англид Франц улсын адил гүн, герцогийн том эзэмшил бүрэлдсэнгүй. Шинэ эздэд байлдан дагуулсан улсаа номхотгон барихад хүчтэй хаант төр хэрэгтэй байв. Тийм учраас нормандын сурвалжтнууд Вильгельмд үнэнчийн тангараг өргөж, түүний харьяатууд болжээ. Ийнхүү Вильгельм ван Английн нэгдсэн вант улсын үндсийг тавьсан юм. Түүний үед төрийн удирдлага, хууль тогтоомжийг цэгцлэн арми, флот байгуулж, анхны газрын тооллого (“Аймшигт шүүхийн ном” гэдэг) явуулжээ.

Харин Вильгельм Байлдан дагуулагчийн ач нарын үед баронууд (том газрын эзэд) 20 гаруй жил самуун дэгдээж, бие даасан байдалтай болжээ. Дайн самуун тариачдын амьдралд хамгийн хүндээр тусч, зарим нь эзнээсээ оргон босож байлаа. Тэдний дунд дур зоргоор авирлагч эздийн эсрэг тэмцэгч Робин Гудын домог өргөн дэлгэрчээ. Гэхдээ Англид хаант засаг бэхжих илүү таатай нөхцөл байв. Английн ихэнх хот вангийн эзэмшилд байсан тул түүнийг дэмжиж байлаа. Ван хотынхон, рыцаруудад түшиглэн том эздийн эсэргүүцлийг даржээ.

II Генрих вангийн (1154-1189), шинэтгэлээр засаг төр ихэд бэхжив. Вангийн шүүх байгуулж, вангийн амбан захирагчдын эрх мэдлийг өсгөв. Баронууд аян дайнд явахын оронд “Бамбай мөнгө” мөнгө төлөхөөр заав. Гэвч түүний хүү Газаргүй Иоанн (1199-1216) баронуудын эсрэг бодлогоо чангатган газрыг нь хураан эх орноосоо хөөж байв. Тэрээр Францын II Филипп ванд ялагдаж, Франц дахь ихэнх эзэмшлээ алджээ. Түүний эсрэг баронууд, хотынхон, рыцариуд бослоо. Хаан босогчдын шаардлагыг хүлээн авч, гарын үсэг зуран тамгаа даржээ. Энэ шаардлагыг “Эрх чөлөөний их Харти” гэнэ. Хартид ван сүмийн сонгуульд оролцох эрхгүй болохыг зааж, мөн “вангийн зөвлөл”-ийн (баронууд орох болсон) шийдвэргүйгээр “бамбайн мөнгө”, аливаа төлбөр хураахыг хориглов.

Вангийн засгийг бэхжүүлэхийн тулд Эдуард (1272-1307) хааны үед давхаргын төлөөлөгчдийн хурлыг зарлан хуралдуулав. Хуралд сүмийн том лам нар, баронуудаас гадна рыцариуд, хотын төлөөлөгчид оролцох болжээ. Энэ хурлыг парламент (франц хэлний парле-ярих гэсэн үгнээс үүссэн) гэнэ. Английн парламент төрийн хэрэгт их үүрэгтэй байжээ. Төлөөлөгчдийн танхимын зөвшөөрөлгүйгээр нэг ч татвар хураах эрхгүй болов. Аажмаар парламент хууль тогтоох болжээ. Парламентад хүн амын янз бүрийн төлөөлөл үзэл бодлоо илэрхийлж, олон асуудлыг шийдвэрлэж байлаа.

Бүдүүвч 5.4. Английн парламент






Асуулт даалгаврыг гүйцэтгэж, мэдээллийн агуулгыг танилцуулна уу.

1. 1066 оноос хойш Англид яагаад вангийн засаг хүчирхэгжих болов.
2. Баронууд улс орныг нэгтгэхийн эсрэг яагаад тэмцсэн бэ?
3. II Генрихийн шинэтгэл ямар ач холбогдолтой байв.
4. Яагаад англичууд Эрх Чөлөөний Их Хартийг иргэний эрхийн баталгаа гэж үздэг вэ? Английн ван, албатуудын харилцааг хэрхэн зохицуулсан бэ?
5. Парламент гэж юу вэ? Английн парламентыг Францын Ерөнхий шаттай харьцуулан дүгнээрэй.

### Улаан ба цагаан сарнайн дайн.

100 жилийн дайнаас 2 жилийн дараа Англид Улаан ба Цагаан сарнайн дайн дэгдэв. Төр барьж буй Пантагенетийн угсааны хоёр бүл засгийн эрхийн төлөө зэвсэглэн тэмцэлджээ. Ланкастерын холын садан Генрих Тюдор энэ тэмцэлд оролцон сүүлчийн тулалдаанд ялалт байгууллаа. Тэрээр VII Генрих нэрээр хаан ширээнд суув. VII Генрих Тюдор Йоркийн гүнжтэй гэрлэн сүлдэндээ улаан ба цагаан сарнайн нэгтгэжээ. Түүний үед зэвсэглэсэн цэрэгтэй байхыг феодалуудад хориглож, эсэргүүцсэн нэгний цайзыг эвдлэн нурааж, газрыг нь хураажээ. Ийнхүү Англид төвлөрсөн улс байгуулагдлаа.

Бүдүүвч 5.5. Пантагенетийн угсаа



1. Улаан ба цагаан сарнайн дайн хэдэн онд эхэлсэн бэ? Дайн хэрхэн өндөрлөсөн бэ?
2. Ямар угсаа засгийн эрх барих болов?


ДҮГНЭЭРЭЙ

5.6

ҮНЭЛЭЭРЭЙ

Асуулт	Англи	Франц
Улс орныг ямар арга замаар нэгтгэв. - Энхийн замаар - Зэвсгийн хүчээр		
Улс орныг нэгтгэх үйл явцад ямар саад тохиолдов.		
Ван ямар эрх мэдэлтэй болов.		
Орон нутгийн эрх мэдлийг хэн барьж байв.		

## Пиренейн хойг: маврууд ба реконкистууд



711-718 онд Пиренейн хойгийг арабууд (мавр-баруун арабууд) байлдан дагуулжээ. Зөвхөн хойгийн хойд хэсэгт орших Астур хэмээх уулын муж тусгаар тогтнолоо хадгалан үлдэв. Арабын байлдан дагууллагаар хүн ам нь хүнд бэрх мөлжлөг, шашны хавчлагад өртсөн ч эдийн засаг, соёл цэцэглэн хөгжжээ. Испанид цагаан будаа, чихрийн нишинги, анар жимсний мод, дал мод, торгоны ялма мод зэрэг газар тариалангийн шинэ соёл нэвтрэв. Хонины аж ахуй өндөр хөгжжээ. Төмөрлөг олборлох, боловсруулах, шавар сав суулга, торгон даавуу, арьсан эдлэл зэрэг гар урлалын салбар амжилттай хөгжив. Толедо хотод X зуунд цаас үйлдвэрлэж эхэлжээ. Хотууд цэцэглэн хөгжиж, 400 гаруйд хүрчээ. Арабын улсын нийслэл Кордова хот худалдаа гар урлал, соёлын томоохон төв байлаа. Европчууд арабын Кордовын их сургуульд суралцаж байв. Испанид арабын уран барилгын гайхамшигт дурсгалууд өнөө хүртэл уламжлан ирсэн байдаг.

**Реконкистуудын хөдөлгөөн.** Маврууд олон зуун жил хойгийн загалмайн шашинт хүн амд ноёрхлоо тогтоосон ч нэгдмэл угсаатан, шашин шүтлэг бүрдсэнгүй. Загалмайтнуудаас гадна Пиренейн хойгт Ромын үеэс еврейчүүд олноороо амьдарч байв.

Испанийн загалмайтнууд мавруудаас чөлөөлөгдөх хөдөлгөөнд нэгдэв. Уг хөдөлгөөн 800 орчим жил үргэлжилжээ. Феодалууд эзэмшил нутгаа тэлэх, эрх мэдэлд хүрэх, тариачид газар, хувийн эрх чөлөөгөө олж авах, хотынхон өөрийн удирдлага, эрхийн төлөө, сүм хийд нэр нөлөөгөө тэлэх зорилготой байв. Реконкистуудын хөдөлгөөний үеэр Кастил, Арагоны вант улс, Пиренейн ууланд Наварра, Португалийн гүнт улсууд байгуулагдав. 1479 онд Кастил, Арагоны вант улсууд нэгдэж, Испанийн вант улс байгуулагджээ. 1492 онд Испанийн Фердинанд ван мавруудын сүүлчийн түшиц газар болох Гранадаг буулган авлаа. Шашин шүтлэгтээ үнэнч үлдсэн еврей, арабуудыг хөөн гаргасан нь улс орны хөгжилд сөргөөр нөлөөлсөн байдаг.

### ТАЙЛБАР

Реконкистуудын хөдөлгөөн - Арабуудаас газар нутгаа чөлөөлөх Испанийн загалмайтнуудын хөдөлгөөн

Зураг 5.13. Реконкистуудын хөдөлгөөн



Асуулт, даалгаврыг гүйцэтгэж уншсан мэдээллийн агуулгыг танилцуулаарай.

1. Реконкистуудын хөдөлгөөнд Пиренейн хойгийн хүн амын ямар давхаргууд оролцсон бэ?
2. Газар зүйн зургийн мэдээллийг уншина уу. Пиренейн хойгт загалмайтны ямар улсууд байгуулагдсан бэ?
3. Реконкистуудын хөдөлгөөн хэрхэн өрнөж, ямар үр дүнд хүрсэн бэ?
4. Араб, еврейчүүдийг хөөн гаргасан нь улс орны хөгжилд яагаад сөрөг үр дагавар авчирсан бэ?

ДҮГНЭЭРЭЙ

5.7

ҮНЭЛЭЭРЭЙ

Харьцуулах асуулт	VIII зууны дунд үе	XV зууны сүүлч
Нутаглаж байсан ард түмэн	Иберийчүүд, баруун готууд, баск, араб, бербер, еврей	
Шашин	Загалмайтны шашин, лалын шашин, иудейн шашин	
Улсууд	Кордовын эмирт улс, Астур, баскуудын нутаг	

## 5. БАРУУН ЕВРОПЫН СОЁЛ (XI-XV ЗУУН)

Түрүү Дундад зууны “Харанхуй зуун”-аас хойш Баруун Европ соёлын хөгжилдөө огцом үсрэлт хийсэн юм. Өмнө нь хүмүүст хэрэггүй байсан зүйл өнөө үнэ цэнтэй, амин чухал болжээ.



Яагаад ийм өөрчлөлт гарсан бэ? Таамаглал дэвшүүлээрэй.



**Баруун Европын соёл хөгжсөн нь.** Түрүү дундад зуунд баруун Европын соёл уналтад орсон юм. Хотын театр, задгай театр, циркүүд эл хуль болжээ. Хүмүүс энэ хүнд бэрх цагт амьд үлдэх нь л чухал байсан тул үзвэр орхигдсон биз ээ. Дундад зууны эхээр Баруун Европын хаад ч уншиж, бичиж чаддаггүй байлаа. Зөвхөн загалмайтны сүм л соёлын өвийг хадгалан үлджээ. Сүмийн тахилч, лам, хар лам нар хамгийн боловсролтой хүмүүс байв. Учир нь латин, грек хэл мэдэхгүйгээр Библийг уншиж, ном айлдаж чадахгүй билээ. Одон орны мэдлэггүйгээр шашны баярыг нарийн тодорхойлж, уран барилгын мэдлэггүйгээр сүм барьж чадахгүй байв. Ийм учраас сүм эртний Грек-Ромын мэдлэгийг нандигнан хадгалж байсан юм.

X-XIII зуунд боловсрол, шинжлэх ухааныг сонирхон судлах болов. Соёлын гол төв нь хот болсон бөгөөд гар урлал, худалдааны хөгжилд шинэ мэдлэг хэрэгтэй байлаа. Хот төдийгүй хаант төрд боловсролтой хүмүүс хэрэгтэй болжээ. Хотынхон худалдааны хэргээ хөтлөн явуулах, хотыг зохион байгуулах, эрхээ хамгаалах хэрэгтэй байв. Хаант төрд мэргэшсэн шүүгч, хуульчид нэн чухал байсан юм.

### Их Сургууль.

Унших, бичих, тоолох чадвар нь сайн хуульч, эмч, номлогч болоход хангалтгүй байлаа. Ийм учраас 1088 онд Европт анхны их сургуулиуд байгуулагджээ. Тэдгээрээс хамгийн алдартай нь Италийн Болоньи хотын их сургууль байв. 1150 онд энэ сургуульд олон орны 10000 оюутан суралцаж байсан юм. Их сургуулийн хичээл латин хэлээр явагддаг байсан тул олон орны хүмүүс суралцаж болдог байжээ. Хичээл дээр багш номын хэсгээс уншиж, ойлгомжгүй хэсгийг тайлбарлаж өгнө, оюутнууд сонсож, лекц (латин хэлний уншлага гэсэн үг) бичнэ. Лекцийн зэрэгцээ маргаан өрнүүлнэ. Урьдчилан дэвшүүлсэн асуудлын дагуу марган мэтгэлцэнэ.



Зураг. 5.14. Их сургуулийн хичээл

Зураг 5.15. Их сургуулиуд



**Шинжлэх ухааны мэдлэг.** XII-XIII зуунд их сургуулийн багш нарын дунд үнэнийг нотлох аргын тухай маргаан өрнөжээ. Нэг хэсэг нь үнэнийг нотолоход Библи, сүмийн номлолд тулгуурлах ёстой гэж үзэж байв. Харин нөгөө нэг нь өөрийн мэдлэг, оюун ухаан, туршлагад үндэслэх хэрэгтэй гэж үзжээ. Профессор Рожер Бэкон бол XIII зууны нэрт эрдэмтэн байв. Тэрээр Парис, Оксфордын их сургуулиудад багшилж байв. Рожер Бэкон шавь нартаа мэдлэгийг туршлагаар батлах ёстой хэмээн сургаж, өөрөө олон нээлт хийжээ.

XI зуунаас европчуудын газар зүйн төсөөлөл, бусад ард түмний талаарх мэдлэг өргөжин тэлэв. XIII зуунд Венецийн худалдаачин Марко Поло 15 жил Төв Ази, Хятадаар аялжээ. Тэрээр «Орчлонгийн элдэв сонин» хэмээх бүтээлдээ Дорно дахины олон ард түмний амьдрал, зан заншлын тухай өгүүлсэн юм.

**Уран зохиол.** Хөгжингүй дундад зуунд Европт олон авьяаслаг зохиолч төрж бүтээлээ туурвижээ. Дундад зууны хамгийн алдартай яруу найрагч бол Данте Алигерье (1265-1321) юм. Дантегийн уран бүтээлийн оргил нь *Тэнгэрлэг туульс* зохиол мөн. Эл зохиол *Там, Ариутгах орон, Энхжин* гэсэн 3 хэсэг, 100 дууллаас бүтнэ. Данте хойд насны тухай шашны домгийг ашиглан цаг үеийнхээ хэрэг явдал, бодит хүмүүс, улс төрийн чухал асуудлыг хурцаар дүрслэн үзүүлжээ. Тэрээр тамын ертөнцөд гэмтнүүд, мөнгө хүүлэгч, шашны мяндаг хэргэм дамлагч, луйварчин, Дантегийн улс төрийн дайсан, урвагчид урд насандаа үйлдсэн гэм нүгэлдээ дүйцэх ял зэм эдэлж шаналан зовж байна. Ариутгах оронд хүмүүс урьдын хилэнцэт үйлдлээсээ цэвэршин салж, буянт үйлс, шударга явдалтнууд Энхжингийн орноо жаргаж байдгаар дүрсэлжээ.

**Уран барилга.** Хөгжингүй дундад зуунд Европын дархад уран барилгад олон шинэ зүйл нэвтрүүлжээ. Эхэндээ уран барилгад роман хийцийн шашны байгууламж голлож байв. Ийм барилга эртний Ромын уран барилгын олон шинжийг өвлөн авсан тул роман хийц гэнэ.

XIII-XVI зуунд Европт уран барилгын гот хийц бий болжээ. Роман хийцийн барилгад хэвтээ нүсэр байгууламж голлодог бол гот хийцийн барилгад тэнгэр өөд тэмүүлэх босоо зохиомж голлоно. Сүмийн гадна, дотор талыг Бурхан, эх дагина Мария, сахиусан тэнгэр, гэгээнтэн, хамба лам, хаадын хөшөө, баримал, товгор сийлбэрээр чимэглэжээ.

Зураг 5.16. Роман хийцийн сүм



Зураг 5.17. Гот хийцийн сүм




Номын чимэглэл зураг шинэ түвшинд гарав. Номын чимэглэл зургийн шилдэг бүтээл бол XV зуунд Францын ах дүү Лимбургийн бүтээсэн “Герцог Беррийскийн хуанли” юм. Ажил төрлөө хийж, амарч буй хүмүүсийг байгалийн дэвсгэр дээр хурц өнгөөр, гэрэл сүүдрийн зохимжит харьцаатайгаар дүрсэлсэн нь номын чимэглэл зурагт нээлт болсон юм.



Дараах асуултын дагуу ярилцаж, газарзүйн зураг мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй

1. Европын анхны их сургуулиудыг газарзүйн зургаас олж заана уу.
2. Дундад зууны их сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг харуулсан бүдүүвч зохионо уу.
3. Их сургуулийн хичээл хэрхэн явагдаж байна вэ? Зурагт хичээлийг хэрхэн зохион байгуулж байгааг тайлбарлана уу?
4. Европын аль ч орны хүн хэлний мэдлэг шаардагдахгүйгээр эдгээр их сургуульд сурч болдог байжээ. Яагаад?
5. Дантегийн бүтээлд ертөнцийг хэрхэн дүрсэлсэн байна вэ? Зурагт тайлбарлаарай.





6. 5.16, 5.17 дугаар зургийг ашиглан уран барилгын роман, гот хийцийн гол шинжүүдийг ялгана уу?
- Шовх оройтой цамхаг
  - Хүчирхэг хана
  - Гоёмсог нарийн хийцтэй багана
  - Нуман хүнхэр цонх
  - Шовх нарийн цонх
  - Олон тооны цамхаг, хурц орой, цүнхэл,
  - Урагш илүү гарсан хана
7. Хөгжингүй дундад зуунд номын чимэглэл зурагт ямар өөрчлөлт гарсан байна вэ? Сурах бичгийн 36 дугаар талын номын чимэглэл зурагтай харьцуулан дүгнэлт хийгээрэй.

Зураг 5.18. Ах дүү Лимбург “Герцог Беррийскийн хуанли” 5-р сар.

ДҮГНЭЭРЭЙ

5.8

ҮНЭЛЭЭРЭЙ

Харьцуулалт	V-XI зуун	XI-XV зуун
Ертөнцийн тухай төсөөлөл		
Боловсрол, шинжлэх ухаан		
Дүрслэх урлаг		
Уран зохиол		

## 6. ВИЗАНТИЙН ЭЗЭНТ УЛСЫН МӨХӨЛ

1. 1439 онд Флоренцийн сүмийн чуулган дээр загалмайтны шашны сүм хийдүүд нэгдэх хэлэлцээр хийжээ. Үнэн алдартнууд католик шашны номлол, Ромын пап ламын дээд эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, үүний хамт үнэн алдартны сүмийн зан үйлийг хадгалан үлдэв. Ромын пап Византид аюул учруулж буй түрэг-османчуудын эсрэг Баруун Европын загалмайтны шашинт улс орнуудыг нэгтгэх, загалмайтны дайныг эхлүүлэх амлалт өгчээ.
2. XIV-XV зуунд Визант тэргүүтэй үнэн алдартны шашинт улсууд Османы эзэнт улсад эзлэгджээ.



Дээрх мэдээг харьцуулаарай.

Яагаад үнэн алдартны шашинт улс орнууд католик шашинт орнуудтай нэгдэн, турк-османчуудын түрэмгийллийг сөрөн зогсож чадсангүй вэ?

1261 онд загалмайтнуудыг Константинополиос дөнгөж хөөж, сэргэлт авсан Византийн эзэнт гүрэнд дорно зүгээс өөр нэг аюул тулгарчээ. XIII зуунд Бага Азид нүүдэлчин түрэгүүд олноор шилжин суурьшжээ. Тэд Төв Азиас монголчуудын довтолгооноос дүрвэн дайжсан ажээ. Визант, сельжукийн хилээр суурьшсан нүүдэлчид жижиг боловч хүчирхэг хант улс байгуулж, өөр зуураа болон византчуудтай тэмцэлдэх болжээ. Түрэгийн эмирт улсуудаас Османы угсааныхны улс хүчирхэгжив. Тэд Бага Азийн лалын улсуудыг нэгтгээд зогсохгүй, Европт довтолж, Балканы улсуудыг ээлж дараалан залгих болов. Турк-османчууд Бага Ази, Балкан дахь Византийн эзэмшлийг бүрэн эзлэв. Византийн василевст Пелопоннес дахь багахан эзэмшил, Константинополь хот л үлджээ. 1369 онд туркууд Косовогийн талын тулалдаанд сербүүдийг ялж, улмаар Болгарын хаант улсыг эзлэв. 1402 онд Османы султан Баязид Дундад Азиас ирсэн Доголон Төмөрт Анкарагийн дэргэд ялагдал хүлээснээр хотын сүйрэл хагас зуун жилээр хойшилсон юм. Анкарагийн сүйрлийн дараа туркууд богино хугацаанд сэргэв. Османы султан II Мехмедийн тушаалаар 1453 оны 4 сарын 22-нд Алтан эврийн буланд османы усан онгоц дөхөж иржээ. 5 сарын 29-нд туркууд хотыг эзэлж, тонон дээрэмдэв. Визант мөхсөнөөр үнэн алдартны шашны төв оршин тогтнохоо болив. Католик сүм хийд Европын хувь заяанд гол үүрэг гүйцэтгэх нь тодорхой болжээ. Зүүн-өмнөд Европт Османы султант улс хэмээх туркийн хүчирхэг улс байгуулагдлаа.



Зураг 5.19. Константинополийг бүсэлсэн нь.



Асуулт даалгаврыг гүйцэтгэж, уншсан мэдээллийн агуулгыг танилцуулаарай.

1. Мэдээллийг уншиж "Турк-османчууд Византийн эзэнт гүрнийг мөхөөсөн нь" он дарааллын хүснэгт зохиогоорой.
2. Асуултын дагуу ярилцаарай.
  - а. Загалмайтнуудын эсрэг аян дайнд Турк-османчууд амжилт олсны учир юу вэ?
  - б. Яагаад Европын улсууд Византид тусламж үзүүлэх амлалтаа биелүүлээгүй вэ?

### Сурвалжийн мэдээ

«...Дайны ялалт (5 сарын 29-нд ерөнхий дайралтын үеэр) туркуудын талд шилжив... Хананд шат тавин авирах дайснуудтай тулгарсан ромей, латинчууд нэг бол тэдэнд цавчуулан унаж, үгүй бол нүдээ анин хананаас унаж, бие нь бяцарч байгаа аймшигт дүр зургийг харж болох байв. Туркууд одоо ямар ч саадгүйгээр хананд шатаа босгож, нисэж буй бүргэд мэт хана руу авирч эхлэв ...

Нэг ромейн эсрэг хорин эрэлхэг турк тулалдаж... байснаас гадна ромей нар тийм ч эрэлхэг цэргүүд биш байв...

Тэд (туркууд) хотод орж, хаалганаас ордон хүрэх зуур замдаа тааралдсан, зугатаж байгаа хэнийг ч болов нэг бүрчлэн хядав. Ийнхүү тэд 2000 цэрэг эрсийг хяджээ... Тэгээд бүх эр, эм хүн, лам, гэлэнмаа нар орон гэрээ орхин хүүхдээ тэврэн Их сүм рүү гүйдэв. Гэвч бүгд Их сүмд зугатан орогнож чадах уу?... Ийнхүү үлэмж сүм тэр дороо л хүмүүсээр дүүрэв.

Туркууд тал тал тийш гүйдэн алж хядан, заримыг нь олзлон өглөө болоод нэг цаг ч өнгөрөөгүй байхад сүмд тулж ирцгээлээ, тэд хаалгыг цоожилсныг хараад сүхээр эвдэв. Сэлмээр зэвсэглэсэн цэргүүд дотогшоо орж, олон хүнтэй тулгарч, хүн бүр өөрийн олзны хүнийг олзлон авав...Эмэгтэйчүүдийг алчуураар нь холбожээ. Сүмээс олзны хүмүүс тасралтгүй цуварч, уйлж, гинших нь сонсогдоно. Сүмийн тухай би юу өгүүлж чадах билээ? Хэлсэн ч гаслан хашгирах биз ээ. Эсвэл хоолой минь арган хатаж, амьсгал давчдан амнаас минь үг ч гарахгүй биз ээ. Нэг хормын дотор нохос гэгээнтний хөргийг цавчин чимэглэл, зүүлт, бугуйвч, ёслолын хувцсыг нь дээрэмдэв. Гайхамшигт цөгцийг нэг бол эвдлэн үгүй бол өвөрлөн ариун идээний үнэт сав суулга, алт, мөнгөн эдлэл зэрэг авч болох бүхнийг тэр даруй дээрэмдэн сүмийг хоослов. (Михаил Дука (XV зуун) – Византийн түүхч. Туркууд Константинополийг эзэлсэн нь.)



1. Эх сурвалжид Константинополийн мөхлийн тухай юу өгүүлсэн бэ?
2. Булаан эзлэгчдийн авир үйлдлийг зохиогч хэрхэн тодорхойлсон бэ?

### ДҮГНЭЭРЭЙ

### 5.9 ҮНЭЛЭЭРЭЙ

Византийн эзэнт улс хэдэн жил оршин тогтносон бэ?	VI зуун, XIII зууны эхэн, XV зуунд Византийн эзэнт улсын газар нутгийн бүрэлдэхүүнд гарсан өөрчлөлтийг харьцуулна уу.	Византийн эзэнт улс хүн төрөлхтний шашин, соёлын хөгжилд ямар хувь нэмэр оруулсан бэ?	Византийн эзэнт улс мөхсөний дараа Үнэн алдартны шашин, соёлын төв хаашаа шилжсэн бол?
Он тооллын шугамд тэмдэглээрэй.	Газар зүйн зурагт зааж тайлбарлаарай	Дүгнэн ярилцана уу.	

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

- Францын давхаргын төлөөлөгчдийн хурлыг:  
а. Ерөнхий штат  
б. Парламент  
в. рейхстаг  
г. Вангийн Зөвлөл
- Герцог, бароны харилцаанд барон нь:  
а. Хараат  
б. Эзэн  
в. Рыцарь
- Загалмайтны аян дайны шалтгаан нь:  
а. Олз, баялагт шунасан  
б. Христийн Ариун газрын чөлөөлөх  
в. Византчуудад туслах  
г. Католик сүм хийд нөлөөгөө бэхжүүлэх
- Инквизици гэдэг нь:  
а. Тэрслүү үзэлтнүүдтэй тэмцэх сүмийн тусгай шүүх  
б. Тангарагтны шүүх  
в. Феодал эзний шүүх  
г. Вангийн шүүх
- Эдлэхүүний аж ахуй гэдэг нь:  
а. Шаардлагатай бүх зүйлээ худалдаж, солилцож бус үйлдвэрлэдэг аж ахуй  
б. Бүтээгдэхүүнийг арилжих зорилгоор үйлдвэрлэдэг аж ахуй  
в. Хараат тариачдын хөдөлмөрийг ашигладаг аж ахуй  
г. Тариачид эзэндээ алба гүйцэтгэдэг аж ахуй
- Анхны загалмайтны аян дайн:  
а. 1202-1204 он  
б. 1096-1099 он  
в. 1073-1085 он  
г. 1261 он
- Загалмайтны аян дайны үр дагавар:  
а. Европ, Дорно дахины худалдааны харилцаа бэхэжсэн.  
б. Византийн эзэнт улс мөхсөн.  
в. Лалын шашинт Дорно дахин, Загалмайн шашинт Европын зөрчил улам гүнзгийрсэн.  
г. Бүгд зөв
- Византийн эзэнт улс хэдэн онд турк-османчуудын довтолгоонд мөхсөн бэ?  
а. 1204 он  
б. 1096 он  
в. 1453 он  
г. 1389 он
- 100 жилийн дайны үр дагавар нь:  
а. Англи Франц дахь бүх эзэмшлээ алдсан.  
б. Франц дахь төвлөрөх үйл явц түргэссэн.  
в. Худалдаа уналтад орж, хойд Европын худалдааны зам хоосров.  
г. Англи хэд хэдэн улс болж задрав.
- Дараах үйл явдал хэзээ болсон бэ? Онуудыг нэрлэж, хэддүгээр зуун, мянганд болсныг тооцоолоорой.  
а. Нормандын герцогууд Английг байлдан дагуулав.....  
б. Загалмайтны сүм хийд үнэн алдартны, католик гэж хуваагдав.....  
в. Анхны загалмайтны аян дайн..... болов.  
г. Византийн эзэнт улс IV зуунд аян дайны дараа сэргээн байгуулагдав.
- Дараах үйл явдлын шалтгааныг нэрлэнэ үү.  
а. XIII зууны эхээр Английн баронууд Газаргүй Иоанны эсрэг бослого гаргасан  
б. XII зууны дунд үед Францын зарим газар нутаг Английн вангийн мэдэлд байв.  
в. Ромын пап Европын рыцариудыг Испанийн загалмайтнуудад туслахыг уриалав.
- Хотуудын нэршлийн гарал үүслийг тайлбарлана уу. Сен Жермен, Гамбург, Оксфорд хотуудын нэрнээс хаана үүссэнийг нь хэрхэн тайлбарлаж болох вэ?
- Тухайн ойлголтод холбогдох үгсийг ялгана уу. “Загалмайтны дайн” гэсэн үгтэй шууд холбоо бүхий үгсийг олж нэрлэнэ үү.  
*рыцарь, зэвсэг, Ойрх Дорнод, түрэг, лал, султан, феодал.*

## АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

### МОНГОЛЫН ТҮҮХ

1. Д.Анхбаяр. Монголын Эл хаант улс. УБ., 2006
2. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988
3. Жиованни Дель Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988
4. А.Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I. УБ., 2006
5. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987
6. Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал. УБ., 1999
7. Монгол улсын түүх. Дэд боть. УБ., 2003
8. Монгол улсын зоос, мөнгөн тэмдэгт. УБ., 2005
9. Монгол-Татарын бүрэн тэмдэглэл. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. УБ., 2014
10. Монголын нууц товчоо. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. УБ., 2011
11. Ж.Ганболд, Д.Наран, Ц.Мөнхцэцэг, А.Пунсаг. Монголын Юань улс. УБ., 2006
12. С.Цолмон. Монголын Алтан ордны улс. УБ., 2006
13. Рашид-ад-Дин. Судрын чуулган. I. УБ., 2002
14. Ц.Энхчимэг. Монголын Цагадайн улс. УБ., 2006
15. Юань улсын судар. Үндэсний номын сан

### ДЭЛХИЙН ТҮҮХ

1. О.В.Арасланова.,К.А. Соловьев. Универсальные поурочные разработки по истории Средних веков. 6 класс. М., 2013
2. Х.Баярмаа., Түүхийн сургалтын зарим асуудал. УБ., 2013
3. Х.Баярмаа., Д.Идэр. Дундад зууны түүх. УБ., 2018
4. М.Бойцов., Р Шукуров. История средних веков. М., 2010
5. Воынец А.О., О.В.Забельникова. История средних веков.V-XIII вв. Тестовые и разноуровневые задания. М., 2011
6. Баясах Ж. Хятадын товч түүх.УБ., 2003
7. У.Гонгоржав. Дундад зууны түүхийн дээж бичиг. Уб., 2005
8. Гюнтер Штөкл. Оросын түүх. УБ., 2011
9. А.А.Данилов., Л.Г.Косулина История России. С древнейших времен до конца XVI века. М., 2009



10. Дэлхий дахины түүх. УБ., I боть. 2002
11. Дэлхийн түүх УБ. 2010
12. Дэлхийн түүхийг эргүүлсэн 100 эрхэм. УБ., 2013.
13. Майкл Х.Харт. Хүн төрөлхтний түүхийн аугаа хүмүүс. УБ., 2007
14. Өлгийсайхан Д. Дэлхийн 100 гайхамшиг. УБ., 2004
15. С.Г. Смирнов. Задачник по истории средних веков. М., 1995

### ЦАХИМ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. <http://mn.wikipedia.org>
2. <http://pish.ru>
3. <http://his.1september.ru/>
4. <http://lesson.history.narod.ru>
5. [Pedagogic.ru/books/item/f00/s00/z0000030/st003/shtml](http://Pedagogic.ru/books/item/f00/s00/z0000030/st003/shtml)
6. <http://karty.narod.ru/claim/ru/ru.html>
7. [www.myshared.ru/slide/989370/](http://www.myshared.ru/slide/989370/)
8. [www.mongoleducation.com](http://www.mongoleducation.com)
9. [www.4teachers.com/](http://www.4teachers.com/)
10. [www.google.mn](http://www.google.mn)
11. [www.eidos.ru](http://www.eidos.ru)
12. [www.teacher.syktsu.ru](http://www.teacher.syktsu.ru)
13. [www.urok.su](http://www.urok.su)
14. [www.1september.ru](http://www.1september.ru)
15. [www.festival.1september.ru](http://www.festival.1september.ru)